Төв аймгийн Баян сумын уугуул, Монгол Улсын Манлай уяач Миеэгомбын Энхболдын зээрд халзан морь "Дүнжингарав-2012" төвийн бүсийн хаврын уралдаанд аман хүзүү, Ардын хувьсгалын 91 жил, Үндэсний их баяр наадамд айргийн дөрөв, Сүхбаатар аймгийн 70 жил, Зүүн бүсийн уралдааны айргийн гурав, "Дүнжингарав-2013" төвийн бүсийн хаврын уралдаанд аман хүзүү, Монгол Улсад Адууны яам байгуулсны 750 жил, дэлхийн дээд амжилт Гиннесст бүртгүүлэх 4249 хурдан морины уралдааны төвийн бүсийн айргийн дөрөвт тус тус хурдлаад байна.

ТҮМЭН ЭХ

Монгол ардын уртын дуу

Зээ, Эрдэнэт хүн энэ биеийг олоод
Этгээд буруу үйлсээс зайлуулж
Эцэс энэ хойд хоёр ч хэргийг
Сайтар бүтээн сэдэлтэй
- Шажин номын тулд амин зүрх
- Сайхан төрийн тулд ахуй чинээгээр
- Сайтар шамдан зүтгээд
- Олон түмний эх тэр болмуй

Зээ, Жагсаал олон агтныхаа уяан дотроос
Улмаа жагсаахуйдаа илүү зохистой
Үсэргэхүйн цагт үзэмжтэй
Тэр валай морь бий
- Татаад байхын цагт дахин тэмүүлээд
- Тавиад ирэхийн цагт
- Ганцаар тэргүүлээд тасархай сайхан
- Олон түмний эх тэр болмуй

Зээ, Үзэхүйд ламынхаа гэгээнийг үзэж
Сонсохуйд ончтой номуудыг сонсож
Ер бас сэтгэлдээ сайтар ханасаар
Ёстойн хүсэл нийлбэй
- Арван цагаан буянаар цагийг нөгчөөж
- Амар мэндийн жаргалангаар
- Хуран чуулаад үүнээс хойш
- Улам өрнөхүйн билиг болмуй

Зээ, Эрхмийн дээд лам юунаа адисаараа
Эзэн дээдсийн төрийг түшиж
Элдэв сайхан таавар байдал үелж
Цэнгэн жаргая
- Эртийн цагаан буянаа бүрэн учраад
- Эсэргэн мэндийн жаргалаар
- Цагийг нөгчөөгөөд үүнээс хойш
- Өнөд бат цэнгэн жаргая

http://enkhboldm.parliament.mn Enkhboldm@parliament.mn /M.Enkhbold /MEnkhbold

МОНГОЛ ТҮШЭЭ

2015 он

М.ЭНХБОЛД:
БУСДАД БОДОХ, ЭРГЭЦҮҮЛЭХ БОЛОМЖ, ЦАГ ХУГАЦАА ӨГДӨГ

НҮҮДЭЛЧДИЙН ХОТЫН ИХ НҮҮДЭЛ

ТӨВ НУТГИЙН ДОМОГ ТҮҮХЭЭС...

XVII ЖАРНЫ “СОГТУУРУУЛАГЧ” ХЭМЭЭХ МОДОН ХОНЬ ЖИЛИЙН ЦАГ УЛИРЛЫН БИЧИГ
(2015-2016 ОН)

МАНАЙ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

(2012 онтой харьцуулснаар)

№	ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	ХЭМЖИХ НЭГЖ	2012 ОН	2014 ОНЫ ХУЛЭЭГДЭЖ БАЙГАА ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ	Хувь	12.4%	6.9%
2	БАНКНЫ ХУГАЦАА ХЭТЭРСЭН ЗЭЭЛ	Тэрбум төгрөг	110.9	269.5
3	ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ	Тэрбум төгрөг	294.5	625.7
4	УЛСЫН ТӨСВИЙН ОРЛОГЫН ТАСАЛДАЛ	Тэрбум төгрөг	-	965.1
5	ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	Сая ам.доллар	4408.0	845.0
6	ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ	Тэрбум ам.доллар	4.1	1.6
7	АМ.ДОЛЛАРЫН ХАНШ (МОНГОЛ БАНКНЫ АЛБАН ХАНШ)	Төгрөг	1393	1883
8	МОНГОЛ УЛСЫН НИЙТ ӨР	Тэрбум ам.доллар	15.300	20.900
9	ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР	Тэрбум төгрөг	8900.0	14100.0
10	МОНГОЛ УЛСЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР (ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ДУНД)	Байр	95	107
11	МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛ	Зэрэглэл	B+ (B1)	B- (B2)
12	ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЗОГСООСОН ААН-ҮҮД	Тоо	-	53700
13	ТӨРИЙН АЛБАН ХААГЧ	Тоо	167769	180150

ТӨВ АЙМАГТ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2015 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

(сая төгрөгөөр)

№	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН НЭР	ЭХЛЭХ	ДУУСАХ	ТӨСӨВ ӨРТӨГ	2015 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ
1	ЭРДЭНЭ СУМЫН 320 ХҮҮХДИЙН СУРГУУЛИЙН БАРИЛГА	2012	2016	2668.7	531.4
2	ЭРДЭНЭСАНТ СУМЫН СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙРНЫ БАРИЛГА	2012	2015	1300.0	131.4
3	БАТСҮМБЭР СУМЫН СУРГУУЛИЙН 120 ХҮҮХДИЙН ДОТУУР БАЙРНЫ БАРИЛГА	2013	2016	1200.0	350.0
4	АЙМГИЙН ХӨГЖИМТ ДРАМЫН ТЕАТРЫН БАРИЛГА, 800 ХҮНИЙ СУУДАЛТАЙ (ЗУУНМОД СУМ)	2014	2016	9500.0	1650.0
5	БАЯНЦАГААН СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН БАРИЛГА	2015	2015	1000.0	1000.0
6	ЗУУНМОД СУМ, БАЯНХОШУУ БАГИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА	2014	2015	919.5	619.5
7	БОРНУУР, ЖАРГАЛАНТ, ПАРТИЗАН, БАТСҮМБЭР ЧИГЛЭЛИЙН 78.8 КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ	2010	2016	14772.1	1269.6
8	ЗУУНМОД СУМЫН 1.5 КМ АВТО ЗАМЫН ШИНЭЧЛЭЛИЙН АЖИЛ (БАЯНХОШУУ БАГ)	2013	2015	311.3	244.2
9	АВРАХ, ГАЛ УНТРААХ АНГИЙН БАРИЛГА (ЗУУНМОД СУМ)	2013	2015	1600.0	322.0

2015 онд Төв аймагт улсын төсвөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгт 9.8 тэрбум төгрөг,
Орон нутгийн хөгжлийн санд 4.6 тэрбум төгрөг хуваарилагдсан.

МЭНДЧИЛГЭЭ

Төрөлх нутгийн төв шударга, ажилч хичээнгүй хөдөлмөрч зон олон минь өвлийг өнтэй сайхан давж, тарган тавтай хаваржиж байна уу? Уугуул нутгийн ахан дүүс, азай буурлууд, хүүхэд нялхас, өргөн түмний минь сүлд хийморь сэргэн мандаж, айл бүхэн аз жаргалтай байхыг бэлгэдэн алд цэнхэр хадгаа дэлгэн сар шинийн мэндийг айлтган мэндчилье.

Миний бие Төв сайхан нутгийн иргэд олон түмэн та бүхнийхээ итгэл найдварыг тээж төрд төлөөлөх түшээдийн залгамж халаа болон хариуцлагатай албанд томилогдон ажиллаж байгаагаа ус нутгийн минь заяа өндөр, буурлуудын минь буян хишиг арвин, ард олны минь амжилт бүтээл арвин, алдар гавьяа, хийморь сүлд өөдөө байгаагийн илрэл хэмээн бишрэн хүндэтгэж явна.

Та бүхнийхээ оюуны мэлмийд өргөн барьж буй энэхүү сэтгүүлийн хуудсаар дамжуулан төрийн хариуцлагатай албанд хоёргүй сэтгэлээр зүтгэж, хийж гүйцэлдүүлсэн ажлаасаа товч танилцуулахын ялдамд, Төв сайхан нутгийнхаа түүхийн дурсгалт газрууд, онгон дагшин байгалийн онцлог, домог түүх, монгол зурхайн “Түвдэнпэлжээлин” хийдээс эрхлэн гаргадаг XVII жарны модон хонин жилийн цаг тооны бичгийг өдөр тутмын зам мөр, заяа төөргөө шинжиж, ажил амьдралаа төлөвлөн зохицуулахад тань тус дэм болоосой хэмээн хүргүүлж байна.

Хонин жилдээ хотол түмнээрээ хавартаа тавтай, зундаа дэлгэр сайхан, намартаа налгар, тарга хүч сайтай, тариа будаа арвин, өвөлдөө өнтэй элбэг хангалуун байж, хүн бүхэн ахан дүүсээрээ итгэлийн галтай, хийморийн цогтой төвшин амгалан амьдарч, тэнгэрийн энтэй мөрөөдөлтэй, уулын дайтай бүтээлтэй, уужим сэтгэлтэй, ухааны цартай, тэгш дүүрэн жаргалтай байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье!

Та бүхний мэлмий тунгалаг, өлмий бат орших болтугай.

Сар шинэдээ сайхан шинэлээрэй.

Монгол Улсын Их Хурлын дэд дарга, Монгол Ардын Намын дарга

Боржигон овогт Миеэгомбын ЭНХБОЛД

XVII жарны “Согтуруулагч” хэмээх модон хонь жилийн
хаврын тэргүүн шар бар сарын шинийн нэгэн

БИДНИЙ МЭДЭХГҮЙ **М.ЭНХБОЛД**



БЛИЦ

1. Найрын дуу: ***Халуун элгэн нутаг.***
2. Хэзээ ч уйдахгүй кино: ***Зэрэг нэмэхийн өмнө.***
3. Улс төрөөс шантрах үе байсан уу: ***Шантрах юм бол алив зүйлийг эхлүүлэх хэрэггүй. 1999 онд Нийслэлийн Засаг даргад нэр дэвшээд 36 хоноход янз бүрийн дайралт шахаанд ороод шантрах үе байсан. Залуу ч байж дээ.***
4. Цэргийн алба хаасан уу: ***Сонгины 019 дүгээр ангид хаасан. Их бууны Ж21 мэргэжлийн зэрэгтэй, дэслэгч цолтой.***
5. Хэдэн дээлтэй вэ: ***Наадмын комиссын даргаар 11 жил ажилласан. Төрийн ёслолын албанаас 7-р сарын 11-ний өглөө л ямар өнгийн дээл өмсөхийг хэлдэг байсан тул олон дээлтэй. Анх 1999 оны наадмаар гурван өнгөөр солонгорч харагддаг дээл хийлгэчихээд Төрийн ёслолын албанаас ямар ч өнгө хэлсэн энэ дээлээ өмсөнө дөө гэж бодож байж билээ.***
6. Удам угсаа: ***Манай дээдчүүл Их шавийнхан л даа. Лам ч байсан, төрийн харчуул ч байсан гэдэг.***
7. Идээний дээж нь: ***Нүүдэлчин монголчууд хэзээнээсээ идээний дээж сархад гэж хундэлдэг. Савнаасаа бусдыг дийлдэг хатуу ундааг баяр ёслоолоор соёлтой, тааруулж хэрэглэдэг болчихвол.***
8. Төв аймгийн нутгаар томилолтоор хэдэн км явсан бол: ***Барагцаалбал 40 гаруй мянган км.***

М.ЭНХБОЛД:
БУСДАД БОДОХ, ЭРГЭЦҮҮЛЭХ БОЛОМЖ, ЦАГ ХУГАЦАА ӨГДӨГ

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Монгол Улсын Ерөнхий сайд, Шадар сайдаар ажиллаж байсан, одоогийн УИХ-ын дэд дарга, МАН-ын дарга Миеэгомбын Энхболдтой ажлын тухай дуусашгүй яриа өрнүүлж болох ч энэ удаад хувь улстөрчийнх нь дотоод ертөнцөд нэвтрэхийг хичээлээ.

Таны харцыг харахаар хүүхэд байхдаа атаман байсан болов уу гэж өөрийн эрхгүй бодогддог?

Ёстой үгүй шүү. Их л томоотой хүүхэд байсан.

Тэр үед хүүхдүүдийн зан байдлын тодорхойлолт гээд их чухал тэмдэглэл хөтөлдөг байсан?

Улирал бүрээр нь гаргадаг. Миний тухай бичсэн ангийн багшийн зарим нэг тэмдэглэл, сурлагын дэвтэр одоо ч надад бий. Түүнийг эргүүлээд харж байхад дэггүйтлээ, сахилгагүй, үймүүллээ гэсэн зүйл байдаггүй. Ер нь л даруухан хүүхэд байсан даа.

Унаган хотын хүүхэд, гэхдээ хөдөөгийн амьдрал үзсэн?

Зуны амралт эхлэнгүүт аав ээж хоёр намайг хөдөө аваачиж орхино. Аавынхаа дүү нарынд наймдугаар сарын хорьд гартал амарна даа. Үхэр, тугал эргүүлэх, хонь, хурга ишиг хариулах гээд өөрийнхөө хэрэнд таарсан ажил хийгээд, томчуудын гар хөлийн үзүүрт гүйнэ. Аав минь Гомбынх гэдэг айлыг нэгэн үе толгойлж явсны хувьд ах дүү нартаа их нэр хүндтэй. Тиймээс ахын хүү гэдэг утгаараа би гэдэг хүн үеийнхэн дундаа арай л дээгүүр жаална. Нутгийн олон ч ялгаагүй, манай Миеэгийн хүү гээд сүйд. Зуны гурван сар хөдөө амрахдаа ер нь л хүндтэй зочин байдаг байсан шүү.

Хөдөө амарсан хүүхдүүдийн хамгийн бахдалтай дурсамж бол морь унаж сурах, уралдах шүү дээ?

Би тэгэхэд долоо, найман настай л байсан. Бас л зуны амралтаараа хөдөө оччихсон, үеийн хэдэн найзуудтайгаа, улаан морио уначихсан давхиж явлаа. Манай нутагт бүгээн зүсмийн адууг улаан гэж ярьдаг л даа. Нэг удаа машинтай уралдаад. Гүүглээд л, ташуурдаад л, ухасхийлээ. Түрүүлж байна шүү. Машинтай уралдаад, түрүүлчихлээ гээд бөөн баяр. Мориороо ч бахархаж байгаа гэж жигтэйхэн. Мориноосоо буугаад ойр тойрноо хараад, нүдэнд өртсөн хагалж жиргэчихсэн түлээний мод аваад мориныхоо хөлсийг хуссан. Угтаа бол жолооч нь “Хүүхдийн урмыг бодъё” гээд хаазаа жаахан хасчихсан байх л даа.

Нэг хэсэгтээ л томчууд өхөөрдөж ярьцгаасан биз?

Би энэ явдлыг мартчихаж. Гэтэл сүүлд аавын дүү Дугаржав эгч энэ тухай нэг сэтгүүлчид ярьсан байсан. Тэр нь Уяачдын холбооны ерөнхийлөгч болсон үетэй цаг хугацааны хувьд давхцаад “Хүүхэд байхын хурдан моринд хорхойтой байжээ” гэдэг яриа өрнөсөн хэрэг л дээ.

Бид морины зүсийг ихэд бэлгэшээдэг ард түмэн. Танд ямар зүс ээлтэй байна?

Хул, хээр, зээрд өнгө надад ээлтэй байх шиг санагддаг. Жаахан хүүхэд байхад ах минь надад хар голтой хул морь бэлэглэж, би олон ч жил унасан. Хожим улсын наадамд дажгүй давхисан, бүсийн наадамд айрагдаж байсан гялгар хул морьтой боллоо. Өвгөрч яваа хээр азарга минь улсын наадамд 2 удаа, бүсийн наадамд 1 аман хүзүүдсэн. Зээрд зүсмийн адуу бас сайхан. Зээрд халзан морь минь улсын наадамд 1 айрагдаж, бүсийн наадамд 4 айрагдчихаад байна. Дахиад ч олон удаа цулбуур өргүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Монгол хүн бүрт морь унах, эдлэх ухаан хар багаас л суусан бол тэр чигтээ үүрд хадгалагдан үлддэг юм шиг ээ. Та хурдны морь унаж байсан уу?

Би ч хурдан моринд хүнддээд унаж байгаагүй. Унах юмсан гэсэн хүсэл бол их байсан.

Таныг хоёр ээжийн мөөм хөхөж өссөн гэдэг. Тэгээд л хэзээний том, биерхүү болж моринд хүндэддэг байсан байлгүй?

П.Жасрай ах хааяадаа "Энхболд золиг түрүүлж хөхсөөр байгаа хүү минь ийм жижигхэн болчихсон юм" гэж надаар наргиа хийдэг байж билээ. Хожим Ерөнхий сайд болсон П.Жасрай гуайнх манайхтай айл саахалт, гэр бүлээрээ эрдэмтэн доктор, шинжлэх ухааны хүмүүс. Түүний гэргий, Дуламсүрэн ээж минь Их сургуулийн эрдэмтэн, доктор хүн. Одоо нас 80 гарсан ч ануухан сайхан байна. Манайхан Баянзүрхийн зусландаа гарчихсан байж л дээ. 1964 оны 7-р сарын 19-ний бороо шивэрсэн өглөө аав цонхоороо харсан чинь Жасрай ах эхнэрээ сугадчихсан, машины зогсоол руу явж байж. Аав ч "За Дууяа дуншжээ" гэж бодсон гэдэг. Үдээс хойш ээж өвдөөд, найз бид хоёр нэг өдөр энэ хорвоод ирсэн юм. Ээжийн минь хөхний сүү татраад байсан болохоор Дууяа ээж надад сүүгээ хөхүүлсэн. Ингээд л би хоёр ээжтэй болсон хүн дээ.

Таны анхны хариуцлагатай алба Хотын Ахуйн үйлчилгээний хэлтсийн дарга. Энэ ажлыг санал болгоход таныг "Аваасаа асуучихаад ирье" гэсэн гэж сонсож байсан. Аав тань яг юу гэж захьсан бэ?

Би тэр үед Нийтийн Аж Ахуйн Яамны мэргэжилтэн байсан. Яам татан буугдах болоод, шинэхэн байгуулагдаж байсан хотын ахуйн үйлчилгээний хэлтсийн даргаар томилох тухай хотын үйлчилгээ, худалдааны салбарыг хариуцсан орлогч дарга Л.Жавзмаа дарга дуудаад хэлсэн юм. Би ч аваасаа асууя гэсэн. Энэ яриаг сонсож суусан Худалдаа, аж үйлдвэрийн нэгдлийн дарга Банзрагч гэдэг хүн "Энэ их сайхан даруухан хүү байна, аваасаа асууя гэж хэлж байдаг" гэж билээ. Асуухгүй байж болохгүй. Улсын нийслэл хотын Ахуйн үйлчилгээний хэлтсийн дарга болох байтугай жижиг зүйлийг ч аваасаа асуух үе бидэнд зөндөө. Хэн ч гэсэн асуух л байсан. Аав минь "Дарга болох, олны итгэлийг хүлээнэ гэдэг сайхан. Даах хэцүү. Дараа нь албан тушаалаас буух, болих үе ирнэ, тэр бас амаргүй. Энэ тухай битгий мартаарай" гэж л хэлсэн.

Энэ үгийг бодох мөч танд олон байсан уу?

Аавынхаа үгийг үргэлж л бодож явах юм даа. Тэр тусмаа аавыгаа бурхан болсноос хойш хэлсэн, ярьсныг нь бүр ч их санадаг, боддог болчихдог юм байна. Би хар багаасаа л машин тэргэнд дуртай, машин барих гэж хорхойсдог хүүхэд байсан. Хотын дарга болчихоод, амралтын өдөр машинаа бариад, аавыгаа хажуудаа суулгачихаад давхиж явлаа. Тэр үед Хотын банк гэж байсан, одоогийн Голомт банкны хажуугаар өнгөрөөд, ордны баруун талын уулзвараар ширүүхэн эргэчихлээ. Тэгсэн аав "Хүүе, чи жаахан аажуу явна шүү. Осол гэдэг хэнд ч тохиолдоно. Хотын дарга гээд л биеэ тоогоод байна уу" гэж билээ. Жолооны ард суух бүртээ л аавынхаа энэ үгийг өөрийн эрхгүй санадаг. Ингээд бодохоор хүний аав гэдэг үр хүүхдийнхээ амьдралын замыг энгийн хэдэн үгээрээ зураад өгчихдөг ч юм шиг.

Одоо жолоо барих боломж хэр олдож байна вэ?

Хүүхэд байхаасаа л хөдөө яваад сурчихсан болохоор хөдөө, хээр, агаар салхи үгүйлэгдээд байдаг юм. Боломж, зав зай гарах л юм бол Мааньт тийшээ явчих санаа их байна. Тэр үедээ л жолоочоо амраагаад хөдөө газар жолоо мушгих бага сага боломж гардаг даа. Хааяа амралтын өдрөөр хотод тэргээ өөрөө бариад явах үе байдаг л юм.

Та хэвлэлээр байнга "гөвүүлж" байдаг улстөрчдийн нэг. Баг болон ажиллаж явахад урваж шарваж явсан "нөхдүүд" ч олон байсан. Тэр бүхэнд үзүүлж байгаа хариу үйлдлийг тань харахад хэтэрхий гэмээр тэвчээртэй юм. Хатуухан, ширүүхэн улстөрчид ч бас байна шүү?

Улс төрийн амьдрал, хүний амьдралын алинд ч баримтлах ёстой "Зөөлөн нь хатуугаа...", "...идүүлсэн бут ургана", "Урсгал ус чулуугаа мөлийлгөж дийлдэг" гэх мэт амьдралаас урган гарсан ардын мэргэн үгс байна. Асуудал гарах бүрт уралцаж, үзэлцэж, ялах дийлэх гэхээсээ илүүтэй ярилцаж, учир начраа ойлголцож, бусдад энэ тухай бодох, эргэцүүлэх боломж, цаг хугацаа өгч явдаг. Ойлгох хүмүүс нь ойлгоно. За ойлгохгүй, ойлгохыг хүсэхгүй байгаа, ойлгосон атлаа ойлгоогүй царайлдаг хүмүүст бол цаг хугацаа ойлгуулна. Цагийн эрхээр үнэн худал нь ялгараад ирнэ.

Танд хүндхэн шийдвэр гаргах үе олон байсан. Саяхан л гэхэд Шийдлийн Засгийн газарт МАН хамтрахаар боллоо. Улс төрийн хувьд эрсдэлтэй шийдвэр байсан гэх юм. Ямар ашиг сонирхол энэ шийдвэрийг гаргах түлхэц болсон бэ?

М.Энхболд гэдэг хүн МАН-ын даргынхаа хувьд энэ шийдвэрийг гаргахдаа улс төрийн өнцгөөс хараагүй биш харсан. Зарим хүмүүс бол "Бүр элгээр нь хэвтүүлэх ёстой. Засгийн газарт хамтарч болохгүй" гэж хатуухан хэлсэн нь ч бий. Бид судалсан, намын анхан шатныхаа байгууллагуудын саналыг сонссон. Эцсийн шийдвэр нь "МАН шиг Монгол Улсын тусгаар тогтнолыг төдийгөөс өдийг хүртэл нуруун дээрээ үүрч, эх орныхоо төлөө явсаар ирсэн нам ийм хэцүү цагт, ард түмэн ядарч байхад зөвхөн улс төрийн ашиг сонирхол тооцож, зүгээр хараад шүүмжлээд сууж болохгүй" гэсэн шийдэл байсан. Хожмын нэг өдөр өнөөдрийн энэ хариуцлагагүй байдлын төлөө давхар хариуцлага хүлээх ч нөхцөл байдал бий болж мэдэх юм. Тиймээс би зөвдсөн, буруудсан аль нь ч бай, энэ нөхдүүдтэй хамтарч, ярьж хэлж, алдаа оноог нь ил тод болгож, алдааны угшил буглаа хаана байгааг оношилж, түүнийг нь засаж, цаашаа явах ёстой гэсэн байр суурин дээр байсан.

Үр дүн хэр байна?

Бүх зүйл санаснаар болохгүй байна. Сүүлийн хэдэн өдрүүдэд байнгын хорооны хурал, чуулганы нэгдсэн хуралдаанд би "Өнгөрсөн 2 жилийн эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийе. Энэ оношилгоогоо хэзээ хийх юм, хийхгүй ингээд явсаар байх уу" гэж яриад л байгаа. Миний хувьд 1987 онд төлөвлөгч-эдийн засагч мэргэжлээр их сургууль төгсөж ирээд хотын Ахуйн үйлчилгээний удирдах газрын харьяаны үйлдвэрийн газруудын 3000 гаруй хүний цалин боддог байлаа. Жил, улирлын эцэст тайлан баланс гаргахад хөдөлмөр, цалин хөлсний хэсэгт цалин, хөдөлмөрийн бүтээмж яаж өссөн бэ гэдэг дүн шинжилгээг хийдэг байсан. Эдийн засгийн сургуулиудад дүн шинжилгээ хийх онолын үндсийг нь заадаг биз дээ. Манай намаас томилогдсон Сангийн сайд ажилтайгаа танилцаад "Төсвийн данс хасах 700 гаруй тэрбум төгрөг байна шүү" гэсэн мэдээллийг ил болголоо. Тэгэхээр 17 хувийн өсөлттэй

"Манзушир хутагт" сангийн Тэргүүн М.Энхболдод Монголын Бурхан шашны шинэ цагийн хутагтууд бараалхав. Манзушир хутагт, Ламын гэгээн, Жалханз хутагт, Гуш ренбучи, Гүндээлэн ренбучи, Гачин ренбучи, Ханчин ренбучи, Сарайдорж Номун хан нар

байсан эдийн засаг хоёрхон жилийн дотор яагаад ийм болчихов, төсвийн орлого ингэтлээ их тасрав гэдгийн учир шалтгааныг хайж, оношлохгүй байна гэдэг зөв үү. Өнгөрснөө ярихгүй ингээд орхиё, ирээдүйдээ анхаарлаа хандуулъя гэх л байх. Гэтэл алдаагаа засахгүйгээр цаашаа явж болохгүй. Энгийн ухаанаар бодоход хүний бие өвдлөө гэхэд аль эрхтэн нь өвдсөнийг оношилж мэдэхгүйгээр ерөнхий эмчилгээ хийдэг бил үү. Тиймээс "Чингис" бондын зарцуулалтаас уу, үнэ тогтворжуулах хөтөлбөрөөс үү, эсвэл шударга бус үйл явдлуудаас болоод төсвийн зарцуулалт, Хөгжлийн банкны хөрөнгө мөнгө өм цөм, ийшээ тийшээ алга болчихов уу? Энэ бүхнийг тодорхой болгож байж л цаашаа явах ёстой. Зарим нөхдүүд "Улс төрийн хариуцлага хүлээчихсэн. Энэ тухай эргэж ярьж сөхмөөргүй байна" гэх юм. Хэн нэгнийг буруутгах, буруутныг олох, яллах гээд байгаа асуудал биш. Ирэх он жилүүдэд эдийн засгаа өөд татъя гэвэл эдийн засгийн нөхцөл байдал хүндэрсний учир шалтгаан, угшил, буглааг олж, алдаагаа засах хэрэгтэй байна. Тэр тусмаа улстөрийн намууд засагт хамтарч байгаа энэ үед алдаа оноогоо мэдэлцэж, улс орны, ард түмний эрх ашигт нийцсэн бодлого боловсруулж, тийм шийдвэрүүд гаргаж гэмээнэ хамтарсны хэрэг нь гарна.

Танай намынхан дотор ч гэсэн энэ шийдвэрт эсрэг байр сууринаас хандаж байгаа хүмүүс цөөнгүй бий?

Цаг хугацаа энэ шийдвэр зөв буруу аль нь байсныг маш тодорхой харуулна. Ер нь үеийн үед л удирдлагуудын гаргасан шийдвэрүүдийн эсрэг байж, тэр бүхнийг буруутгаад байх нь зөв зүйл биш шүү. 2008 онд Ардчилсан намыг Засгийн газарт урьж оруулсан нь буруу л гэсэн. Гэтэл 2014 онд Ардчилсан намд уригдаж Засгийн газарт орсон нь бас л буруу. Ердөө ч хамтарч болохгүй юм шиг, МАН-ын үе үеийн дарга нарын гаргасан шийдвэр бүхэн буруу юм шиг ярих юм. Тэр түүхэн шийдвэрүүд буруу байгаагүйг цаг хугацаа, алдаа оноо харуулаад л байна. Улс орны эрх ашгийн өмнө тулгарч байгаа асуудлыг шийдэхийн тулд бид зоримог шийдвэр гаргаж, эрх баригчийн хийгээд сөрөг хүчний аль ч байр суурин дээр байсан хэлэх зүйлээ хэлж, санаа оноогоо уралдуулж, хамтарч чаддаг байх үүрэгтэй. Харин хамтарсан гэдэг нэрийн дор нэгнийхээ буруу алхмыг мэдээгүй царайлаад явна гэдэг зарчим байж болохгүй. Тэр тусмаа Улсын Их Хурал Засгийн газрын алдаа оноог маш нарийн харж, засаж залруулах үүрэгтэй, энэ үүргээ биелүүлэх ёстой.

Улстөрч бүхэнд олон нийтэд хүлээн зөвшөөрөгддөг өөр өөрийн төрх байдаг. Зарим хүнийг уран сайхан яриа, өөр нэгнийг зохион байгуулсан тэмцэл, жагсаал цуглаан нь "чимдэг". Харин таны хувьд бага ярьдаг?

Би сонгуульд "Ярих уу, хийх үү" гэдэг уриатай оролцсон хүн. Зарим хүмүүс их ярих юм. Уг нь бид хийх, бүтээх ёстой хүмүүс. Тиймээс хийнэ, бүтээнэ л гэсэн санаагаа илэрхийлэх гэсэн уриа юм уу даа. Энэ зарчмыг баримталдаг.

Үр дүн нь юу байв?

60-70 хувиар ялалт байгуулсан.

Олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгсэл хүчтэй нөлөөтэй болсон энэ цагт хэтэрхий чимээгүй байх нь улстөрчид ашиггүй биз дээ. Би ганцхан жишээ хэлмээр байна. Монгол хүн 2008 оны Бээжингийн Олимпоос анхны алтан медаль авах үед бид талбай дүүрэн цугласан. Төрийн түшээд ч тэнд байсан. Та харагдаагүй?

Би ордон дотор байсан.

Гэхдээ та гарч ирээгүй. Улстөрчийнхөө хувьд биш ч, Олимпод бэлтгэх үндэсний

Их ажлын заваар хөдөө дүүгийндээ

хорооны даргын хувьд. Олимпийн багийн төсөв хөрөнгийг 10 дахин, тамирчдын цалин хангамжийг 7 дахин нэмж чадсан, үүнд хэрэгтэй бүх л санхүүжилтийг босгосон, тамирчидтай хамгийн ойр байсан хүний хувьд энэ баярыг хуваалцах хүний нэг нь яах аргагүй та мөн байсан?

Бараг мартчихсан тоонууд таны асуултад дурдагдсан чинь сайхан сонсогдлоо. Би хувьдаа монголчууд 2008 оны Бээжингийн Олимпод заавал амжилт гаргах ёстой, газар зүйн байрлал, цаг агаарын ба цагийн бүсийн хувьд ч хамгийн ойр газарт болж байгаа нь олимпийн амжилтад нөлөөлнө гэдэгтэй санал нэг байсан. Тиймээс ч энэ амжилтыг бий болгохын төлөө өөрийн зүгээс чадах зүйлээ хийе гэж зүтгэсэн. Төсөв, мөнгийг нэмэгдүүлэхийн төлөө боломжит бүх эх сурвалжийг ашигласан. Улсын төсвөөс зарцуулдаг хөрөнгө, мөнгийг ч нэмэгдүүлсэн.

Энэ тухайд би спортын зүтгэлтнүүд, тамирчдын ярианаас сонссон учраас ийм тод санаж байгаа юм?

Тамирчид маань уулзахаараа энэ талаар дурсах бүрт надад сайхан байдаг. Танд бас ярьсан байх нь. Олимпийн бэлтгэл ажлын тухайд Эрдэнэт үйлдвэрийн хуучин ашиглаж байсан усны өргөгч насосны хажуугийн барилга байгууламжийг холбогдох газартай нь ярилцсаны үр дүнд авч, Олимпийн хорооны мэдэлд өгч, тамирчдын бэлтгэл хангах баазыг байгуулсан нь их зөв шийдвэр байж дээ гэж эргээд харахад бодогддог. Тэнд хамгийн их нарс ургадаг учир агаарын хүчилтөрөгчийн агууламж их, өндөр нам нь яг л таарсан газар гэж мэргэжлийн хүмүүс хэлсэн нь яг оносон байна лээ. Тэнд бэлтгэл хийсэн тамирчдаас олимп, дэлхийн олон медальтнууд төрж байна. Талбай дээр цугласан олны тухайд бол 7-р сарын 1-ний гашуун өдрийн айдас хүйдсийг тайлсан сайхан үйл явдал болсон. Төрийн гурван өндөрлөг нь хүний ёсоор баярласан сэтгэлээ илэрхийлж, олон нийт тэднийг ойлгож хүлээж авсан нь сайхан дурсамж болон үлдэжээ.

Лондоны Олимпод оролцож байхад нэг тийм шаргал өнгөтэй медальтай бол ч гэх жаахан шунаг сэтгэл төрж байсан шүү. Олимпийн багийг ахалж явахад дандаа ийм сайхан явдал тохиолдоод байдаггүй юм. Хатуу ширүүн шийдвэр гаргах үе ч бий. Монгол Улс багаа аваад маргааш өглөө нутаг буцлаа, олимпийг орхилоо гэж хэлэх шаардлага гарч л байсан. Дэвжээний шүүгч ялалтыг өгсөөр байтал дахин хяналт хийлгээд "Английн тамирчин ялсан" гэх шударга бус дүгнэлтийн эсрэг багийн ахлагчийн хувьд ийм шийдвэр гаргаж байгаагаа хэлсэн. Үүний дараа шүүгчдийн зүгээс гаргасан буруу шийдвэрээ хүлээн зөвшөөрч, дэвжээний шүүгчийн шүүлт зөв байжээ гэж манай талд асуудал шийдэгдэж байсан.

Бас л эрсдэлтэй алхам хийжээ. Ер нь яаж яваад Олимптой холбогдох болов?

Талийгаач Ш.Отгонбилэг гуай намайг 1999 онд Биеийн тамир, спортын хороон дээр дуудаад, Олимпийн хорооны тэргүүлэгч гишүүдийн хуралдаанаар 10 гаруй хүн гар өргөөд л шууд л тэргүүлэгч болгочихсон хэрэг.

Социалист нийгмийн үед та үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт ажиллалаа. Шударга өрсөлдөөний талбар спортыг хөгжүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулъя гээд зүтгэлээ. Төрийн өндөр албан тушаалуудыг хашлаа. Энэ хугацаанд аливаа ажлыг хийхэд энэ л хамгийн их саад болдог юм байна даа гэх дүгнэлтэд хүрэх үе олон байсан байлгүй дээ?

Хүний атаач зан хаана, хэзээ гэдгээс үл хамаарч нэгнийхээ бодсон, санаачилсан, эхлүүлсэн, хийгээд үр дүнг нь үзье гэсэн санал санаачилга, ажлын садаа тээг болдог. Яг л хажууд нь байгаа нөхөр "Энэ биш ээ, ингэж болохгүй" гэж үгүйсгээд эхэлбэл болж бүтэх ажлыг болохгүй болгоод, эцэс сүүлд нь замхруулдаг. Үнэндээ нэг их илүү мундаг туршлагатай, илүү ухаантайдаа болохгүй гээд байгаа юм биш шүү дээ. Аар, саархан шалтаг хаанаас ч олддог. Ихэнх тохиолдолд энэ нь атаа жөтөө байдаг. Магадгүй "Би дараа дарга, даамал болохоороо хийнэ" гэсэн атаг санааны тусгал юм болов уу. Олон ч бүтээн байгуулалт, үр өгөөжтэй ажил энэ л байдлаас болж цаг хугацааны хувьд хойшилж, үр ашиг нь алдагдах юм.

Ийм байдал олон тохиолдож байв уу?

Олон.

Тодорхой жишээ хэлээч?

Би Ерөнхий сайдаар ажиллаж байхдаа 2007 оны дөрөвдүгээр сард Оюутолгойн гэрээний төслийг боловсруулаад УИХ-д өргөн барьсан. УИХ-аас байгуулсан ажлын хэсэг олигтой судалж өгөхгүй, хуралдахгүй удаасаар байгаад хойшлуулсан. Дараагийн Засгийн газар тэр гэрээг татаж аваад, шинэ гэрээ оруулж ирсэн. Манай багийн оруулсан гэрээ өнөөдрийн байгуулчихсан гэрээнээс хамаагүй сайн нөхцөлтэй байсан юм. Монгол Улс 34 хувиа үнэгүй авна, хөрөнгө оруулалтын хэмжээ 2,7 тэрбум ам.доллар, 2011 онд зөс хайлуулах үйлдвэр байгуулна гээд яриад байвал Монголын талд хамаагүй их ашигтай гэрээ байсан. Ийм гэрээг цаад талтай үзэглэчихсэн байхад батлаагүй гээд бодохоор харамсалтай л санагддаг. Эгийн голын усан цахилгаан станцын асуудал байна. Гарын үсэг зурлаа бол ажил эхлэхэд бэлэн байдаг. Хятадын Засгийн газрын 300 сая ам.долларын санхүүжилтээр ажил эхлэхээр болчихсон. Азийн Хөгжлийн банкны санхүүжилтээр 1990-ээд оны эхэн үед 4,8 сая ам.доллар зарцуулаад төслөө хийлгэчихсэн. Хятадын Засгийн газрын Гадаад харилцааны сайд У Дау гэдэг хүн надад "Та санаа зоволтгүй, ажлаа эхлүүлээрэй. Дутах санхүүжилтийг нөхцөлийг нь өөрчлөхгүйгээр нэмж өгнө" гэж хэлсэн. 40 жилийн хугацаатай, маш бага хүүтэй зээлээр энэ ажлыг хийж болох бүх боломж нь хангагдчихсан байдаг. 1 квт цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэх зардал нь 11 төгрөг байх тооцоотой. Өнөөдөр 1 квт цахилгаан, эрчим хүчийг 40 орчим төгрөгөөр үйлдвэрлэж байна. Сүүлд ажил авсан мэргэжилтнүүд өртөг нь өндөр болоод 89 төгрөг боллоо ч гэдэг бил үү дээ, тэгээд л энэ ажлыг зогсоосон. Үнэн юм гэдэг үхэр тэргээр туулай гүйцнэ гэдэг шиг өнөөдөр эргээд тодорхой болж байна. Энэ төслийг хэрэгжүүлэхгүй бол болохгүй юм байна гээд Эгийн голын усан цахилгаан станцыг байгуулах төслийн нэгж байгуулагдаад ажил нь эхэлж байна. Тухайн үед ажил эхлүүлэх боломжийг алдагдуулснаас болоод эргээд хэдэн жилийн дараа тэр үед 320-330 сая ам.долларааР хийх байсан төслийн өртөг өнөөдөр 500-600 гаруй сая ам.доллар болчихсон байх жишээтэй. Нэгнийхээ хийж байгаа ажлыг гуйвуулах нь эргээд улс оронд илүү зардал, хүнд ачаа болдгийн ганцхан жишээ л энэ шүү дээ.

Таны Ерөнхий сайд байх үеийн татварын бодлого бизнес эрхлэгчдийн ачааг хөнгөлөхөд багагүй дэмжлэг болсон шүү?

Би Ерөнхий сайд байхдаа 2006 онд татварын багц хуульд оруулсан дөрвөн арвын системийн хүрээнд хүн ам, аж ахуйн нэгжийн орлогын болон нэмэгдсэн өртгийн албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 10 хувиар тогтоож 2007 оны нэгдүгээр сарын 1-нээс эхлэн хэрэгжүүлсэн юм. Үүний үр дүнд тухайн үедээ манай улс Ази-Номхон далайн бүс нутагт татварын хувь хэмжээгээр хамгийн багатай улсад тооцогдож байлаа. Дөрвөн арвын систем гэхээр бараг хүн бүхэн мэдэх байх аа. Үр шимийг нь хүртсэн иргэд, аж нэгжүүд ч олон. Ийм шатлалтай болсноор хувийн хэвшил, аж ахуйн нэгж, жижиг, дунд үйлдвэрлэл хөл дээрээ босч бие дааж хөгжихөд түлхэц болсон шүү. Жишээлбэл, гурван тэрбум төгрөг хүртэлх татвар ноогдох орлоготой жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд дөрвөн арвын татвар үр дүнгээ өгсөн. Нийт аж ахуйн нэгжүүдийн 98 хувь нь 10 хувийн орлогын албан татварт хамрагдсан гэсэн үг л дээ.

Аав охин хоёр - намын их хурлын төлөөлөгчид

Таны улс төрийн болон бусад чиглэлийн илтгэл, хэлэх үгийг хэн бичдэг бэ?

Ерөнхий санаа, мэдээлэл, тоо баримт зэрэгт мэргэжлийн хүний үг, зөвлөгөөг их авна. Эцсийн боловсруулалтыг өөрөө хийнэ. Нэлээн нухна шүү.

Таныг илтгэлээ шинжлэх ухааны үндэслэл сайтай боловсруулдаг гэж сонсож байсан учир энэ тухай онцолж асуулаа?

Хэнээс сонсов?

Улаанбаатар хотын 360 жил, 2006 онд Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойд зориулсан илтгэлийг Монголын түүхийн шинжлэх ухааны салбарт шинжлэх ухааны бүтээлийн хэмжээнд боловсруулсан илтгэл болжээ гэж эрдэмтэд дүгнэсэн байдаг юм билээ?

Аливаа түүхэн ойг тэмдэглээд өнгөрөх нэг хэрэг. Харин түүхийн бодит үнэнийг ном, бүтээл болгож үлдээх нь чухал юм гэж бодоод түүхийн салбарынхныгаа дэмжиж байгаад нэлээд хэдэн ном товхимол гаргуулсан. Тэгэхгүй болохоор үе, үед төрийн мэдэлд хүрсэн хүмүүс өөрийн үзэл бодлын үүднээс түүхийг тайлбарладаг буруу жишиг тогтчих вий гэсэн болгоомжлол төрөх л юм байна. Тиймээс ч түүхэн ойд зориулсан илтгэлээ бодит мэдээлэлд тулгуурлан, шинжлэх ухааны үндэслэлтэй, түүхэн баримт болохуйц хэмжээнд бэлтгэхийг хичээдэг.

Таныг Ерөнхий сайд, Шадар сайд байхад түүхэн хэд хэдэн ой давхацсан. Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилээр та Ерөнхий сайд байсан. Олон сайхан түүхт ой тухайн үед тохиож байсан нь бэлэгшээлтэй л юм?

Тийм шүү. Цаг хугацааны мөчлөгийн хувьд бид өвөг дээдсийнхээ бүтээсэн түүхийн ойн жилүүдийг бахархан тэмдэглэх хувьтай байна гэдэг бас л бэлгэдэлтэй хэрэг. 2011 онд Тулгар төр үүсч, Хүннү гүрэн байгуулагдсаны 2220, Их Монгол Улс байгуулагдсаны 805, Үндэсний эрх чөлөөний хувьсгалын 100 жил, Ардын хувьсгал ялсны 90 жил гэсэн дөрвөн их ой тохиоход би Шадар сайд байсан. За Шадар сайдаар ахлуулъя, тэгье гэсээр байтал бүх комиссын дарга болчихож. Бүгдээрээ нийлээд, эрвийх дэрвийхээрээ л зүтгэцгээлээ, наадам, ой сайхан боллоо л гэсэн. Энэ явдлаас жилийн дараа

Өмнөговь аймгийн нэг хүн “Манай аймагт цагаан шүр гэдэг их гоё зөөлөн цагаан чулуугаар хөөрөг хийдэг юм. Би танд хийж өгмөөр байна. Танд санаа оноо байна уу?” гэдэг юм байна. Нэлээд бодсоны дараа би дөрвөн талтай, тал тус бүр дээр Чингис хааны гэрэгэ дээр монгол бичгээр ойн дурсгалын үг бичүүлэх захиалга өгсөн. Энэ хөөргийг одоо жил гаруй хэрэглэж байна. Орсон гарсан хүмүүс хөөргийг минь их сонирхдог. Хожим нь музейд өгнө дөө.

Сүхбаатарын талбайн өнгө төрхийг 60 жилийн дараа анх удаа засаж, шинэчилсэн нь тухайн үедээ их л хэл ам дагуулж байлаа. Одоо бид гадна дотны зочдоо нүүр бардам угтаад сайхан л байна?

Нийслэл хот 2003 оныг “Их бүтээн байгуулалтын жил” гэж зарласан. Хотын дарга уриалсан бол өөрөө манлайлж, бүтээн байгуулалт хийх ёстой биз дээ. Тухайн үед нийслэлийн маань төв талбайн хагарч цуурсан асфальтны завсраар ургасан өвс ногоог нь зулгааж цэвэрлэж байж төрийн ёслол хүндэтгэлийн арга хэмжээ явуулдаг байсан. Тэгээд л бид юуны өмнө Д.Сүхбаатарын талбайг боржин чулуугаар бүрье гэсэн санаачилга гаргаад, ажлаа эхлүүлсэн. Ардын хувьсгал ялсны дараа Д.Сүхбаатар жанжин цэргүүдтэйгээ орж ирсэн аргагүй түүхтэй газар энэ талбай мөн. Аливаа талбай, гудамж, байршлын нэр гэдэг бодит түүхэн үйл явдалтайгаа холбогдох ёстой. 2003 онд 2 тэрбум орчим төгрөг гэдэг бага биш хөрөнгө байсан. Бүгдийг хандиваар шийдсэн.

Хандив амлуулах нэг хэрэг, авах ч бас амаргүй даваа. Тэр үед хандивласан хүмүүс бүгд өгсөн үү?

Бүгд өгсөн. Ямар надад өгөх гэж байгаа биш дээ. Улсынхаа тусгаар тогтнолын түүхийн гэрч, төв талбайгаа сайхан болгох гэж байгаа юм чинь хармын сэтгэлгүй л өгцгөөнө шүү дээ. Энэ ажлыг хийсний дараа мэргэжлийн хүмүүс төв талбайн маань нас 100 жилээр уртаслаа гэж байсан. Тийм хэмжээний эдэлгээ дааж байвал сайхан л байна. 32 мянган кв.метр талбайг боржин чулуугаар бүрсэн. Түүний дор сайн сөөм зуузаан цемент цутгаж, дээр нь элсээр багсармал асгаад боржин чулуугаа байрлуулсан.

Улстөрчид шийдвэр гаргахдаа олны санаа бодолд нийцүүлэх гэж хичээдэг болчихсон ч юм шиг. Таны хувьд энэ тухайд ямар бодолтой явдаг бол?

Хөдөө томилолтоор явж байхад шинэ хүнд нэр өгөх хүндтэй атлаа хүндхэн үүрэг тохионо.

Аливаа шийдвэрийг гаргахын өмнө олон хүнтэй уулзаж, ярилцаж, асууж лавлана. Энэ бүх мэдээлэл дээрээ суурилуулаад, өөрийн сэтгэл зүрх, итгэл үнэмшилдээ хөтлөгдсөн шийдвэрүүдийг гаргадаг. Түүнээс биш олон нийтийн санаа бодол ийм байна, ингэвэл нийтэд таалагдах юм байна гэсэн далд бодлоготой, давхар мэхтэй шийдвэр гаргаж, өөрийгөө хүчлэхийг би буруу гэж боддог. Ихэнх тохиолдолд өөртөө итгэл үнэмшилтэй болж, дараа нь гаргасан шийдвэртээ эзэн нь байж чаддаг байх нь улстөрч хүний үүрэг юм.

Сүүлийн хэдэн жил эдийн засаг хүндхэн байгаа ч цаг сайхан байна. Ийм сайхан цагт тэр тухай ярих хэрэг байна уу даа гэж би өөрөөсөө олон удаа асуусан. Гэхдээ ярихгүй өнгөрч боломгүй байна. Хэлж ирэхгүй хийсч ирдэг цагийн бэрхшээлийг даван туулах гэж зүтгэсэн малчидтай та олон ч удаа хамт байсан шүү?

Зуд турхан гэдэг цаг хугацаатай үзэгдэл учраас хүмүүс их амархан мартдаг. 2009-2010 оны өвөл маш хатуу болж байлаа. Олон ч хүний алтан амь эрсдэж, олон жилийн хүч хөдөлмөр үгүй болсон доо. Сүүлийн 40 жил болоогүй зуд болсон гэдэг. Би яагаад ингэж маш тодорхой тоо хэлээд байна вэ гэхээр, настнуудын амнаас сонссон юм. Тэр их зудны жил цагаан сар нэлээд хуучирсан цагаар Төв аймагтаа очлоо. Зуунмод сумын хамгийн өндөр настнуудтай золгосон. Шинэ сар нэлээд хуучирчихсан байсан ч хөгшчүүл цай цүү болоод тэр үед 90 гаруй настай Найдан гэдэг хөгшин гаднаас ууцныхаа голыг оруулж ирээд “Хөлдүү байна. Гэсэн ч ёс ёмбогор, төр төмбөгөр. Төрийн хүн ирлээ” гээд өмнө минь тавьсан. Тэгээд хуучилж суухад “За энэ ч сүүлийн 40 жилд болоогүй өвөл боллоо доо. Энэ хэцүү, бэрх цагийн ард гарлаа. Хүү минь чи их ч явлаа даа” гэсэн. Тэр л хүний ярианаас энэ 40 жил гэдэг тоог олж сонссон. Дараа нь Өвөрхангайд явж байгаад Хархорины зүүн өмнөхөн байх нэг хот айлд очлоо. Насаараа мал дагасан 60 гаруй насны хөгшин байна. Хоёр жаахан хүүхэдтэй. Хот нь харлачихсан, харахаас нүд хальтрам хэцүү байдалтай. Ойр зуурын зүйл ярилцаж суутал, өвгөн “Ёстой хэцүү цаг боллоо, миний хэдэн хүүхдүүд мөн ч азгүй юм даа” гээд уйлсан. Тэр хэрийн насны эр хүний нулимс гэдэг тийм ч ойрхон байдаггүй шүү дээ. Энэ хоёр уулзалтын дараа л би үнэхээр хатуу бэрх цагийг туулжээ гэж бодох болсон. Гадаадын бүх элчин сайд, олон улсын байгууллагуудын дарга нарыг цуглуулаад би Улсын Онцгой комиссын даргын хувьд биечлэн уулзаж, хүсэлт тавьсан. Нисэх дээр Ил-76 онгоц 15 минутын зайтай 3 удаа бууж гадаадын тусламжийг хүлээж авч байлаа. Ил-76 гэдэг онгоц чинь шалаанз машин бүхлээрээ дотор нь орчихдог том онгоц шүү дээ. Тэр жилийн цас зудын бэрхшээлийг даван туулж, хохирлыг барагдуулахад нийтдээ 45 тэрбум төгрөг зарцуулсан. Энэ их мөнгөний 6.8 тэрбумыг төсвөөс гаргаж, бусдыг нь гадаад, дотоодын байгууллагуудын хандивын хөрөнгөөр шийдвэрлэж байлаа. Тэр үед Гадаад харилцааны сайд байсан Г.Занданшатар надад их дэм болсон.

Та төрийн болон төрийн бус байгууллагуудад алба хаших юм. Яаж энэ их ажлыг амжуулаад байна?

Хүнд итгэл өгч, баг болж ажиллахгүй бол би ганцаараа яаж бүгдийг барах билээ. Хэнд аль ажлыг хариуцуулах вэ, өөрөө хэзээ нь оролцож, юуг нь хянах юм бэ гэдэгт л асуудал байдаг болов уу. Тэр ч байтугай хөрөнгө зарцуулах эрх мэдлийг өгч чаддаг байх хэрэгтэй. Өнөөдрийн зарим удирдлагуудыг харж байхад хөрөнгө зарах эрх мэдлээ гартаа атгачихаад “Хий, хий” л гээд байдаг. Мөнгөгүйгээр ямар ч ажил урагшаа явахгүй. Гол нь эрх мэдэл, хөрөнгө мөнгөний зарцуулалтыг өгснийхөө хэрээр үр дүн нэхдэг, сайн тооцдог байх ёстой юм.

Эрх мэдэл өгнө гэснээс орон нутагт эрх мэдэл өгөх тухай асуудал мөн ч олон жил, янз бүрээр яригдсаар бүр ужиг болж гүйцлээ. Нэг засаг нь гарч ирээд өглөө л гэх, нөгөө нь засаглахаараа болохгүй л гэх?

Би ч улс төрийн хүрээнийхний яриагаар бол орон нутгийн угшилтай улстөрч. Дүүргийн дарга, хотын дарга, Төв аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүн гээд. Тэрэндээ ч гол нь биш. Бодит байдлыг судалж үзээд орон нутагт эрх мэдэл өгөх тухайд томоохон шийдвэр гаргаж байлаа. Харамсалтай нь аливаа шийдвэрийн үр дүнг үзээгүй байж их амархан өөрчилдөг болж. Би Ерөнхий сайд болсныхоо дараахан орон нутагт эрх мэдэл өгөх асуудлыг өндөр түвшинд шийдэх ёстой гэж үзээд Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Д.Дондог гишүүнээр ахлуулсан комисс байгуулж, мэргэжлийн хяналт, цагдаа, онцгой байдал, татвараас бусад бүх салбарын удирдлагыг аймгийн Засаг дарга томилдог болгосон. Энэ мэт дараа дараагийн алхмуудыг зоригтой хийсэн. Одоо эргээд харахад энэ бүхнийг үгүйсгээд төвлөрүүлэн удирддаг байдал руу шилжчихэж. Орон нутагт сэтгэл, гар нийлж зүтгэх багийн тоглолт хийх боломжийг хаачихлаа. Аливаа хүнд хэцүү нөхцөл байдлыг давах, том ажил, зорилгын ард гарахад баг хамт олны нэгдсэн хүч, зангидсан гар шиг сэтгэл чухал гэдгийг төр засгийн удирдлагууд мэддэг л баймаар юм даа. Үүнээс гадна орон нутгийн санхүүгийн бие даасан байдлыг хангах нь чухал юм. Жишээ дурдахад 2006 он хүртэл нийслэлээс улсын төсөвт жил бүр 15 орчим тэрбум төгрөг төвлөрүүлдэг байсныг манай Засгийн газрын үед эрс бууруулснаар 2007 онд нийслэлээс улсын төсөвт 1.5 тэрбум төгрөг төвлөрч байсан. Энэ нь орон нутгийн санхүүгийн бие даасан байдалд дэмжлэг болсон арга хэмжээ боловч дараагийн засгийн газруудын үед нийслэлээс улсын төсөвт нэлээд олон тэрбум төгрөг төвлөрүүлэх болсон.

Удахгүй цагаан сар болох гэж байна. “За тэр маань ч одоо ингээд ороод ирнэ дээ” гэж хүмүүс их ярьдаг. Таны хувьд тэр хүлээдэг зочин хэн бэ?

Бид ч наадам, цагаан сараа хүндэтгэн бэлгэшээж, дээдлэн тэмдэглэдэг ард түмэн. Энэ жилийн наадмын тухай ирэх жилийн наадам хүртэл ам дамжин хуучилдаг. Цагаан сараар хүлээдэг зочид олон доо. Нэр цохох хэрэг байна уу. Яахав, сонин болгоод ярихад миний тэргүүлж байсан Үндэсний эв нэгдлийн Засгийн газрын гишүүд маань жил бүрийн шинийн 5-нд манайд ирж золголт хийдэг. Би ч хүлээдэг болчихож. Өнгөрөгч оны зун миний 50 насны төрсөн өдрөөр хоолонд орцгооё гээд цугларсан чинь 17 хүн ирлээ. Бид хэд “За энэ чинь Үндэсний эв нэгдлийн Засгийн газар хуралдахаар бол ирц хангалттай байна шүү” гэж наргиа болгоод инээлдэж байлаа.

Уг нь бол үхрийн бөөр шиг алаг цоог бүрэлдэхүүнтэй баг байсан?

Ажил хийхэд амаргүй үе байсан уу гэвэл тийм. Таван намын даргатай, өөр өөрийн үзэл бодлоо уралдуулж, ширүүхэн хэлэлцэнэ. Гэхдээ асуудлыг шийдэж чаддаг. Нэг ч төгрөгийн өр, зээл нэмээгүй, төрийн албан хаагчийн дундаж цалин 92000 төгрөг байсныг 300 мянга болгосон, тэтгэвриг 3 дахин нэмсэн, хүүхдийн мөнгийг 600 мянган хүүхдэд 3000 төгрөг өгч байсныг 1047000 хүүхдэд 10 мянган төгрөг өгдөг болгоод, дараа нь 11300 төгрөгт хүргээд, "Үдийн цай" хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн гээд ажил хийсэн Засгийн газар шүү. Нэг хүнд оногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 811 ам.доллар байсан, бид 1500 ам.доллар болгосон, экспорт нь импортоосоо 100 орчим сая ам.долларaар давсан бодит ашигтай гадаад худалдаа хийж чадсан. Жилд 540 км засмал зам тавьсан, 90 гаруй сумыг байнгын эрчим хүчинд холбосон. Дахиад жаахан ажилласан бол бүх сумдыг эрчим хүчинд холбох зорилт тавьчихсан, төлөвлөгөө гарчихсан байлаа. Цөөхөн сумыг холбож амжаагүй үлдээсэн. Одоо харин тэр ажлыг гүйцээх гээд яриад байх шиг байна.

Улс орны хэмжээний шийдвэр гаргахад 50 насанд хэр бяд нэмэгддэг юм бол?

Мэдээж үзсэн харсан, туулсан, мэдсэн, бодол санаа цэгцэрсний хэрээр гаргах шийдвэрийн алдаа багассан байна. Хүний амьдралд өнгөрүүлсэн цаг мөч бүр үнэ

Морьтон монголчууд Гиннессийн дээд амжилтад бүртгүүлэх жагсаалд эхнэрийн хамт оролцов.

цэнтэй байдаг. Монголчууд 40 насыг их тоодог. Түүнээс хойш 10 жил гэдэг их ч зүйлийг үзэж, туулж, олон ч хүнтэй уулзаж амждаг хугацаа юм байна.

Та өөрийгөө хүн таних тал дээр хэр бэ?

Ажил, амьдралын өгсөх, уруудахын аль ч цагт хамт байдаг нөхөд гэдэг юугаар ч сольж, орлуулж болохгүй үнэтэй. Надад тийм нөхөд олон бий.

Улс төр танд юу өгсөн бэ?

Төрийн олон хариуцлагатай алба хашлаа. Ажил, амьдралын хувьд дадлагашиж, олон ч шалгуурыг давж гарах шаардлага гарч байлаа. Тэр хэрээр найз нөхөдтэй, олон түмэнтэй болсон.

Таны охин улс төрд орж байгаа гэж сонслоо?

Миний охин Хулан Лондоны Их Сургуульд зургаан жил суралцаж, хүний нөөцийн удирдлагаар мэргэшсэн. Тэгсэн одоо Сонгинохайрхан дүүргийн эмэгтэйчүүдийн байгууллагын дарга, намын үүрийн дарга болоод намын амьдрал руу ороод байна. Аавыгаа дагаад улстөрч болох сонирхолтой байгаа бол би буруутгаж чадахгүй. Гэхдээ эмэгтэй хүнд улс төрийн амьдрал хатуу даа. Чадна гээд зүтгэж байгаа бол яахав, өөрөө шийдэг дээ гэж л бодох юм.

Гэхдээ та эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог эхнээс нь дэмжсэн?

Намынхаа дүрэмд нэр дэвшигчдийн 25 хувь нь эмэгтэйчүүд байх заалтыг оруулсан. Дараа нь Улс төрийн намын тухай хуулинд энэ заалтыг нэмсэн.

Төв аймгийнхан таныг хоёр дахь удаагаа УИХ-д биднийг төлөөл гээд сонгосон. Хүн ам цөөн, нийслэлд ойрхон аймгийн гишүүн байх нэг талаас нь харвал төвөгтэй юм уу?

Аймаг, орон нутаг, иргэдийнхээ төлөөлөл болоод зургаан жил болжээ. Хүн ам цөөн, хотдоо ойрхон гэдэг шалтгийн хувьд манай аймаг улсын нийслэл, энэ олон хүнийг хоол хүнсээр хангах үүрэгтэй гэсэн хүчийг нь дагуулаад л асуудлаа зүтгүүлчихдэг, өөр арга байхгүй. Тэгж байж л асуудлаа шийдүүлнэ. Ажил хийх л гэж байгаа хүнд арга чарга олддог л юм. Зорилго байвал зам байдаг гэдэг дээ. Энэ жилийн тухайд л гэхэд аймгийнхаа Хөгжимт драмын театрыг шинэ байртай болгочих санаатай. Манай урлагийнхан чадалтай, сайхан уран бүтээлч олон байна. Гэтэл байр, талбай нь хангалтгүй, хуучирсан байна. Тиймээс 2014 оны төсөвт энэ асуудлыг шийдэх хөрөнгийг суулгах гээд Засгийн газрын гишүүдээсээ гуйлаа. Шийдэж өгсөнгүй. Тэгээд төсвийн ажлын хэсэгт орсон Д.Оюунхорол гишүүнд би ч хэллээ дээ. Засгийн газраас оруулж ирсэн төсөвт бол байхгүй, гэсэн ч та нар минь зүтгүүлээд өгөөч гэсэн. Мөн тэр ажлын хэсэгт оруулсан Су.Батболд гишүүнээрээ хяналт тавиулж, зүтгүүлсээр байгаад 9,5 тэрбум төгрөг тавиулсан. 2014 онд түүнээс 3,4 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн, ажил нь сайн явж байна. Аймгийн маань олон түмэн итгэл хүлээлгэсэн учир, миний хийж чадах зүйл байгаагийн хэрээр зүтгэх нь үүрэг шүү дээ.

Сургууль, цэцэрлэг, зам дэд бүтцийг нь сайжруулах талаар аймагтаа олон ажил хийлээ, хөдөө сум тус бүрт 5, нийт 136 худаг гаргалаа, 2013 онд аймгийн ахмадын амралт, сувиллын газрын барилгыг бариулж халамжийн хэлтэст хүлээлгэн өглөө. Цаашдын төлөвлөсөн ажил их байна. Төв аймгийг зүүн талаараа Налайхтай холбох 25 км зам 2012 онд тендерийг нь зарлаад 2013 онд ашиглалтад оруулсан. Урьд жилүүдэд улсын төсөвт хөрөнгө, мөнгийг нь суулгахаар бидний хөөцөлдөж байсан Зуунмод-Улаанбаатарын зам ч энэ намар Зуунмодоос Өлзийт хороолол руу салдаг хүртэл засагдаж сайхан болсон байна билээ. Жаргалант, Борнуур, Батсүмбэр сумдад фермерийн аж ахуйг хөгжүүлэх ёстой гээд Улаанбаатар хотын хүнсний хангамжийн асуудлыг шийдэх төслийн хүрээнд хамруулаад засмал замтай болгох ажил амжилттай өндөрлөж байна. Одоо Батсүмбэрийн замын ажлаас багахан хэсэг нь үлдсэн гэсэн.

Халуун ам булээрээ.

Та Төв аймгийн хөгжлийн гарцыг хэрхэн хардаг вэ?

Аль ч оронд тухайн улсын нийслэлийн эргэн тойронд байгаа муж, дэд хот, тосгодын хувьд нийслэлийнхээ хүнс тэжээл, хангамжийн найдвартай ар тал байж, хөгждөг жамтай байдаг. Төв аймгийнхан өмнө нь ч энэ үүргийг биелүүлж байсан, одоо ч хийж л байна, цаашдаа ч ийм байсаар байх болно. Одоо дахиад шинэ нисэх буудлаа дагаад 100 гаруй мянган хүнтэй шинэ хот байгуулагдах гэж байна. Би Ерөнхий сайд байхдаа 2006 оны гуравдугаар сард Японы Ерөнхий сайд Ж.Койзумитай уулзахдаа хүсэлт тавьж, Хөшигийн хөндийн нисэх буудлыг байгуулах талаар тохиролцож байлаа. Энэ ажлын эхлэл 2017 онд үр дүнгээ өгч, нисэх буудал ашиглалтад орно. Олон улсын өмнө үүрэг хүлээсэн энэ төслийн баттай ар тал нь манай Төв аймагчууд л байна. Энэ мэтчилэн манай аймгийн хөгжлийн олон шийдэл, гарц, боломж улам бүр тодорхой болно.

Монголын тариалан эрхлэгчдийн үндэсний холбоо, Засгийн газрын хооронд улаан буудайнаас үүдэлтэй маргаан үүсчихлээ. Уг нь үе үеийн Засгийн газар тариаланчдад огт хатуурхаж байгаагүй санагдах юм?

Тариаланчид улсын стратегийн хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнийг өөрсдийн гараар бүтээдэг. Үндэсний үйлдвэрлэгчид болох тариаланчдаа дэмжиж, урамшуулж, газар тариалангийн салбарын тогтвортой хөгжлийг хангахад төр засаг туслах үүрэгтэй. Төр ямар ч үед тариаланчдынхаа урмыг хугалсан, тэдний хөдөлмөр бүтээлд саад тотгор болсон шийдвэр гаргах ёсгүй. ОХУ-аас улаан буудай худалдан авах салбарын яамны шийдвэрийг тариаланчид их эсэргүүцсэн. Аргагүй юм. Хавар, зун, намаржингаа тариалангийн талбайд борви бохисхийлгүй хөдөлмөрлөснийх нь үр шимийг нэг өдөр үнэгүйдүүлэх гэж байгаад хэн ч дургүйцнэ. Манай намын УИХ дахь бүлэг тариаланчдаа дэмжих хөдөлгөөн өрнүүлж, ХХААЯ-нд албан шаардлага хүртэл явуулсан. Ингэж тариаланчдын дуу хоолойг шийдвэр гаргах түвшинд хүргэсний хүчинд яам тухайн шийдвэрээ цуцалж байх жишээтэй. Миний бие Ерөнхий сайдаар ажиллаж байхдаа Тариалангийн тухай хуульд 2006 онд нэмэлт, өөрчлөлт оруулж, улсад болон гурилын үйлдвэрт тушаасан улаан буудайны нэг тонн тутамд 60 мянган төгрөгийн урамшуулал олгох зохицуулалтыг хийсэн. Энэ нь тариаланчдад нэлээд урам өгсөн болов уу. Тэр үеэс л тариаланчид улам эрвийх дэрвийхээрээ зүтгэж, харин үндэсний олон аж ахуйн нэгж газар тариалангийн салбар руу хөл тавьж, энэ чиглэлээр эрчимтэй ажиллах болсон. Дараа нь Ерөнхий сайд С.Баяр үндэсний аж ахуйн нэгжүүд, тариаланчдын санаа бодол, улсын хэрэгцээ шаардлагыг соргогоор мэдэрч Атрын III аяныг санаачлан эхлүүлсэн дээ. Атрын III аян өргөжин тэлснээр гурилын дотоодын хэрэгцээгээ 100 хувь хангаж, үрийн нөөц, чанар сайжирч, тариалан эрхлэгчдийн техник, технологи сайжирч, гурил, талх, нарийн боовны үнэ тогтвортой болсон шүү. Энэ бол үр дүнгээ улс орны амьдралд ч, ард иргэдийн аж амьдралд ч бодитой өгсөн оновчтой шийдвэр байсан. Иймэрхүү байдлаар хүнсний стратегийн гол нэрийн бүтээгдэхүүний талаар шат дараалсан арга хэмжээ авахаар бодож төлөвлөж байсан санаа оноо бишгүй байсан. Би зөвхөн Төв аймгийнхаа төдийгүй улсын хэмжээнд тариаланчдыг дэмжиж явсан хүн. Цаашид ч тариаланчдаа дэмжих болно.

Хөдөө гэртээ гэргий Ж.Туяацэцэгийн хамт

Тухайлбал, ямар ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байсан бэ?

Дээр дурдсан гурил, хүнсний ногооноос гадна мах, сүү гэх мэт экологийн, эрүүл бүтээгдэхүүний хангамж, үнэ ханшийг тогтвортой байлгах нь хүнсний аюулгүй байдлын хувьд төр засгаас хийх ёстой ажил. Мал сүрэг маань жилээс жилд өсч байгаа ч махны үнэ ханш улам өсөөд л байх шинжтэй. Нийслэлчүүд, цаашлаад Эрдэнэт, Дархан зэрэг том хотууд, аймгийн төвүүдэд махны хомсдол байнга гарах юм. Бид хавар, намартаа нөөцийн махаа борлуулдаг ч энэ асуудлыг бүрэн шийдэж чадаагүй л байна. Суурин газрын ард иргэдээ чанартай мах, сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангахын сацуу нөгөө талаас малчид малынхаа ашиг шимийг хүртэх, байнгын орлоготой болох ач холбогдолтой. Суурин газрын ард иргэд, малчдаа нэгэн зэрэг дэмжсэн ийм тогтолцоог бий болгох зайлшгүй шаардлага бий. “Монгол мах”, “Монгол сүү” аян санаачлан хэрэгжүүлье гэж бид намын сонгуулийн мөрийн хөтөлбөртөө тусгаж байсан. Харамсалтай нь нь энэ санаачилга маань төдийлөн ажил хэрэг болж чадахгүй байгаа. 2016 онд МАН ялсан тохиолдолд бид “Монгол мах”, “Монгол сүү”-ний анхдугаар аяныг улсын хэмжээнд хэрэгжүүлж, монгол брэнд бий болгоно гэж төлөвлөж байна.

Ярилцсан: Л.Энхтуяа

МОНГОЛ УЛСЫН 24 ДЭХ ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛДЫН

ТЭРГҮҮЛСЭН **ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЛИЙН ЗАСГИЙН ГАЗАР**

- Эмхлэн байгуулагдсан огноо: 2006.01.25
- Ажилласан хугацаа: 1 жил 10 сар

НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН 21 ҮЗҮҮЛЭЛТИЙН ХАРЬЦУУЛАЛТ

/Тайлбар: + өсөлт, - бууралт/

№	ҮЗҮҮЛЭЛТ	хэмжих нэгж	2005 ОН	2007 ОН	ӨСӨЛТ, БУУРАЛТ
1	ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ	хувь	7.2 %	**10.2 %**	+3,0 %
2	1 ХҮНД ОНОГДОХ ДНБ	ам.доллар	811	**1 500**	+689
3	НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО	тэрбум төгрөг	837.9	**1 900.0**	+1 062.1
4	ГАДААД ХУДАЛДААНЫ НИЙТ БАРАА ЭРГЭЛТ	тэрбум ам.доллар	2.2	**4.0**	+1.8
5	ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ	сая ам.доллар	298.0	**1 103.0**	+805.0
6	1 АМ.ДОЛЛАРЫН ХАНШ	төгрөг	1 221	**1 165**	-56
7	АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ	их наяд төгрөг	1.5	**3.1**	+1.6
8	БҮРЭН ТЭТГЭВРИЙН ДООД ХЭМЖЭЭ	төгрөг	32 000	**97 500**	+65 500
9	ХУВЬ ТЭНЦҮҮЛСЭН ТЭТГЭВРИЙН ДООД ХЭМЖЭЭ	төгрөг	20 000	**45 000**	+25 000
10	ДУНДАЖ ТЭТГЭВЭР	төгрөг	37 400	**79 900**	+42 500
11	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	тэрбум төгрөг	84.1	**127.0**	+42.9
12	ЯДУУРЛЫН ТҮВШИН	хувь	36.1 %	**32.6 %**	-3.5 %
13	ШИНЭЭР БИЙ БОЛСОН АЖЛЫН БАЙР	тоо	50 000	**69 000**	+19 000
14	ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ДУНДАЖ ЦАЛИН	төгрөг	92 000	**300 000**	+208 000
15	ХӨДӨЛМӨРИЙН ХӨЛСНИЙ ДООД ХЭМЖЭЭ	төгрөг	42 500	**90 000**	+47 500
16	ХАЙГУУЛЫН ЛИЦЕНЗ	ширхэг	7 400 орчим	**3 400 орчим**	-4 000
17	ХӨДӨЛМӨРИЙН БААТАР, АРДЫН ЦОЛТОН, АХМАД ДАЙЧДАД ОЛГОДОГ ТЭТГЭМЖ	жилд/төгрөг	-	**200 000**	+200 000
18	ГАВЬЯАТ ЦОЛТОНД ОЛГОДОГ ТЭТГЭМЖ	жилд/төгрөг	-	**100 000**	+100 000
19	ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	сая төгрөг	100.0	**1 200.0**	+1 100.0
20	ЗАЛУУ ГЭР БҮЛД ОЛГОДОГ ТЭТГЭМЖ	жилд/төгрөг	-	**500 000**	+500 000
21	ЦӨМИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СУДАЛГАА	тэрбум төгрөг	-	**1.0**	+1.0

ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЛИЙН ЗАСГИЙН ГАЗРЫН ХИЙСЭН ОНЦЛОХ 11 АЖЛЫН ТОВЧООН

1 Монгол хүний хөгжил, хийж бүтээхийн үндсийг хангах **“ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН”**, Ерөнхий боловсролын сургуулийн I-V ангийн сурагчдын **“ҮДИЙН ЦАЙ”**, 16.500 айлын орон сууц ашиглалтад оруулсан **“40.000 АЙЛЫН ОРОН СУУЦ”**, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, нэг цэгийн үйлчилгээ бий болгосон **“ЦАХИМ МОНГОЛ”**, **“ЦАХИМ ЗАСАГЛАЛ”**, 4000 орчим км цахилгааны шугам байгуулж, 90 гаруй сумыг байнгын эрчим хүчний эх үүсвэрт холбосон **“ЭРЧИМ ХҮЧ”** зэрэг төсөл, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлжээ.

2 Татварын багц хуулийг цогцоор нь шинэчилж, хүн ам, аж ахуйн нэгжийн орлого, НӨАТ, НДШ-ийн татварын хувь хэмжээг 10 хувь болгон бууруулснаар **Монгол Улс Ази-Номхон далайн бүс нутагт хамгийн бага татвартай улс** болов.

3 Улаанбаатар хотыг аймгийн төвүүдтэй хатуу хучилттай замаар холбох ажлыг эхлүүлж, **540 гаруй км** хатуу хучилттай зам, замын байгууламж ашиглалтад оруулав.

4 Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг Хөшигийн хөндийд **олон улсын нисэх онгоцны буудал** барих талаар Япон Улсын Засгийн газартай гэрээ хэлэлцээр байгуулав.

5 Монголын бүх сумын төвд **үүрэн телефон** холбооны үйлчилгээг нэвтрүүлэв.

6 Өмнөх Засгийн газруудын үед Монгол Улсад хохиролтой нөхцөлтэй байсан Тогтвортой байдлын гэрээг шинэчлэн байгуулж “Бороо гоулд” компаниас аж ахуйн нэгжийн орлогын татвар, нөөц ашигласны төлбөрт **160 тэрбум төгрөг**, “Цайрт минерал” компаниас аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нөөц ашигласны төлбөрт **243 тэрбум төгрөгийг улсын төсөвт** төвлөрүүлэв.

7 Олон жил яригдсан стратегийн томоохон ордууд болох **“Оюутолгой, Тавантолгойн нөөцийг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ”**-ний төслийг Монгол Улс, Монголын ард түмэнд ашигтай нөхцөлөөр боловсруулан УИХ-д өргөн барив.

8 Монгол Улсыг **бүсчлэн хөгжүүлэх** бодлогыг тодорхойлж, бүсийн тулгуур төвүүдийг тогтоож, хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, дөрвөн бүсийн хөгжлийн хөтөлбөр, түүнийг зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэв.

9 “Монгол Улсыг хөгжүүлэх сан” болон улс, орон нутгийн төсвөөс бүс нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжихэд нийт **240.0** орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь сүүлийн гурван жилийн дунджаас даруй **5.3 дахин** нэмэгдсэн байв.

10 Бэлчээр усжуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2006 онд **762**, 2007 онд **1478**, нийтдээ **2240** худаг шинээр гаргасан буюу засварласан байна.

11 Их Монгол Улс байгуулсны 800 жилийн ойн хүрээнд гадаад улс орны төр засгийн **50** орчим төлөөлөгчид, нийт **400** гаруй зочинг хүлээн авав.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН М.ЭНХБОЛДЫН

2008-2014 ОНД ТОЙРОГТОО ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧООН

НЭГ: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ДЭД БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР

— 2009-2011 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын нийт 1 тэрбум 750 сая (гишүүний мөнгө хэмээн нэршсэн) төгрөгийн санхүүжилтээр аймгийн 26 сум тус бүрт 5 худаг, Зуунмод суманд 1 худаг, нийт 131 инженерийн хийцтэй гүний худаг гаргаж сумдын өмчид шилжүүлсэн. 2009, 2010 онд Зуунмод суманд "Эх нутгийн иргэд" ТББ гүний 2 худаг гарган хүлээлгэж өгсөн.

— 2010 оны УИХ-ын гишүүний 1 тэрбум төгрөгөөс 320 сая төгрөгийн санхүүжилтээр худаг гаргаж, үлдсэн 680 сая төгрөгийг аймгийн мэдэлд шилжүүлж бусад шаардлагатай хөрөнгө оруулалтад зарцуулсан.

— Сумдын өрхийн амьжиргааг дэмжих төсөлд 180 сая төгрөг хуваарилсан.

— Аймгийн өрхийн үйлдвэрлэлийг дэмжих санд 70 сая төгрөг хуваарилсан.

— 2012 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын (гишүүний мөнгө) 1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Сэргэлэн сумын нутаг Баруун Зуунмодны аманд Төв нутгийнхаа нийт ахмадуудад зориулсан амралт сувиллын газрын барилгыг бариулан аймгийн халамжийн хэлтэст хүлээлгэн өгсөн.

— "Жи-Мобайл" ХХК-д хүсэлт тавьж хамтран ажилласны дагуу Төв аймгийн 22 сум Жи-Мобайлын үүрэн телефоны сүлжээнд хамрагдаад байна. Хамрах хүрээний хувьд бүх сумдын малчид иргэд энэхүү сүлжээнд хамрагдсан бөгөөд үлдсэн сумдад суурин станц тавих, хөдөө тархалтын хүчийг нэмэх тухай тус компаниас ирүүлсэн мэдээнд дурджээ.

— Угтаалцайдам, Цээл, Сүмбэр, Жаргалант, Баянчандмань, Батсүмбэр, Борнуур зэрэг газар тариалангийн бүс нутгийн сумдад Техник үйлчилгээний дундын нэгж байгуулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн.

— Газар тариалангийн бүс нутгийн 500 орчим тариаланчдад бага оврын трактор, хадлан, тариалангийн дагалдах төхөөрөмжийн хамт хөнгөлөлттэй зээлээр олгуулсан.

— Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 13.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Зуунмод-Налайх, 4-р зөрлөг чиглэлийн хатуу хучилттай авто замын ажлыг амжилттай гүйцэтгэж ашиглалтад оруулсан.

— 2008-2012 онд УИХ-ын гишүүн, Монгол Улсын Шадар сайдаар ажиллаж байхдаа хөрөнгө оруулалт, санхүүжилтийн асуудлыг нь шийдвэрлүүлж байсан, Германы "Сэргээн босголт" банкны зээлээр хэрэгжүүлэх "Нийслэл хотын хүнсний найдвартай байдлыг хангах орон нутгийн тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх төсөл"-ийн хүрээнд Борнуур, Жаргалант, Партизан-Батсүмбэр чиглэлийн 78.8 км хатуу хучилттай авто замын ажил амжилттай өндөрлөж байгаа бөгөөд 2015 онд бүрэн дуусна.

— Улсын хэмжээнд 150 сум шилэн кабелийн сүлжээнд холбогдохоос Төв аймгийн 23 сумын ЗДТГ, сургууль, эмнэлэг, соёлын төвийг интернэт сүлжээнд холбох, иргэдийг WiFi утасгүй интернэтээр хангах ажил хийгдсэн. Одоогоор Мөнгөнморьт, Борнуур, Баян-Өнжүүл, Баянжаргалан сумыг висат, тоон радио релей ашиглан сүлжээнд холбох ажил явагдаж байна.

— 2012 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хуваарилагдсан Зуунмод сумын "Хүүхэд залуучуудын соёл амралтын хүрээлэн"-гийн 1.1 тэрбум төгрөгийн, Баяндэлгэр сумын Соёлын төвийн барилгын 750 сая төгрөгийн санхүүжилт, мөн зарим бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил улс орны эдийн засгийн хүндрэлийн улмаас зогсоод байгаа юм. Царцаасан хөрөнгө оруулалтын асуудлыг сэргээн шийдвэрлэх тал дээр цаашид анхаарал тавин ажиллана.

ХОЁР: ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР

— Аймгийн нэгдсэн эмнэлгийн байрны их засварын ажлын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж байв.

— 2008-2012 онд Солонгосын халамжийн байгууллага, "Эх нутгийн иргэд" ТББ-ын хамтын ажиллагааны хүрээнд Төв аймгийн харьяат зүрхний төрөлхийн эмгэгтэй 3-14 насны 32 хүүхдийг БНСУ-ын Ансан хотын Танвон эмнэлэгт явуулж үнэ төлбөргүй мэс засал, эмчилгээ хийлгэсэн.

— 2010 оны 6 дугаар сард Монгол Солонгосын хамтарсан Ионсей найрамдал эмнэлэгт Төв аймгийн харьяат 13 иргэнд нүдний болорын мэс засал хийх, болор шинээр тавих үнэ төлбөргүй эмчилгээ хийлгэсэн.

— Архуст, Дэлгэрхаан, Өндөрширээт, Алтанбулаг, Сэргэлэн, Мөнгөнморьт зэрэг суманд хүн эмнэлгийн машиныг шинээр олгох асуудлыг ЭМЯ-тай хамтран шийдвэрлэв.

ГУРАВ: НИЙГМИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР

— Хөрөнгө оруулалтыг нь шийдвэрлэснээр Орон сууц санхүүжилтийн корпорацийн санхүүжилтээр Зуунмод суманд 20 ба 38 айлын орон сууц, хуульчдын буюу цагдаагийн хотхон ашиглалтад орж байлаа.

— Орлого багатай, амьжиргааны түвшин доогуур 83 өрхөд гэр олгуулсан.

— 2011 онд аймгийн удирдлагын зүгээс тавьсан хүсэлтийн дагуу 2009-2010 онд тохиолдсон зудын хохирлыг арилгах зорилгоор Төв аймгийн 26 суманд "Эх нутгийн иргэд" ТББ малжуулах төсөл хэрэгжүүлж, сум тус бүрээс 10 өрх, нийт 260 өрхийг баг, сумын ИНХ, ИТХ-аар хэлэлцэж тодруулсны үндсэн дээр сонгон малжуулсан. Нэг өрхөд 10 эм төлөг, 7 эм борлон ногдсон бөгөөд нийт төслийн хүрээнд 2600 төлөг, 1820 борлонг тухайн сумын малчдаас худалдан авч төсөлд хамрагдсан малчдадаа буцалтгүй тусламж хэлбэрээр олгож байсан.

— Төв аймгийн малчид иргэддээ өвс, тэжээл бусад тусламжийн барааг түргэн шуурхай хүргэх ажлыг зохион байгуулахын тулд Зуунмод суманд Улсын Онцгой комиссын нөөцийн салбар шинээр байгуулсан.

— Төв аймгийнхаа зудын байдалтай байсан сумд руу нийт 5 удаагийн тусламжийн цуваа гаргаж 650 тонн өвс, 480 тонн тэжээл болон бусад тусламжийн бараа материалыг хүргүүлснээс гадна аймгийн хэмжээнд байршилтай улсын нөөцийн бүх салбарт шаардлагатай өвс тэжээлийн нөөцийн зузаатгалыг хийх ажлыг зохион байгуулж байсан.

— Баян, Баянцагаан, Батсүмбэр, Бүрэн, Сэргэлэн, Лүн, Угтаалцайдам, Өндөрширээт, Эрдэнэ сумын түүхт 90 жилийн ойн баярын зохион байгуулалтын ажилд хандив, дэмжлэг үзүүлэв.

— Монголын Ахмадын баярыг тохиолдуулан 27 сумын Ахмадын байгууллагад дэмжлэг үзүүлэв.

— 2014 онд тив, дэлхий, олон улсын тэмцээнд эх орон, уул усныхаа нэрийг дуурсган амжилт үзүүлсэн шинжлэх ухааны болон урлаг соёлын залуу зүтгэлтнүүд, тамирчдыг хүлээн

Аймгийн ахмадын сувиллын байр

авч хүндэтгэл үзүүллээ.
— Аймгийн казах иргэдийн "Алтан бүргэд" наадамд хандив дэмжлэг үзүүлсэн.
— 2014 оны 12-р сарын 25-ны өдөр зохион байгуулсан Төв нутгийн залуусын “Алтан шанага” шинэ жилийн цэнгүүний хандивын 2.5 сая төгрөгийг Төв аймгийн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо” ТББ-ын 9 өрхөд сар шинийн тавгийн идээний хамт гардуулж, хүлээн авч хүндэтгэл үзүүлж, цаашид хамтран ажиллах чиглэлээ тодорхойлов.

ДӨРӨВ:БОЛОВСРОЛ, СОЁЛ, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР

— Монголын морин спорт, уяачдын холбооны ерөнхийлөгчийн хувьд Монгол Улсад адууны яам байгуулагдсаны 750 жилийн ойг тохиолдуулан “Морьтон монголчуудГиннессийн дэлхийн дээд амжилт” төслийг санаачлан дэлхийд анх удаа 11125 морьтны жагсаал, 4249 морины уралдааныг амжилттай зохион байгуулсан. Морьтны жагсаалд Төв сайхан нутгаа төлөөлж 3000 гаруй морьтон оролцож, хурдан морины уралдаанд 800 гаруй хурдан хүлгээ сойн хурдлуулсан нь бас нэгэн дээд амжилт байлаа.
— Төв аймгийнхаа бөхчүүдийг дэмжих, амжилтыг нь нэмэгдүүлэх, шинэ залуу бөхчүүд төрүүлэх зорилгоор Баруун Зуунмодны аманд үндэсний бөхийн “Дүнжингарав” дэвжээний цогцолбор байгуулсан. Тус дэвжээнээс Баянхангай сумын харьяат Б.Батмөнх 2011 онд улсын начин, 2013 онд улсын заан, Баяндэлгэр сумын харьяат Ч.Батчулуун 2014 онд улсын начин цол тус тус хүртсэн.
— Монголын морин спорт, уяачдын холбооны ерөнхийлөгчийн хувьд эрлийз адуу болон цэвэр монгол цусны хурдны морьдыг тусад нь уралдуулах, хүүхэдгүй морийг 5 байр ухрааж барих зэрэг шийдвэр гаргасан нь хөдөөгийн жирийн малчид, уяачдын эрх ашигт нийцсэн чухал арга хэмжээ болсон.
— Баянчандмань, Баян-Өнжүүл сумын сургуулийн барилгын ажил, Батсүмбэр, Эрдэнэсант, Эрдэнэ сумын сургуулийн дотуур байрны барилгын ажлын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлсэн.
— Сүмбэр, Цээл зэрэг сумын сургуулийн байрны их засварын ажлын санхүүжилтийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлсэн.
— Бүрэн сумын цэцэрлэгийн барилгын ажил, Эрдэнэсант сумын цэцэрлэгийн байрны өргөтгөлийн ажлын санхүүжилтийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлсэн.
— Баянжаргалан, Баянцагаан, Сэргэлэн сумын малчдын бага насны хүүхдүүдийн сургуулийн өмнөх боловсролд шаардлагатай явуулын гэр цэцэрлэгийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэсэн.
— Эрдэнэ сумын Мэргэжлийн сургалттай дунд сургуулийн байрны барилгын ажил, Баянжаргалан сумын дунд сургуулийн их засварын ажлын хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлсэн.
— 68 хүүхдийг зохих журмын дагуу сургалтын төрийн сангийн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тэтгэлэгт хамруулсан.
— Аймгийн Хөгжимт драмын театрын шинэ барилгын ажлын 9.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэснээр барилгын ажил явагдаж байна.
— Баянцагаан суманд шинээр баригдах соёлын төвийн барилгын ажлын 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2015 оны төсөвт суулгав.

МОНГОЛ АРДЫН НАМЫН ДАРГА М.ЭНХБОЛДЫН
2013-2014 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧООН

— Монголын улс төрийн намууд толхилцож биш ойлголцож ажиллах зарчмын байр суурин дээр **Үндэсний зөвшилцлийг** МАН-ын даргын хувьд санаачлан эхлүүлж, улс төрийн намын дарга нарын түвшинд 8 удаа уулзлаа.
— Дунд хугацааны зорилтоо тодорхойлсон стратегийн **бодлогын баримт бичгийг** боловсруулан баталсан анхны улс төрийн нам боллоо.
— Улс орны тусгаар тогтнол, эв нэгдэл, ард түмний язгуур эрх ашгийг эрхэмлэн эрх баригчдын бодлогын алдааг залруулах, эдийн засгийн хямралаас хохирол багатай гарах зорилгоор **сөрөг хүчнээс эрх баригч хүчин** боллоо.
— **“Ардын индэр”** аяны хүрээнд Удирдах зөвлөлийн гишүүд, УИХ дахь намын бүлгийн гишүүд 21 аймгаараа хоёр удаа тойрч, иргэд сонгогчид, намын гишүүд, дэмжигчидтэй уулзалт хийлээ.
— Шри-Ланка Улсад болсон Ази-Номхон далайн бүс нутгийн 80 гаруй улсын улстөрийн намуудын дарга нарын дээд чуулганд оролцож, МАН нь Ази-Номхон далайн **бүс нутагтаа нөлөө бүхий** тэргүүлэх байр суурьтай улс төрийн хүчин гэдгээ бататгалаа.
— БНХАУ-ын Коммунист намын урилгаар албан ёсны айлчлал хийж ХКН-ын Төв хорооны Улс төрийн товчооны Байнгын хорооны гишүүн, Төв хорооны Нарийн бичгийн дарга нарын газрын Нарийн бичгийн дарга, Намын Төв хорооны захирал, Төв хорооны оюун ухааны соёлын бүтээн байгуулалтын удирдах зөвлөлийн ахлагч Лю Юньшаньтай уулзаж, хоёр улсын хөрөнгө оруулалт, соёл, хэвлэл мэдээллийн салбарын болон хоёр намын хамтын ажиллагааг өргөжүүлэхээр яриа хэлэлцээр хийв.
— Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн ОХУ-ын засгийн эрх баригч Нэгдсэн Орос намын Удирдах зөвлөлийн гишүүн, ОХУ-ын Холбооны Хурлын Холбооны Зөвлөлийн дарга хатагтай В.И. Матвиенког хүлээн авч уулзаж хоёр улсын болон хоёр намын уламжлалт харилцаа, хамтын ажиллагааг эрчимжүүлэв.
— Намын бүх шатны байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлэхээр **“Нэг баг - нэг зорилго”** уриан дор 500 гаруй удирдах ажилтны улсын зөвлөгөөн, 5 бүсийн зөвлөгөөнийг зохион байгуулав.
— Намын хүний нөөцийг чадавхижуулах, бэлтгэх зорилгоор бакалавр, магистрийн зэрэг олгох хөтөлбөрт 150 гаруй оюутан, Монгол Улсын сум тус бүрээс нэг залууг сургах зорилготой **“Манлайлал 500”** хөтөлбөр хэрэгжүүлж байна.



Ноён Лю Юньшаньтай хийсэн уулзалт

Ази-Номхон далайн улсуудын улс төрийн намуудын дээд чуулганд илтгэл хэлэлцүүлэв.

Хатагтай В.И.Матвиенког хүлээн авч уулзав.

УИХ ДАХЬ МАН-ЫН БҮЛГИЙН 2014 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧООН

— Эрх баригчдын алдаатай бодлогын талаар 10 гаруй мэдэгдэл, уриалга гаргаж, олон түмнийхээ дэмжлэгийг авч чадлаа.
— Төсвийн гадуур зарцуулагдаж байгаа “Чингис”, “Самурай” бонд, үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хөрөнгийг **улсын нэгдсэн төсөвт нэгтгэж**, нэг төсөвтэй байх бодлого дэвшүүлэв.
— Ард түмний язгуур эрх ашигт харш хууль бус үйлдлийг тухай бүр нь таслан зогсоож ирлээ. Тухайлбал, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид **100 жилээр газар эзэмшүүлэх, өрийн хязгаарыг ДНБ-ий 90 хувьд** хүргэх гэсэн оролдлогыг таслан зогсоов.
— Үл хөдлөх хөрөнгийн албан татвар, авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын дээд хэмжээг **хоёр дахин нэмэгдүүлэх**, малчин өрх, мал бүхий этгээдээс **албан татвар** авахыг болиулав.
— Хоёр хөршийн тэргүүн нарын Монголд хийсэн айлчлалын үеэр улс төрийн намуудад хандан **эв нэгдэлтэй** байхыг уриалсан уриалга гаргалаа.
— ТЭЦ-5, төмөр зам, Оюутолгой, Тавантолгой зэрэг бүтээн байгуулалтын томоохон **төслүүдийг эрчимжүүлэх** шаардлагыг удаа дараа тавив.
— Санхүүгийн эх үүсвэргүйн улмаас царцаагдсан объектуудын хөрөнгийн асуудлыг шийдэж, улсын төсвийн хөрөнгө оруулалтыг **223 тэрбум** төгрөгөөр нэмэгдүүлж, **149.6 тэрбум** төгрөгийн зардал хэмнэж, агентлагийн дэд дарга, Засаг даргын орлогч, зөвлөхүүдийн орон тоог 345-аар цөөлөв.
— Малчдын тэтгэврийн насыг **таван жилээр** наашлуулах, нийгмийн даатгалын шимтгэлийг **нөхөн төлүүлэх**, малчдын хоршоонд хамрагдах хугацааг **2016 он болгон** хойшлуулах, хоршоонд элсээгүй малчдын **ноосны урамшууллыг** олгох, цалин, тэтгэвэр, тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан **30 хувиар** нэмэх, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох, баялаг бүтээгчдээ дэмжсэн **нэг хувийн татвар** зэрэг хуулийн төслүүдийг өргөн барив.
— **Одонтой эхчүүд, хүүхдийн мөнгийг** танах гэсэн Засгийн газрын бодлогыг тууштай эсэргүүцсэний дүнд эдгээр тэтгэмжийг хэвээр үлдээв.



МОНГОЛЫН МОРИН СПОРТ, УЯАЧДЫН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ М.ЭНХБОЛДЫН 2014 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧООН

— ММСУХ-ны бодлого, үйл ажиллагааны талаар малчид, уяачдын санал бодлыг хүлээн авах зорилгоор цахим орчинд **www.morinerdene.mn вэбсайт, твиттер, фэйсбүүк хаяг, sanalhuselt@horserasing.mn и-мэйл хаяг, 70161618** дугаарын шууд утас ажиллуулж байна.
— 2014 оны 5 дугаар сарын 5-8-ны өдрүүдэд Хонконг улсад зохион байгуулагдсан Азийн морин уралдааны холбооны 35 дугаар бага хуралд оролцож, **ММСУХ-ны “Алтан морь” шагналыг** Ази тивд морин уралдааны үйлсэд онцгой гавьяа байгуулсан эрхэмд олгох Азийн морин уралдааны холбооны дээд шагнал болгосон.
— ММСУХ Засгийн газрын тогтоолтой зуны бүсийн уралдаан зохион байгуулах **5 аймагтай гэрээг шинэчлэн байгуулж**, Тэргүүлэгчдийн баталсан хуваарийн дагуу Холбооны удирдлага, тэргүүлэгчид бүсийн уралдааны зохион байгуулалтад хяналт тавьж ажиллалаа.
— 11125 морьтны жагсаал, 4249 морины уралдаан зохион байгуулж Дэлхийн дээд амжилт тогтоосны 1 жилийн ой, Адууны яам байгуулагдсаны 751 жилийн ойд зориулсан баярыг 2014 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр Төв аймгийн Аргалант сумын нутагт наадам зохион байгуулж, **“МОРЬТОН МОНГОЛ” цогцолборын** шавыг тавилаа.
— Жил бүрийн 8 дугаар сарын 9-ний өдрийг **Монголын уяачдын өдөр** болгон тэмдэглэж байх шийдвэрийг гаргалаа.
— 2015 онд тохиох ММСУХ-ны түүхт 20 жилийн ойг уртан спортын **“Сүлд” телевизтэй байгуулсан** гэрээний дагуу үндэсний утга агуулга бүхий сонирхолтой цуврал нэвтрүүлгүүдийг бэлтгэн хөдөөгийн олон түмэндээ хүргэж байна.
— ММСУХ өнгөрсөн жил Төв, Баянхонгор, Дундговь, Дорнод зэрэг аймаг зохион байгуулагдсан бүсийн уралдааануудын өглөг хишиг болгон 12 өрхөд өргөө цагаан гэр бэлэглэсний дотор **“ДҮНЖИНГАРАВ” уралдааны үеэр Төв аймгийн Аргалант, Баянчандмань, Борнуур сумын 3 өрх хамрагдаж, 3 ихэр хүүхэдтэй Борнуур сумын иргэн Б.Батдоржийнх** өргөө гэртэй болж баяр дээр баяр нэмэв.

Морьтон монголчууд Адууны яам байгуулсны 750 жилийн ойн хүрээнд 11125 морьтныг жагсааж 4249 морь уралдуулж Гиннессийн дэлхийн дээд амжилтыг 2 төрлөөр эзэмшсэн батламжийг хүлээн авч буй торгон агшин

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД М.ЭНХБОЛДЫН
2007-2012 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧООН

2010 оны зудтай өвөл нисэх дээр 15 минутын зайтай гурван Ил-76 онгоц дараалан бууж гадаадын туслалцааг хүлээн авч байлаа.

1. **УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГЫН** хувьд улс орны хэмжээнд гэнэт цаг бусаар тохиосон аюулт, гамшигт байдлын үед үүссэн нөхцөл байдалд шуурхай дүгнэлт хийж, цаг алдалгүй шийдвэр гарган, зөв гарцыг хайх, ард иргэд болон үндэсний баялаг, өмч хөрөнгийг авран хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулж ирсэн.
2. **ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙН АЮУЛААС** урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангахад мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулж, нэгдсэн удирдлагаар хангах эрх, үүрэг бүхий байнгын ажиллагаатай Зөвлөлийг байгуулан ахлан ажиллаж байв.
3. **ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ,** хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль эрх зүйн үндсийг бүрдүүлэх, үндэсний урт болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулах, улс, бүс, орон нутгийн хөгжлийн бодлогыг төлөвлөх, боловсруулах, түүний уялдааг хангах, батлах ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж байлаа.
4. **"МОНГОЛ УЛСЫН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ"**-ын дагуу нутаг дэвсгэрийн хөгжлийн тэнцвэрийг хангах, эдийн засгийн бүсүүдийн хүрээнд бүс нутаг-хот байгуулалтын уялдааг хангах замаар аймаг, орон нутгийн хөгжлийг дэмжих төрийн бодлого, зохицуулалтын тогтолцоог бий болгох зорилго бүхий үндэсний албыг удирдан ажилласан.
5. **"40.000 АЙЛЫН ОРОН СУУЦ", "4000 ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ОРОН СУУЦ"** хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж дуусгав. "100.000 айлын орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх Үндэсний хорооны даргаар ажиллах үедээ энэ ажлыг бусад бүтээн байгуулалтын ажилтай уялдуулж шуурхай хэрэгжүүлэх, хөрөнгө босгох, үндэсний болон гадаадын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах, хамгийн гол нь энэ төсөлд хамрагдаж буй гэр бүлийг банкны 6 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлд хамруулах банк, санхүүгийн нөхцөлийг хангахад анхаарлаа хандуулан ажиллаж байв. Энэ төсөл нэр хаягаа өөрчилсөн хэдий ч өнөөдрийг хүртэл хэрэгжиж байгаа бөгөөд зээлийн хүү нь сарын 8 хувь болсон.
6. **МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН** Үндэсний зөвлөлийн даргын хувьд сургалтын материаллаг бааз суурийг бэхжүүлэх, суралцагсдыг тэтгэлэгт хамруулах, мэргэжлийн боловсрол, сургалтад төр хувийн хэвшлийн түншлэл, салбар дундын зохицуулалтыг хангах загвар гарган мөрдөж, "Эрэлт-сургалт-ажлын байр" хөтөлбөр боловсруулан, ажил олгогчидтой бүхий л шатанд хамтран ажиллах нөхцөлийг хангахад анхаарч байв.
7. **ХОРШООЛЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН АХЛАГЧААР** ажиллаж байхдаа хөдөөгийн үйлдвэрлэгчдийг хэрэглэгчидтэй холбох, сум бүрт жишиг хоршоодыг байгуулах, үйл ажиллагааг нь дэмжих, хоршоодыг хөгжүүлэх, бэхжүүлэх, удирдлагыг сургаж, мэргэшүүлэх, "Сум хөгжүүлэх сан"-г бэхжүүлэх, малчид, тариаланчдын урамшууллын (Үр тарианы, ноос, ноолуурын гэх мэт) тогтолцоог хөгжүүлэх зэрэг асуудалд голчлон анхаарч байлаа.
8. **ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДЭД ТЭРГҮҮНИЙ** албыг хашиж байхдаа нийгэм, ахуйн болон зам, тээврийн осол, дарамт, хүчирхийлэл, хүнд хөдөлмөр, гамшгийн аюулаас сэргийлэх чиглэлээр хүүхдийн эсэн мэнд амьдрах эрхийг хангаж, олон нийтийн оролцоо, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх бүх талын арга хэмжээг аван ажиллаж байлаа.
9. **ДЭЛХИЙ ДАХИНД МОНГОЛООРОО ГОЁЖ,** монгол хүн бүрийн сэтгэл зүрхэнд бахархлын гал асааж байдаг Үндэсний Их баяр наадмыг зохион байгуулах хорооны даргаар 11 жил ажиллав.
10. **2011 ОНД ТУЛГАР ТӨР** үүссэний 2220, Их Монгол Улс байгуулагдсаны 805, Үндэсний хувьсгалын 100, Ардын хувьсгалын 90 жилийн ой зэрэг 4 их түүхт ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх Үндэсний хорооны даргаар ажиллав.
11. **2012 ОНЫ ЛОНДОНЫ ЗУНЫ ОЛИМПИЙН ИХ НААДАМД** оролцсон Монголын үндэсний шигшээ багийн ахлагчаар ажиллаж, манай баг тамирчид түүхэндээ анх удаа 2 мөнгө, 3 хүрэл, нийт 5 медаль хүртсэн амжилтаар монгол түмнээ баярлуулсан юм.

Эрлийз, монгол адууг тусад нь уралдуулах шийдвэрийг 2011.02.23-нд гаргав.

ИРЭЭДҮЙД ТЭМҮҮЛСЭН
ЗУУНМОД

Эх сурвалж: Түүхч Я.Дамдинсүрэнгийн "Төв аймгийн байгаль, түүхийн дурсгалт газрууд"

1733 онд Богд уулын өвөрт баригдсан Манзуширын хийдээс улбаатай Төв аймгийн Зуунмод сум хийдийн тууринаас 7 км зайтай оршино. Төв аймгийн нийгэм, эдийн засгийн төв болохынхоо хувьд Зуунмод ирээдүйд тэмүүлж, аймгийнхаа хөгжлийн түүчээ нь болсоор ирсэн. Хотыг 1942 онд Улаанбаатараас нүүлгэн одоогийн байгаа газарт байгуулж байсан түүхтэй.

МАНЗУШИР ХИЙД

Манзушир гэдэг нь "Оюун билгийн тэнгэрийг сахих бурхан" гэсэн утгатай. Манзушир ламтны анхдугаар дүрийн хувилгаан Лувсанжамбалданзан удирдан 1733 онд Богдхан уулын энгэрт бариулснаар Манзуширын хийдийн суурь тавигджээ.

XYIII зууны сүүлчээр цогчин дуганыг байгуулж, өмнө талд нь Богд уулнаас ус татаж, хиймэл нуур үүсгэжээ. 1760 онд Бадамын дуган, 1770 онд Шар хүрээ хэмээх Богдын ордонг барьж, Хангал, Цогчин, Эргэдэг Майдар, Суварган сүм, Сэрүүн лаврин, Мамба, Цанид, Жүд, Мангал зэрэг сүм дугануудыг уран барилгын гайхалтай шийдлээр байгуулсан байна. Эдгээр сүм Богдхан уулын үзэмжит сайхан байгальтай зохицон нийцэж байсан учраас "Халх Монголын Ар утай" гэж алдаршжээ. XX зууны эхэн үе гэхэд 500 гаруй шавьтай, гавж аграмбын мяндгийг олгодог Монголын нэр нөлөөтэй том хийд болсон байна. Сүмээс үлдсэн хэсэг нь одоо музей болж хадгалагдан иржээ. 200 гаруй жилийн түүхтэй Манзуширын хийдийг 1937 оны хэлмэгдүүлэлтээр нураан буулгах үед 20 барилга байгууламж, 300 лам нартай байжээ. Энэ хийдийн туурь, уулын энгэрийн хадан дээр сийлбэрлэсэн том бурхдын зураг нь түүх соёлын ховор нандин бүтээл дурсгал болж үлдсэнийг 1998 онд улсын хамгаалалтад авсан. Тус музейн зүүн талд 1726 онд аяганы дархан Жалбуу ах дүү нарынхаа хамт урлан бүтээсэн жасын том тогоо байдаг. Нэг удаа 1000 хүний хоол бэлтгэж болдог энэ тогооны амсар нь 215 сантиметр, гүн нь 140 сантиметр, багтаамж нь 1800 литр, хүнд нь 2 тонн ажээ. 1000 хүний хоол бэлтгэхэд нэгмөсөн 2 шарын мах буюу 10 гаруй хонины махыг чанахад 4 тэрэг түлээ түлдэг байжээ.

"Манзушир" байгалийн музей нь 1972 онд байгуулагдсан. Энд байгалийн төрөл бүрийн зүйлс ашиглан Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн Д.Шагдарсүрэн, сурвалжлагч О.Сумъяа нарын урласан бүтээлүүдийг сонирхохоос гадна ан амьтан, араатан жигүүртний чихмэлүүдийг үзнэ. Угсаатны үзмэр болох бүрэн тавилгатай таван ханатай гэрээр орж гэрийн дотоод зохион байгуулалттай танилцан, мал аж ахуйн тоног хэрэгсэл гэх мэт үзмэр болон анчны холтсон урцаар орж үзэх боломжтой.

Газар нутгийн хэмжээ	24.1 мянг.га
Багийн тоо	6
Өрх	4 823
Хүн ам	16 094
Улаанбаатар хотоос	43 км

Малын тоо	56 066
Адуу	6 452
Үхэр	4 997
Тэмээ	7
Хонь	25 491
Ямаа	19 119

АМЖИЛТЫН БУЛАГ
АЛТАНБУЛАГ

Төв аймгийн Сэргэлэн, Баянцагаан, Баян-Өнжүүл, Өндөрширээт, Лүн, Баянхангай, Аргалант гэсэн 8 сум болон Нийслэлийн Хан-Уул дүүрэгтэй хиллэн оршдог Алтанбулаг сум 1936 онд Шархайн хөндийн хойд энгэр, Бор Өндөр уулын өвөрт Данжаалангийн жасын суурин дээр анх байгуулагджээ. 1959 онд Алтанбулагийн амны Туулын дэнж дээр нүүн байрласнаас хойш Алтанбулаг нэрээр сэргээсэн түүхтэй.

ХУСТАЙН НУРУУ

Төв аймгийн Алтанбулаг, Аргалант, Баянхангай сумын зааг нутагт Улаанбаатараас баруун тийш 80 километрт оршдог Хустайн нуруу баруун өмнөөс зүүн хойшоо чиглэлтэй сунаж тогтсон. Хамгийн өндөр цэг нь Хөшөөт уул бөгөөд 1842 метр. Хамгийн нам цэг нь далайн түвшнээс дээш 1190 метр өндөр Тариатын булаг. Хэнтийн нурууны баруун өмнөд салбар уул юм. Хустайн нурууны бүс нутагт байх Хустайн бааз нь өвөл зунгүй ажилладаг бөгөөд тэнд тахь нутагшуулах төсөл хэрхэн хэрэгжиж байгаа талаар баримтат бичлэг үзүүлж, Хустайн бүс нутгийн талаар мэдээлэл бүхий үзэсгэлэнгийн танхим ажиллуулдаг. Хустайн нурууны энэ бүс нутагт 1992 оноос тахь нутагшуулах Монгол Голландын хамтарсан "Тахь" төслийг хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд 900 ам.км нутгийг 1993 оноос улсын хамгаалалтад авсан. Анх 1992 онд 15 тахийг Оросоор дамжуулан авчирсан ба түүнээс хойш 3 жил тутам 18-20 тахь нэмж нийт 84 тахь авчирсан нь өсөж үржсээр эдүгээ 250 гаруй тоо толгойд хүрээд байна. Тахийг Монгол адууны дээд өвөг гэж үздэг. XIX зууны эхэнд Оросын эрдэмтэн Н.М.Прежевальский нээсэн бөгөөд Прежевальскийн адуу гэж бүртгэгджээ.

ИХ ӨЛ ХӨТӨЛ

Ойрдын Амарсанаа, Хотгойдын шадар ван Чингүнжав, Халхын Үй жанжин гурав анд нөхөд байжээ. Тэд Манжийн хааны эсрэг тэмцэлд босохоор нууцаар хэлэлцэн "Энэ үйл хэрэгт амь нас хайргүй зүтгэнэ" гэж ам тангараг тавьсан боловч нууц нь задарчихжээ. Манжийн хаанд алтан хошуу хүрсэн гэдгийг сонссон Амарсанаа даруй зугтааж Шавийн даваагаар гарч, Орос нутаг руу одсон гэнэ. Шадар ван Дархадын нутгаар зуттан гарахаар зүүн хойш мордсон боловч дархадууд элдвээр аргалж саатуулсаар байгаад манжийн цэрэгт бариулжээ. Харь газар баригдан одохдоо Чингүнжав "Энэ хөтлийг даваад хангайгаа орхиж байгаа юм байна. Алтан Туулаас хойш нэгэн сайхан өл залгалаа. Өлзийтэй сайхан нутаг минь" хэмээн шүүрс алдсан гэдэг. Ийнхүү эх нутгаа орхин одсон Шадар вангийн сэтгэлийн хайллаар Өлзийт Их Өл гэх нэр үүссэн гэх домог энэ билээ.

Газар нутгийн хэмжээ	565.2 мянг.га
Багийн тоо	4
Өрх	970
Хүн ам	3 100
Улаанбаатар хотоос	52 км
Аймгийн төвөөс	48 км

Малын тоо	183 741
Адуу	23 427
Үхэр	17 588
Тэмээ	147
Хонь	12 4210
Ямаа	94 906

НААДМЫН ЦУУРАЙТАЙ
АРГАЛАНТ

БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1976 оны 357 тоот тогтоолоор Төв аймгийн Баянцогт сумын нутагт ур тариа, мал аж ахуйн чиглэлийн Нөхөрлөл сангийн аж ахуй байгуулсан бөгөөд түүнд түшиглэн 1977 оны 11-р сарын 11-ний өдрийн 209 дүгээр зарлигаар Аргалант сумыг байгуулсан. Аргалант сум ноолуур сайтай улаан ямаа, цагаан арвай, хөх тариагаараа алдартай.

АРГАЛАНТ УУЛ

Төв аймгийн Алтанбулаг, Аргалант, Баянхангай сумын зааг нутагт Улаанбаатараас баруун тийш 80 километрт орших Хустайн нурууны байгалийн цогцолбор газарт, ойт хээрийн бүс дотор говь нутгийг санагдуулам элсэн манхан бөгөөд 10 орчим километр ам дөрвөлжин талбайг эзэлдэг. Хээтэн долгилох нуурын толиот мандал мэт аясын салхинд намиатан байдаг Молцог элсийг нутгийн зон олон Халхын шар хүйс гэж нэрлэдэг. Хүний аманд ороод ихэнх нь хайлаад алга болчихдог тун нарийн ширхэгтэй энэ нутгийн элс нь давсаг, бөөр, нуруу, үе мөчний өвчнийг илааршуулах үйлчилгээтэй юм. Молцог элсний зах хавиар 50 гаруй зүйл ургамал ургадгийн тал хувь нь эмийн ургамал учраас элсний чанарт нөлөөлсөн гэж үзэх нь бий. Молцог элсээр бөөрний бүх төрлийн эмгэг, мэдрэлийн гаралтай нурууны өвдөлт, үе мөч, ясны сийрэгжилт, түнхний дутуу хөгжил, түрүү булчирхай, архаг ядаргаа, рахит сульдааг эмчилдэг. Аялж амарч яваа зочдын хувьд энэ нутгийн алтан элс аз жаргалын өлгий нь болдог. Элсний зөөлөн түрлэг, далайн давалгаа мэт салхины аясаар бөмбөрч, амар амгалан, сэтгэл тэнүүн сайхан мэдрэмж төрүүлэх ид шидтэй.

Аргалант сум Жирмийн цагаан нуур, Овоот хадан, Агуйт, эртний тахилгатай Алтан толгой уул, авралын дээд өвгөөс шүтсэн Аргал хангай, Овоот хангай, газрын диваажин Ар дулаан, нар дагуулж бүлээсдэг Налгар хан уул, халхын буян хурдан хүлгүүдийн туурайнаас манарсан тоос, хүч шавхсан хөлс, хийморь бадраасан хүүхдүүдийн гийнгоон дуу цуурайтсан Хүй долоон худаг, холын гийчин зорин тэмцдэг Шийр хайрхан, амуу тариа суналзсан их тал, ундаалж өссөн Аргалын булаг, сунаж мөргөсөн Алтан овоот гээд Түшээт ханы Илдэн гүний хошууны түших амь, тэнгэрийн соёрхолт нутаг билээ.

Газар нутгийн хэмжээ	121.0 мянг.га
Багийн тоо	2
Өрх	576
Хүн ам	1616
Улаанбаатар хотоос	82 км
Аймгийн төвөөс	120 км

Малын тоо	100 932
Адуу	7 829
Үхэр	7 603
Тэмээ	13
Хонь	52 911
Ямаа	32 576

АТРЫН АНХДАГЧДЫН ӨЛГИЙ
АРХУСТ

БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1959 оны 129-р зарлигийг үндэслэн Төв аймгийн Хөдөлмөрчдийн Депутатуудын Гүйцэтгэх Захиргаа, МАХН-ын хорооны 1959 оны 4-р сарын 16-ны өдрийн 40/13-р тогтоол гарч засаг захиргааны өөрчлөлт дахин хийгдэх үед Архустын сангийн аж ахуйг түшиглэн Архуст сумыг байгуулсан. Архуст сум 1971 онд Бөөрөлжүүтийн хөндийд барьсан багсармал тэжээлийн үйлдвэрийн дэргэд төвлөрөн суурьшиж, хөгжсөн түүхтэй. Сумын эдийн засгийн гол тулгуур нь хөдөө аж ахуй бөгөөд уламжлалт мал аж ахуйг голчлон эрхэлж байгаа төдийгүй эрчимжсэн аж ахуй эрхлэгч 4 бүлгийн ажил хурдацтай урагшилж байна. Мөн Алтанбулаг үүлдрийн хонь, Баяндэлгэр омгийн ямааг сонгон үржүүлж, цөм сургийн малын тоо толгой 2333-д хүрчээ.

НАГАЛ ХАН УУЛ

Төв аймгийн Архуст сумын нутагт, Улаанбаатараас зүүн урагш 80 километр зайтай оршдог. Жанчивлангийн рашаан амралтын зүүн өмнө оршдог Нагал Хан уул Хэнтийн нурууны өмнө захын төгсгөлийн хэсэг бөгөөд далайн түвшнээс дээш 1970 метр өндөр. Энэ уулын төв хэсгийн 500 га талбайг эзлэх шинэсэн ой нь Хэнтийн нурууны хамгийн урд төгсгөлийн ой юм. Ийм учраас энэ хавийн 31 ам.км талбайг 1957 оноос дархлан хамгаалсан билээ. Манай орны хээрийн бүсэд орших, уулын хээр болон ойт хээр хосолсон өвөрмөц тогтоцтой байгалийн үзэсгэлэн бүрдсэн газар бөгөөд голлох өндөрлөгүүд нь далайн түвшнээс дээш 1700-1800 метр өргөгдсөн байдаг. Нагал Хаан уул нь геологийн тогтоцын хувьд герциний атриат уул юм. Ашигт малтмалаар баялаг уул бөгөөд алаг гантиг, шохойн чулуу, цагаан гантиг, усан болор, утаат болор, маргад, цагаан тугалга, гянт, өнгө бүрийн аргай бий. Нагал Хаан уулын ойн бүсэд шинэснээс гадна улиангар, улиас, хус, хусан торлог цагдуул гэх мэт мод бут бага зэрэг ургадаг. Дэгд, бамбай, таван салаа, тарваган шийр, сөд, ганга, нохойн хошуу, мэхээр зэрэг эмийн болон бэлчээрийн ургамал элбэг.

Буга, бор гөрөөс, үнэг, чоно, мануул, тарвага, зурам, өмхий хүрэн, туулай, үхэр огодой, элдэв оготно зэрэг амьтадтай. Нагалхаан уул түүхийн дурсгалт зүйлсээр нэлээд баялаг бөгөөд эртний болон Түрэг овог аймгийн булш, хиргисүүр их байдаг.

Газар нутгийн хэмжээ	82.7 мянг.га
Багийн тоо	2
Өрх	410
Хүн ам	1 254
Улаанбаатар хотоос	104 км
Аймгийн төвөөс	108 км

Малын тоо	40 908
Адуу	5 264
Үхэр	3 773
Тэмээ	2
Хонь	29 217
Ямаа	21 204

БАЯЛАГ САЙХАН

БАТСҮМБЭР

Түшээт Хан аймгийн Баатар вангийн хошуу, одоогийн Батсүмбэр нь “Хөдөө аж ахуй, мал аж ахуйн гаралтай экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэгч” болохоор зорин ажиллаж байна. Тус сумын эдийн засгийн гол салбар, хөгжлийн түүчээ нь бэлчээрийн болон хагас эрчимжсэн мал, сүүний аж ахуй, жимс жимсгэний тариалалт, зөгийн аж ахуй, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл юм.

Батсүмбэр сум нийт 243.1 мянг.га талбайг хамарсан нутаг дэвсгэртэй бөгөөд үүнээс 95.3 га бэлчээр, 2.1 га тариалангийн талбай,137.6 мянган га ой мод эзэлдэг. Хэнтийн нурууны салбар уул бүхий нутгийн 51.1 хувийг эзэлдэг тус сум Өлгий Шатан, Сөгнөгөр, Баянгол, Хүй Мандал, Бургалтай, Хунцал, Хужирт зэрэг уулсаар хүрээлэгдсэн байгалийн үзэсгэлэнт газар юм.

АСРАЛТ ХАЙРХАН

Монгол оронд гурван их уулс бий. Энэ бол Алтай, Хангай, Хэнтий. Монголчууд бид энэ их уулсаа үеийн үедээ шүтэн биширч, түшин аж төрж, бахдан дуулж ирсэн ард түмэн билээ. Хан Хэнтийн нуруу бол энэ гурвын нэг нь. Төв, Сэлэнгэ, Хэнтий гурван аймгийн арав гаруй сумын нутгийг дамнан орших энэ их уулс бол хүний хөл ховорхон хүрсэн онгон дагшин сарьдагууд, хүүхэрэн шуугих хөвч тайга, хүйтэн булаг нь бургилах хавцал хөндий, булга, минж, буга, баавгайнаас эхлээд зүйл бүрийн араатан жигүүртэн хөлхөлдсөн ихийн их тайга энд бий. Чухам энэ их уулсын оргил тэргүүн нь Асралт хайрхан. Далайн түвшнээс дээш 2799 метр өндөрт өргөгдсөн энэ оргил нийслэл Улаанбаатараас 72 км-ын зайд оршино. Гэхдээ газрын зураг дээр шулуун шугамаар тэр шүү дээ. Хэнтийн нурууны ноён оргил Асралт Хайрхан нь байгалийн үзэсгэлэн бүрдсэн бөгөөд далайн түвшнээс дээш 2800 метрийн өндөрт дүнхийнэ. Жилийн дөрвөн улиралд цас мөсөн дуулгатайгаа цавцайх энэ оргилыг зорьсон хэн хүнгүй намаг шавар, өндөр даваа, энхэл донхол ихтэй замыг туулах хэрэгтэй болдог ч тийшээ цуврах аялагчдын цуваа тасардаггүй. Энэ уулыг их уулсын зангилаа гэж тодорхойлох нь бий. Аялагчид Төв аймгийн Батсүмбэр сумаас цааш явсаар Сөгнөгөрийн гол, Хүрхрээгийн гол нийлэх бэлчирт хүрэх бөгөөд эндээс ихэнх аялагчид явганаар аяллаа үргэлжлүүлдэг. Ан гөрөө элбэгийн зэрэгцээ жимс самар арвинтай Асралт хайрхан уулнаас Заан, Тэрэлж, Сөгнөгөр голууд эх авна.

Газар нутгийн хэмжээ	243.1 мянг.га
Багийн тоо	4
Өрх	2 062
Хүн ам	6 787
Улаанбаатар хотоос	98 км
Аймгийн төвөөс	140 км

Малын тоо	68 482
Адуу	6 339
Үхэр	20 354
Тэмээ	12
Хонь	23 885
Ямаа	17 892

ХҮЛГИЙН БУЯН ХУРСАН

БАЯН

Богд Хан уулын хошуунд Баян сум, Зогсоол, Жаргалант, уулын хошуунд Авдарбаян сум нэртэйгээр байгуулагдсан. Баян сум нь “Өвөр шаварт” гэдэг газар байрлаж байгаад 1956 онд Төмөр замын Мааньт өртөөн дээр төвлөрөн нэгдэж нэг сум болжээ.

ХАНГАЙН БУЛГИЙН ЦОГЦОЛБОР

Хангайн булгийн хүн чулуу Баян сумын хойд хэсэг, Их Бага хоёр Хангайн хооронд, булгийн эхэнд /ХӨ 47° 27´, ЗУ 107° 32´/ байдаг. Болхи хийцтэй, хоорондоо 20-иод метр зайтай 2 хүн чулуун хөшөөг 1994 онд улс хамгаалалтад авсан бөгөөд эл газрыг нутгийнхан Баянхангайн Хангайн булаг гэдэг. Босоо хэлбэрийн, зассан чулуун дээр хүний нүүр царайг болхидуухан хийцээр дүрсэлсэн энэхүү хүн чулууны эргэн тойронд байсан булшийг ухаж хөндсөн болов уу гэмээр харагдана. Хангайн булгийн цогцолборын хүн чулууны хийц хэлбэрийг судалж, хэзээ бүтээгдсэн гэх он цагийг тогтоогоогүй байгаа. Энэ хэсэг газартай ойролцоо Булштын ам гэх газар бий бөгөөд энд дээрээ хүн чулуу байхгүй том дугуй булш байдаг. Гэхдээ үүний дээхнэ талд хоорондоо ялимгүй зайтай эр, эм хоёр хүний нүүр царай, дүр төрхийг үл мэдэгдэм байдлаар ухаж дүрслэн сийлсэн хоёр жижиг хөшөө байдаг.

БАМБАР ЭРДЭНЭ ХУВИЛГААНЫ ХИЙД

Энэ хийдийг нутгийнхан Ламын хүрээ гэх нь ч бий. Анх Төр Гэрэлтийн 13-р он буюу 1833 онд Үнээ уулын өвөрт байгуулсан байсныг 20 шахам жилийн дараа Эрээдэн уулын ард зөөсөн гэж үздэг. Баян уулнаас зүүн тийш тун ч холгүйхэн сүм хийдийг нурааснаас хойш Суурин гэж нэрлэх болсон газарт энэ хийдийн туурь бий бөгөөд цагтаа цогчин дуган тэргүүтэй хэд хэдэн хурлын сүм дугантай, суваргатай олны хөлтэй, байнгын хуралтай томоохон цогцолбор байсныг гэрчлэх ул мөр одоо ч бий.

Бамбар Эрдэнэ хувилгааны анхны дүр Түвдэд тодорч байсан нь чулуун хуруут Азар гэгч байсан гэдэг. Тэрсүүдүүд түүний амийг авахаар хортой идээ өгчээ. Азар хувилгаан өнөөх хортой ундаанд нь хуруугаа дүрэхэд хуруу нь чулуу болж энэ цагаас хойш түүнийг чулуун хуруут Азар гэх болжээ.

Бамбар Эрдэнэ хувилгаантай хөөрөглөв.

Газар нутгийн хэмжээ	290.5 мянг.га
Багийн тоо	3
Өрх	654
Хүн ам	2 063
Улаанбаатар хотоос	100 км
Аймгийн төвөөс	85 км

Малын тоо	110593
Адуу	11 484
Үхэр	6 212
Тэмээ	112
Хонь	55 588
Ямаа	37 197

ЦУУТНУУДЫН ӨЛГИЙ
БАЯН-ӨНЖҮҮЛ

Түшээт Хан аймгийн Дайчин бэйсийн хошуу нь 1973 онд АИХ-ын Тэргүүлэгчдийн 193-р зарлигаар Баянбараат, Өнжүүл 2 сум нийлж Их хайрханы уурхайн төвд байгуулагдсан нь Төв аймгийн Баян-Өнжүүл сум болжээ.

ЗОРГОЛ ХАЙРХАНЫ ДОМГУУД

Зоргол хайрхан уулын бараааханд 1202 оны намар Чингис хаан, хуурай эцэг Тоорил ханы хамт нэгэн намрыг өнгөрөөж, эцэг хүүгийн ёс барилдаж, андгай тангараг өргөсөн гэж “Монголын нууц товчоо”-нд гардаг билээ.

Энэ хавийн нутаг арвин баялаг домог үлгэртэй билээ. Эрт урьд цагт хангай, говийг хамарсан нэгэн их цасан шуурга болж, хандгай буга, зээр, гөрөөс цөм уруудан өмнө зүг цувран явж байжээ. Хамгийн эхэнд явсан бугын сүрэг нэгэн талд зогссон нь Их газрын чулуу болж гэнэ. Дараагийн хэсэг буга зогссон нь Бага газрын чулуу гэнэ. Хамгийн сүүлд улдаж ядарсан ганц зоргол оцойсхийгээд зогсож хоцорсон нь Зорголхайрхан болжээ. Ижил сүргээсээ улдаж хоцорсон ганц зоргол их уурталй байснаас Зоргол хайрхныг догшин хайрхан гэх болжээ.

Зорголхайрханд том, жижиг гурван агуй байх бөгөөд хамгийн томыг нь Шижирбаатарын буюу Дансрангийн агуй гэнэ. Хангайн баруун талын үргэлжилсэн уулыг Баянгийн хэц гэнэ. Чингисийн намаржаа жуулчны баазын хойд талын уулыг агуйт гэнэ. Дээрээс нь дүүжингээр ордог хаалга бүхий агуй юм. Халх Монголын нутагт байдаг үзэсгэлэнт сайхан боржин чулуун уулсын нэг нь энэ Хангай билээ.

Зорголхайрханы чанх урд тусгайдуу байдаг хадтай толгойг Морин цохио гэнэ. Энэ цохиог нутгийнхан жил бүрийн зуны эхэн сарын шинийн 8-нд тахин бэсрэг наадам хийдэг уламжлалтай. Ялангуяа хурдан морьтой хүмүүс морио авчирч “хийморийг нь сэргээдэг”. Морин цохио гэдэг нь хадтай ангалаар нэгэн морь доош бууж ирж байгаа хэлбэртэй цохио аж.

Эрт цагт энэ нутагт амьдарч байсан Шижирбаатар гэгч сайн эр хоёр алтан гадас шаан зэл татаад гүү барин зусаж байжээ. Гэтэл нэгэн өдөр гүү сааж байсан хүн хувинтай сүүгээ унаган асгахдаа хайран юм гэж дуу алдсан нь Харийн нуур болон хувирсан ажээ. Зэлний хоёр алтан гадас нь баруун, зүүн хоёр Алтан овоо болжээ. Харийн нуурын зүүхэнтээ болон нуурын баруун талд харгалдаа харагдах хоёр овоог Алтан овоо гэдэг.

Газар нутгийн хэмжээ	479.1 мянг.га
Багийн тоо	3
Өрх	643
Хүн ам	2 086
Улаанбаатар хотоос	150 км
Аймгийн төвөөс	110 км

Малын тоо	29 4031
Адуу	20 326
Үхэр	11 504
Тэмээ	323
Хонь	150 071
Ямаа	111 807

БӨХИЙН ХИЙМОРЬ ТЭТГЭСЭН
БАЯНЧАНДМАНЬ

Түшээт Хан аймгийн Баатар вангийн хошуу өдгөө Төв аймгийн Батсумбэр сумыг анх Замтын нэгдэл гэж байгаад хожим Баянчандмань гэж нэрлэх болсон байна. Сум 4000 гаруй хүн ам, 60 орчим мянган толгой малтай, нийтдээ 61,3 мянган хавтгай дөрвөлжин км нутагтай. Үүнээс 14 мянган га газар ой модоор бүрхмэл. 3780 шахам га газар тариалангийн талбайтай. Вольфром буюу гянтболдын уурхайтай. Бүр социализмын үеэс л Унгартай хамтран ашиглаж байсан баялаг нөөцтэй гэгддэг.

ИХ СҮҮЖ ХАЙРХАН

Ардын төрийн их наадмын сүр нэгэн хүч болох хүчит бөхчүүдийн эрч хүч энергийн төв нь Их Сүүж хайрхан билээ. Сүүж гэх нэр нь эх үрийн сүжрэл гэсэн үгнээс улбаатай бөгөөд нутгийн зарим хүмүүс Эхийн уул, Далан хоёр гэж нэрлэх нь ч бий. Эл уулнаас хойгуур Борхужирын гол урсдаг. Эн гол цаашлаад урагшлахаараа Бөөрөлжүүтийн гол гэж нэрлэдэг бол цаашлаад Бороогийн гол болж Хараагийн голд цутгадаг. Борхужирын хөндийн хоёр талаар Их Бага Сүүж, Шар, Бөөрөлжүүт, Дал, Зур зэрэг ус булагтай үржил шим сайтай амуудад 18-р зууны үеэс харь нутгаас ирсэн цагаачид суурьшин тариа, ногоо тарьж амин зуулгаа залгуулдаг байсан

гэдэг. Нутгийн зүүн захаар далайн түвшнээс дээш 1759 метр өндөрт өргөгдсөн Тусгалт, 1758 метрийн өндөр Согоот зэрэг их ойтой уулс сүндэрлэдэг. Нутгийн баруун хойд зах нь Гунын Цагаан даваа бөгөөд энд гянт болдын нөөц байгаа нь судлагдсан юм.

Газар нутгийн хэмжээ	61.3 мянг.га
Багийн тоо	3
Өрх	1 245
Хүн ам	4 099
Улаанбаатар хотоос	70 км
Аймгийн төвөөс	110 км

Малын тоо	48 103
Адуу	4 346
Үхэр	8 802
Тэмээ	11
Хонь	19 174
Ямаа	15 770

ИХ НАЙРАГЧИЙН ӨЛГИЙ
БАЯНДЭЛГЭР

Түшээт хан аймгийн Дархан хошой чин ван Пунцагцэрэнгийн хошууны харьяанд 1923 онд Гүн сум нэртэйгээр анх байгуулагдаж байсан Баяндэлгэр сум 1924 онд Баяндэлгэр уулын сум нэртэй болж, 1931 онд одоогийнхоо нэрийг хүртжээ.

ГҮН ГАЛУУТАЙ

Дэлхийд маш ховордсон биологийн төрөл зүйлүүдээр баялаг Гүн Галуутайд Монгол Улсын шувуудаас дэлхийн "Улаан бүртгэлд"-д орсон 28 зүйлийн 9-тэй нь тааралддаг. Тэдгээрээс хамгийн ховор буюу 20-30 жилийн дараа устаж болзошгүй дэлхийд тус бүр нь 3000-5000 толгой үлдсэн сибирийн цагаан тогоруу, цэн тогоруу юм. Цэн тогоруу нь жил бүр Цэнгийн бүрдэд өндөглөдөг. Мөн ховор шувуу болох хар тогоруу, япон буюу алаг тогоруу хааяа үзэгддэг. Хошуу галуу, Усны цагаан сүүлт бүргэд зэрэг дээрх бүртгэлд орсон шувууд харьцангуй олон тоотой байдаг.

Манай улсад 14 зүйлийн шавьжаар хооллогч, 12 зүйлийн далавчтан, 4 зүйлийн харх, 3 зүйлийн туулай, 65 зүйлийн мэрэгч, 22 зүйл махчин амьтан, 14 зүйл туурайтан амьтан, 75 зүйл хөхтөн байдгаас 35 зүйлийн хөхтөн амьтан нь Монгол Улсын Улаан номонд бүртгэгдсэн байдаг. Гүн Галуутайд 63 зүйлийн хөхтөн, 107 зүйл шувуу, 3 зүйл хэвлээр явагч болон 38 зүйлийн загас байдаг.

Гүн Галуутайд дэлхийн улаан номонд бүртгэгдсэн 13 зүйлийн амьтан байгаа бөгөөд тэдний 2 нь хөхтөн, 10 нь шувуу юм. Монгол Улсад 427 зүйлийн шувуу бүртгэгдсэнээс 28 нь дэлхийд нэн ховор буюу Улаан номонд бүртгэгдсэн байдаг. Тэдгээрийн 35,7 хувь нь Гүн Галуутай хэмээх жижигхэн байгалийн нөөц газарт байдаг нь үнэхээр гайхалтай. Энэ нь Гүн Галуутай бол экосистемийн хувьд маш үнэтэй, давтагдашгүй өвөрмөц онцлогтой болохыг илтгэдэг.

Түүхэн үйл явдал. Гүн Галуутайд Их Монгол Улсын үед буюу XIII зууны үеэс эхлэн түүхийн онцгой үйл явдлуудын гэрч болсон маш олон газар бий. Энд Чингис хаан болон түүний ойр дотны хүмүүсийн амьдарч байсан ба тэдэнд тохиолдож байсан үйл явдлууд маш их. Жишээлбэл: Монголын нууц товчоонд өгүүлснээр:

—1190 онд Жалама уулын өвөр буюу Өлгийбулагт байсан Жамухын дүү Тайчар Саарь хээрт байгаа Чингис хааны Зүчи-Дармалагийн адууг дээрэмдэж, улмаар Зүчи-Дармала очиж адуугаа авахдаа Тайчарыг харван алсан байна. Монголд хэд хэдэн саарь хээр байсан ба үүний нэг нь Хэрлэн мөрний хавьд буюу одоогийн Багануур, Гүн Галуутайгаас Бөөрөлжүүтийн хөндийн өргөн уудам нутгийг хэлдэг байна.

Газар нутгийн хэмжээ	214.6 мянг.га
Багийн тоо	2
Өрх	534
Хүн ам	1 330
Улаанбаатар хотоос	101 км
Аймгийн төвөөс	115 км

Малын тоо	155 672
Адуу	13 179
Үхэр	10 099
Тэмээ	146
Хонь	84 047
Ямаа	48 201

ЦОГ ХИЙМОРИЙН ЭХТЭЙ
БАЯНЖАРГАЛАН



Хуучнаар Сэцэн Хан аймгийн Сэцэнчин вангийн хошуу шинэ цагийн засаг төр үүсч, хошуудыг сум болгон өөрчлөхөд адууны цог хийморийн Нялга уулаараа нэрлэгдсэн Нялга сум 1923 онд 16 арван, 154 өрх, 633 хүн ам, 32 мянган малтайгаар үүсгэн байгуулагджээ. Тухайн үеийн нийгмийн байгуулалт, цаг үеэс хамаарч татан буугдаж, Баян-Эрхтий уулынхаа "Баян", Жаргалант уулынхаа "Жаргалан"-гаар овоглон 1960 онд Баянжаргалан сум "Баясгалант" уулын энгэрт дахин байгуулагдсан гэдэг.

ГУА ДОВ

Бидний өвөг дээдсийн цогцлон бүтээсэн олон арван хот суурины дурсгалын нэг нь Гуа дов хэмээх эртний хотын туйр юм. Уг дурсгал Төв аймгийн Баянжаргалан сумын нутаг Хэрлэн мөрний баруун этгээд Цагаан арал гэдэг газар байдаг. Гуа дов бол Монголын аман зохиол, түүх сударт Бурхан Халдун уул, Онон, Хэрлэн мөрнүүдтэй эн зэрэгцэн дурдагдаж ирсэн агаад аман домогт Чингис хааны отгон охины орд харш хэмээн дурдагдаж ирсэн түүхт газар билээ. Гуа довыг 1920-иод онд Судар бичгийн хүрээлэнгийн анхны дарга Онходын Жамъян нутгийн ард түмнээс сурвалжлан мэдэж анх олж үзсэн гэх бөгөөд 1952 онд тэнд эртний судлаач Х.Пэрлээ малтлага хийж холбогдох он цагийг Хүннү гүрний үе буюу Х.Т.Ө II зуун - Х.Т I зуунд хамааруулжээ. 1952 онд археологийн шинжилгээ хийх үед уг суурин нь өмнө, хойд талдаа их хаалганы ор бүхий дөрвөлжин шороон хэрэмтэй, хэрмэн дотор түүнд тулгаж дотогш харуулж барьсан бяцхан барилгын оромтой, мөн хэрмийн төв хэсэгт "Гуа дов" хэмээн нэрлэгдсэн 3 м өндөр, 4 м өргөн, 56 м урт хэмжээтэй том шавар барилгын ор үлдэцтэй байжээ. Тэр үед Гуа дов хэрэм хэмжээгээрээ хойноос урагш 367 м, баруун зүүн тийшээ 360 м, хэрмийн өргөн 3,5-7,5 м, өндөр нь 50-70 см байсан бөгөөд Х.Пэрлээ энд нийтдээ 12 газар малтаж, дагтаршуулсан шавар шалд суулгасан барилгын баганын суурь чулуу үлдсэн байсан бөгөөд холбогдох он цагийг нарийвчлан тогтоох боломжтойг илрүүлж, дээврийн ваарны хагархай, ширмэл ширдэгний хээтэй дөрвөлжин тоосгоны хэлтэрхий, шатсан туйпуу олныг гарган, хятад үсгийн хээтэй төмөр товч, шаазан савны хагархай зэрэг сонирхолтой олдворууд олсон.

Мөн шинжилгээний явцад хэрмийн зүүн урд өнцгөөс 190 м зайд нэгэн барилгын үлдцийг малтахад зүүн тийш хандуулан, хоёр хөлийг атийлгаж, нүүрийг хойд зүг харуулан, гар биеийг дагуулан баруун хажуугаар нь тавьж, чулуун зэвсгийн эцсийн үед холбогдмоор сумны ясан зэв дагалдуулсан оршуулга илэрчээ.

Газар нутгийн хэмжээ	237.6 мянг.га
Багийн тоо	3
Өрх	494
Хүн ам	1 571
Улаанбаатар хотоос	168 км
Аймгийн төвөөс	160 км

Малын тоо	160 326
Адуу	13 451
Үхэр	6 042
Тэмээ	393
Хонь	88 513
Ямаа	51 927

ЗАЛУУСЫН ӨЛГИЙ

БАЯНХАНГАЙ

Баянхангай сум хөгжил дэвшлийн өлгий юм. Унан босон торнисон Уран цэнхэрийн хөндий, урсгал ус нь саваа халин мэлтэлзсэн Уртрагийн гол, уужим холоос зүүдлэгдэх Улаан хадны буйраараа нутгийн олон бахдан бахархдаг.

УЛААН ХАДНЫ ТУЛААН

Хөрс нь зос ихтэй учир улайран харагддаг энэ нутгийн Их Бага Улаан хадын ууланд 1921 онд Хиагт хот орчимд гамингууд ардын журамт цэрэгт бут цохигдон зугтахдаа шивээлсэн байна. Нийслэл хүрээнээс Сундуй гүний удирдсан цэргийн анги тосон очиж, хүрээлэн авч энд түүхэнд Улаан хадны тулаан хэмээн нэрлэгдэн үлдсэн тулаан болжээ. Зарим номонд энэ тулааныг партизан Тогтохын удирдсан цэрэг хийсэн гэж тэмдэглэн үлдээсэн нь ч бий. Ямартай ч энд нутгийн энгийн ардуудыг хоморголон устгаж байсан гурван мянга гаруй гамин цэргийг хиар цохисноор Ардын хувьсгалын нэгээхэн ялалт энд тохиосон гэдэг юм. Нутгийн буурлууд энэ тухай Хадын өврийн хэд хэдэн хонхорт гамин цэргийн хэрэглэж байсан буу, сумны хонгио зэрэг зэвсгийн үлдэгдэл саяхныг хүртэл байсан гэдэг.

Улсын заан Б.Батмөнхийн амжилтыг мялаав.

Газар нутгийн хэмжээ	100.7 мянг.га
Багийн тоо	2
Өрх	471
Хүн ам	1 404
Улаанбаатар хотоос	105 км
Аймгийн төвөөс	150 км

Малын тоо	96 213
Адуу	6 179
Үхэр	5 955
Тэмээ	-
Хонь	49 371
Ямаа	34 708

ХИЙМОРЬ ДАЛЛАСАН

БАЯНЦАГААН

Төрийн наадамд торгон жолоо өргүүлсэн алтан туурт хулгуудийн өлгий нутаг Баянцагаан сум 1924 онд Авхаа уулын отог, Баянцагаан уулын отог хоёрыг нийлүүлэн одоогийн 3-р багийн нутаг Элэгний Хөх ус гэдэг газар 2 гэртэйгээр байгуулагдаж, сумын анхны даргаар Сэрээтэр зайсанг сонгосож байсан түүхтэй.

ГАШУУН БАЛСТАЙН ХӨШӨӨ

Сумын төвөөс урагш Бага Элгэн гэдэг газар байдаг засмал боржин чулуу байх агаад түүн дээр тогос шувуу, дээд талд нь урд урдаасаа харсан өндөгөө дарсан байдалтай бүргэдийг дүрслэн сийлсэн байдаг. Нутгийн иргэд үүнийг өндөр дээд хэргэмтэй язгууртан хатны булш гэж үздэг. Харин сумын төвөөс 20 орчим километрийн зайтай Зогсоолын уулын зүүнтээх Шивээт уулыг Чингис хааны цэргийн харуул байсан гэх нь бий. Энэ уулын оройн шивээг хоёр хүн ухаж байтал том чулуун таглаа байсан гэнэ. Түүнийг нээхээр оролдож байтал морь унасан хүн гэнэтхэн гарч ирээд удалгүй ор сураггүй алга болсон гэнэ. Нутгийн эрдэмтэй ламд энэ тухайгаа хэлэхэд "Уулын эзэн нь байжээ. Дахиад битгий оролдоорой" гэсэн тухай яриа домог болон яригддаг.

Энэ мэт эртний дурсгалт газрууд Баянцагаан суманд олон бий. Түүний нэг болох Гашуун Балстайн хөшөө сумын нутгийн хойд хэсэг, Хулгар зурхайчдын хөндийн зүүн хойд захад байдаг. Энэ бичигт хөшөө дурсгалыг 1998 онд улсын хамгаалалтад авсан.

УУЛСЫН НУТАГ

Баянцагаан сум дээхнэ үед Авхай уулын хошуу гэж нэрлэгддэг байсан бөгөөд өдгөөгийн сумын төвийн зүүн өмнөд талд Авхай-Овоот гэх уулыг эртнээс тахиж шүтэж ирсэн юм. Мөн түүнчлэн энэ нутагт Сүүжийн цагаан овоо, Балир, Зогсоол, Дуут толгой гэсэд олон сайхан уул нурууд бий. Сумын нутгийн баруун хэсэгт байх Үйзэн нуурын хонхорт Үйзэнгийн говь гэдэг нэртэй говирхог хөндий байдаг нь Монголын төв хэсгийн хээрийн бүсийн хамгийн арын говь нутаг юм. Мөн Баянцагаан суманд Зогсоолын хүйс (одоогийн аймгийн төв байгаа газар) Хөтөл нуур, Чавчирын хөндий, Өлзийт нуур, Өвөр зүлэгтий зэрэг газруудад жас, хурал байсан.

Газар нутгийн хэмжээ	647.6 мянг.га
Багийн тоо	5
Өрх	612
Хүн ам	1 803
Улаанбаатар хотоос	158 км
Аймгийн төвөөс	113 км

Малын тоо	186 383
Адуу	13 759
Үхэр	6 271
Тэмээ	257
Хонь	96 515
Ямаа	69 581

БАЯЛАГ ЦОГТОЙ

БАЯНЦОГТ

Төв аймгийн Баянцогт сум 1911 оноос Түшээт хан аймаг Илдэн вангийн хошуу, 1923-1931 онд Богд хан уулын аймгийн Халиугчин Боролзой уулын хошуу Тамгын газар, улмаар Баянцогт уулаараа нэрлэн Өвөр дулааны энгэрт 1929 онд байгуулагдсан түүхэн замналтай Монгол Улсын анхны сум, суурингуудын нэг билээ.

ГУНА ХАЙРХАНЫ ДОМОГ

Баянцогт сум Манжийн ноёрхлын үе 1719 онд Түшээт Хан аймгийн Зоригт вангийн хошуунаас тасарч байгуулагдсан Сүжигт вангийн хошуунд хамаарагдах бөгөөд “Туулын гүний хошуу” гэж нэрлэдэг байсан гэдэг.

Жирэмийн хөндийгөөс хойш алсаас харахад хэвтэж байгаа үхрийн хэлбэртэй харагдах элгэн улаан хадтай уулыг Хүүхэн Гуна гэдэг. Гэхдээ нутгийн олон нэрээр нь хэлэхийг цээрлэдэг болохоороо Гуна хайрхан гэж нэрлэсээр иржээ. Ингэж нэрлэсний учир нь Хүүхэн хутагт гэгч нэгэн Барга нутгаас 33 шарга морь хулгайлж энэ нутгаар тууж явахад араас нь хөөж явсан хүмүүс нэхэн ирж гүйцэхийн хэрд энэ ууланд нуугдсан юм байна. Хүүхэн хутагт Амарбаясгалант

хийдийн баруунтаа байдаг Салуужин гэх өндөр бартаатай даваанд давж Сэлэнгэ мөрнөөр гатлан явсанд хөөж явсан хүмүүс зүрх алдан буцжээ. Урд талаасаа эгч элгэн хадтай, ар талаасаа хүн мал чөлөөтэй гарах боломжтой уулын оройн ирмэглэсэн өндөр хадны ар ёроолд том тогооны амсар хэртэй хонхорт тунгалаг булагтай цөөн хусан төгөлтэй, зүлэг ногоотой байдаг. Энэ хус моднуудаас Хүүхэн хутагт 33 шарга морио уяж байсан гэнэ.

Газар нутгийн хэмжээ	147.2 мянг.га
Багийн тоо	3
Өрх	651
Хүн ам	1 841
Улаанбаатар хотоос	90 км
Аймгийн төвөөс	135 км

Малын тоо	108 084
Адуу	8 742
Үхэр	8 675
Тэмээ	135
Хонь	55 614
Ямаа	34 918

МОНГОЛ АНДАХГҮЙ

БОРНУУР

Хуучнаар Түшээт хан аймгийн Баатар вангийн Наваан-Юндэнгийн хошуунд харьяалагдаж байсан энэ нутаг 1938 онд байгуулагдсан Баян-Өлзийт сумыг 1959 оны Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар Борнуур болсон түүхтэй.

АМЬСГАЛ АНИРДАХ АГЛАГИЙН СҮМ

Зорьсон хүний хүсэл, угтах эзний ухаан, байгалийн содон тогтоц Аглаг бүтээлийн сүмд огтлолцон аяллын жим тодорчээ.

“Буддын шашины зан үйлүүдийг гүйцэлдүүлж, тусыг хүртэж чадвал сайн хэрэг. Чадахгүй бол хий хоосон мухар сүсэг хэрэггүй” гэж Аглаг бүтээлийн сүмийг үүсгэн байгуулагч Г.Пүрэвбат лам хэлжээ. Мөн тэрээр “Мухраар сүсэглэх нь сэтгэл болон цагийн гарз. Бага ч атугай ойлгож сүсэглэх нь бүхний үйлсэд ус агаар адил чухал” гэж онцолсон нь бас буй. Тэрээр эдгээр үгсээ үйлдлээр үлгэрлэхийн тулд байгуулсан бүтээлийн сүмийг байгуулжээ.

Аглаг бүтээлийн хийд цогцолсон энэ газар Төв аймгийн Борнуур сумын нутагт Гарьд уулын Далын ам гэх газарт буй. Далан хар булаг боргилдог, даль цэцэг ширдэг шиг ургадгаас үүдэн ийнхүү нэрлэсэн гэж нутгийнхан тайлбарладаг. Уулын амны багахан хэсэгт хашаа татаж, том дааман хаалга босгожээ.

ГАРЬД УУЛЫН ЗҮРХ

Сүмийн үүдэнд бул чулууг сийлж урласан арслан биетэй, хангарьд толгойтой хөшөө байх бөгөөд толгойгоо хэвийлгэсэн зүгийн хэвлий дор 11 өндөг дараастай. Эндээс баруун зүгт үүнтэй адил загасан толгойтой, халиу биетэй үлгэрийн амьтны дүрс бас буй. Хоорондоо үл нийцэх амьтдын биесийг ийнхүү зохицолдуулж дүрслэх сайныг бэлгэддэг гэж буддын шашинтнууд үздэг. Сүмийн танхимын хойморт бурханч лам Г.Пүрэвбатын шавь нартайгаа хамтран бүтээсэн Шамбалын орон буюу Амитаба, алтадсан Бурхан багш тэргүүтнийг тахижээ. Энд мөн Ганжуур, Данжуурын ботиуд залаастай. Баруун хананд эх болсон зургаан зүйл хамаг амьтны энэ яваа насанд өвчин зовлонгүй, муу бүхнээс ангид байх, хойд насны мөрийг сайнаар олох хүртэл бодьсадын төрлөөс урвахгүй, шашин номыг сахиж, тусыг үйлдэх тангарагтай номын сахиус Балданлхам бурхан бий.

Баримт: Анх сүмийг барихаар шав тавих газрыг сонгоход байсан том бул чулууг хагалж бутлан зайлуулахаар эхэлсэн ажилтай хугацаа давхцан Гарьд ууланд түймэр гарснаас ажил хойшлогдон хоносон шөнө бурханч ламын зүүдэнд зөн ирсэн тул ургаа хадыг энэ чигээр нь үлдээж, түүнийг дээвэр дор нь оруулан сүмийг барьсан гэдэг.

Газар нутгийн хэмжээ	114.7 мянг.га
Багийн тоо	4
Өрх	1 542
Хүн ам	5 059
Улаанбаатар хотоос	105 км
Аймгийн төвөөс	155 км

Малын тоо	105 356
Адуу	8 738
Үхэр	15 327
Тэмээ	56
Хонь	45 172
Ямаа	36 063

БҮРЭН ЗАЯАТАЙ
БҮРЭН

Түшээт хан аймгийн Зоригт вангийн хошуу "Монгол Улсын нутгийн захиргааны дүрэм" гэгч албан бичгийн дагуу 1923 онд өнөөгийн Бүрэн сум болон шинэчлэн байгуулагджээ.

ТӨХӨМИЙН ХИЙД

Хуучин Түшээт хан аймгийн Зоригт вангийн хошуу одоогийн Төв аймгийн Бүрэн сумын төвийн баруун өмнөд талд Төхөмийн хийдийн туурь байдаг. Монгол Улсын үндэсний төв архивын сан хөмрөгт хадгалагдаж буй холбогдох баримт бичигт "...Шаддубдаржаапандлин" хийдийг Бүрэнт Засагчийн VIII /1869/ онд Засаг Жюн ван Одсэр базар шашин хурлыг дэлгэрүүлэхээр Баянтөхөм хэмээх газар сүм дуган байгуулж дээдийн түмэн өлзийг бататгахаар Цогчин, Ганжуур, Маанийн бүтээл, Ярь хайлан, Хангал, Цаг цагийн ерөөл зэрэг хурал номыг үйлдүүлжээ..." гэсэн баримт хадгалагдаж байна. XX зууны эхэн үеэр Төхөмийн хийд 300 гаруй ламтай, 3 дуган 1 сүмтэй, зуны эхэн сард Майдар эргэдэг, намрын эхэн сард Ганжуур хурдаг, адаг сард нь бага хэмжээний Цам гардаг хийд байжээ.

Зоригт вангийн хошуу нь дотроо урд сумын, дунд сумын, хойд сумын гэсэн 3 том хуралтай байсан бөгөөд урд сумын хурал нь одоогийн Бүрэн сумын Төхөмийн хурал, дунд сумын хурал нь Өндөр ширээтэд, хойд сумын хурал нь Эрдэнэсант суманд тус тус байжээ.

Энэ нутгийн ахмад хүмүүсийн дурсамж ярианд үлдсэнээр бол анх Баянхонгор аймаг хавийн хуучин Ламын гэгээний нэгэн томоохон лам ачаа хөсөг дагуулынхаа хамт 1800-аад оны эхэн үеэр Богдын хүрээ орохоор явж байгаад Төхөмийн зүүн дэнжид хоноглохдоо хэнгэрэгнийхээ ишийг хаячихаад явжээ. Тэр газрыг бэлгэшээн Төхөмийн сүмийг анх шавраар барьсан гэдэг. Сүмийн гол дөрвөн баганын нэгнийх нь доор уг ишийг хийж барьсан ба хожим уг сүмээ нурааж хятадуудаар модон сүмийг бариулахад мөнхүү ишийг авч дахин тэр сүмийнхээ баганан дор хийж бариулсан гэж хэмээн домоглон хэлэлцдэг ажээ.Уг хийдийн жас нь нэлээд баян 1000 гаруй адуу, 3000 гаруй хонь ямаа, 500 гаруй үхэр 50-60 тэмээтэй байжээ. Тухайн үед нутгийн жинчид жинд явахдаа Төхөмийн хийдийн 100 шарыг хөлслөн авж явах нь цөөнгүй байсан гэдэг. Лам хуврагуудын дотор Дашням унзад, Дорж гавьж, Цэнд гавж, Амгаа унзад, Ишосор тэргүүн лам, Жадамба, Гомбодаш лам, Цэдэндаш зэрэг эрдэм чадалтай мяндаг тушаалтан лам олон байсан ажээ.

Газар нутгийн хэмжээ	375.5 мянг.га
Багийн тоо	5
Өрх	848
Хүн ам	3 012
Улаанбаатар хотоос	220 км
Аймгийн төвөөс	190 км

Малын тоо	300 158
Адуу	20 562
Үхэр	11 914
Тэмээ	139
Хонь	159 428
Ямаа	108 115

ДУУТЫН БИЧЭЭСТ
ДЭЛГЭРХААН

Эрчимжсэн мал аж ахуйг бодлогоор дэмжихээр санаа нэгдсэн Дэлгэрхаан сумынхан хуучнаар Түшээт Хан аймгийн Мишиг гүнгийн хошуунд харьяалагддаг байсан ба өнөө цагийн энэ нэршил, нутгийн засаг захиргааны нэгжийн харьяалал тэртээ 1923 онд үүссэн юм.

ЦОГТ ТАЙЖИЙН БИЧЭЭС

Бичигт хадны бичгийг өдгөөгөөс 390 жилийн өмнө, Цогт тайж 1624 оны намар ан хийж яваад авга эгчийгээ санан бичсэн гэж түүхэнд тэмдэглэгдэн үлджээ. Тус сумын төвөөс урагш 20-иод километр зайд орших Тарамцагийн уулсын шувтарга Хутаг хэмээх уулын өвөрт байдаг тэр хадыг нутгийн ард түмэн "Дуут" хад гэж нэрлэдэг. Ийнхүү нэрийдэх болсон нь түүнээс ширмэн тогоо шиг дуу авиа гардаг байна. Мөн гаднаа хар боловч дотроос нь цагаан саарал өнгө гарч ирдэг байгалийн нэгэн гайхамшигт тогтоц юм. Тиймээс Халхын тайж Цогтын бичээс нь хар самбар дээр цагаан шохойгоор бичсэн юм шиг тод харагддаг юм.

"Дуутын хар чулуу"-н дээрх Цогтын шүлгийг дунд сургуулийн уран зохиолын хичээлд үздэг тул бараг монгол хүн бүр мэднэ. Долоон бадаг уг шүлгийн утгын цөм хэсэг нь Цогт тайжийн Халуут эгчээ дурсан шүлэглэсэн хэсэг юм. Цогтын хамгийн дотнын эгч нь холын овогтноо бэрд гаран одоход угаас улс төрийн хувьд ганцаардалд орсон байсан Цогт бүр ч ганцаардан эгчийгээ ихэд үгүйлдэг байсан гэдэг. Автай сайн ханы ач Бахарай хошуучийн хүү Цоохор Цогтын ганцаардах болсон шалтгаан нь Манжуудын Монголыг эзлэх бодлогыг эсэргүүцэн тэмцсэн Цахарын Лигдэн хааны тэмцлийг Ар Монголоос Цогт тайж бараг ганцаар дэмжин тусалж байсанд оршино. Ингээд чулуунд бичсэнээр "цагаан тахиа жилийн (1621 он) намрын эхэн сарын хорин нэгнээ Хангай ханы цэцэрлэгийн хойт ууланд авлан, хуягт халтраа унаад өндөр дээр гарч байхдаа зүүн зүг харан сэтгэлээ маш уярч Халуут авга эгчээ санаж ийн өгүүлээд уйллаа" хэмээсэн байна. Цогт тайж эгчээ үгүйлэн шүлэг зохиохдоо санаагаа шууд тоочсонгүй, гүн ухааны асар нарийн гаргалгаа хийж, яруу найргийн шат дараалын зарчмаар хэлсэн ажээ.

Хэл шинжлэл, утга зохиол, Монгол гүн ухааны гайхамшигт дурсгал, нэрт монгол судлаачдын дүгнэснээр "ном бичгийн хэлийг олсон ардын дуут санагдуулам" (Б.Я.Владимирцов), "хээр талын анхилуун үнэр" шингэсэн (А.Н.Веселовский), "алс бодлоготны зөөлөн сэтгэлийн уярангуй байдал тодорхой бөгөөд Буддын шашинтны хамаг амьтныг нигүүлсэн ивээхийн бясалгалт сэтгэгдэл гүнзгий" (Ж.Төмөрцэрэн) хэмээх энэ сайхан найраг, нүүдэлчдийн чулуун ном Дуутын хар чулуутайгаа хамт тал сайхан нутагтаа үүрд залрах болтугай.

Газар нутгийн хэмжээ	216.8 мянг.га
Багийн тоо	3
Өрх	504
Хүн ам	1 660
Улаанбаатар хотоос	318 км
Аймгийн төвөөс	234 км

Малын тоо	143 542
Адуу	9 753
Үхэр	6 344
Тэмээ	132
Хонь	72 753
Ямаа	54 560

ЖАРГАЛТАЙН ДЭЛГЭР

ЖАРГАЛАНТ

Олноо өргөгдсөн Монгол Улсын үед Түшээт Хан аймгийн Баатар вангийн хошуунд харьяалагдаж байсан Жаргалант сум хожим 1927 онд Сангийн тариалан нэртэйгээр анх байгуулагдан, улмаар Баян-Өлзийт сум гэгдэж яваад,1957 онд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн тогтоолоор Жаргалант сум болон байгуулагдсан.

МЭНДИЙН ХАР ҮЗҮҮР

Жаргалант сум хойд зах болох Хөшөөтийн даваагаар Төв аймаг Сэлэнгэ аймагтай хиллэдэг. Өмнүүрээ Бугын толгойт, Ногоон нуруу зэрэг үргэлжилсэн их ойтой өндөр уулс, нурууд хөндөлссөн энэ нутгаар Өндөр гэгээн Занабазар болон Жибзундамба хутагтын хойд дүрүүд хойш урагш заларч байх үед уттаж байсан газрыг Угтаал, үдэлж хоноглож байсан газрыг нь Жаргалан гэж нэрлэсэн домог бий. Жаргалант сумын нутагт Мэндийн хар үзүүр гэх газар бий бөгөөд хутагтыг залрах үед хүндэтгэл үзүүлж, даншиг мандал өргөж байсан гэнэ. Ялангуяа II Богд Жибзундамба хутагт Туул голын ай савд төрж, Амарбаясгалант хийдийн өмнөх Ийвэн голын хөвөөний Саадаг толгойд шашны тэргүүнээр өргөмжлөгдсөн түүхтэй. Иймээс II Богд Жибзундамба хутагтын дараагийн дүрүүд Хутагтын өргөө Орхон голын эрэгт байх үед мөн Амарбаясгалант хийдэд олон удаа заларч байсан юм байна. Сонинхангай уулын зүүн урд залгаа өндөр уулыг Халиугчин уул, Халиугчны ам гэдэг бөгөөд энд Халиугчин Боролзой уулын тамгын газар байрлаж байсан гэнэ. Сумын нутгийн зүүнтээ Тээлийн хөндий, Тээлийн рашаанаас холгой орших Хүүлэн хан буюу Хүүлэй хан уулыг нутгийнхан эртнээс тахиж шүтэж, өндөр дээд язгууртнуудаа нутаглуулж байсан тул энэ уулын амуудад эртний булш, хиргэсүүр олноор байдаг. Мөн энэ ууланд малтлага хийхдээ археологичид үлэг гүрвэлийн бололтой чулуужсан булууны ясыг олсон гэдэг.

Монгол Улсын нийслэл нүүдэлчдийн анхны нийслэл өргөө өдгөөгийн бууриндаа төвхнөх хүртэл туулсан нүүдлийн урт замын дунд Жаргалант сумын нутагт 1724-1729 онуудад тулга тулж, галаан бадрааж байсан түүхтэй.

ТОС ДААСАН БУЯНТ

ЗААМАР



Заамар нь нийт 7500 өрх, 37500 хүн ам суурьшсан 2900 ам км нутаг дэвсгэртэй Монгол орны томоохон сумдын нэг юм. Анх 1959 онд байгуулагдсан сумын төвийн Бат-Өлзийт суурин 2008 оны байдлаар 5800 хүн амтай гэж тоологджээ. Ган зуд тохиодоггүй тул Тосон Заамар хэмээн алдаршсан нутаг.

ХЭЭРИЙН ОВОО

Заамар сумын төвөөс урагш 7 км орчим Хунтайжийн Бүрд гэдэг жижигхэн нуур буй. Энэ бүрдийн эргэн тойронд Хунтайжийн нэртэй холбогдсон домогт газар цөөнгүй. Хунтайж цагаан байшингаа барьж дуусгаад заанаар мялаая гэтэл заан байхгүй тул Заан нэртэй хүүгээрээ мялаах болсон тухай хүү нь дуулж мэдээд тэндээс оргон зайлж Хунтайжийн бүрдний дэргэд чулуугаар хороо барьж, хээр хоносон тул тэр чулуун овоог Хээрийн овоо гэж нэрлэдэг болжээ.

Мөнхүү Чингис хааны их цэрэг аян дайнаас буцаж явахад Эзэн Богд өгөөмөр сайхан баян хангайг хараад “За энд амаръя” гэж хэлсэн гэнэ. Тиймээс энэ сайхан нутгийг “За амаръя” гэж хэлсэн газар гэж домоглон хуучлах болж, төд тэр нь Заамар болон нэршил тогтжээ.

БИЧИГТ ШУРГУУЛГЫН МОНГОЛ БИЧЭЭС

Нэгэн цагаасаа тосон Заамар хэмээн нэрлэгдэж хүн малын нуруу тэнийлгэн, сэтгэл сэргээдэг асан энэ нутагт зуд болж байсан түүх үгүй гэнэ. Хэнтий нурууны үргэлжлэл хэмээгдэн үзэсгэлэн гоо бүсгүй мэт ганган цагаан хус найган ганхаж, саарал чоно, халиун буга, хярс, цагаан зээр, бор гөрөөс идээшин, Наймганы нуруунд нь нутагшсан аргаль угалзран данхайх эврээрээ сүр хүчээ гайхуулдаг сайхан үе эдүгээ түүх домог болон яригддаг.

Цулаан сэрүүнд тухлан суусан нутаг мөнөө
Дуурсан саатах дуут Бор булан мөнөө
Тохойрон урсах Туулын гол мөнөө
Тоглон наадсан болоон довцог мөнөө
Биеийг Булхсан бүрд тойром мөнөө
Билгүүнийг шүүсэн бичигт байц мөнөө
Харийн бараа харсан Хаст өнбөр мөнөө
Харьтны эсрэг хатамжсан хатан зэмсэгтэн мөнөө
Насыг элээх нахиат наймганууд мөнөө
Наран ээсэн уур утаа мөнөө

Газар нутгийн хэмжээ	186.8 мянг.га		Малын тоо	160 773
Багийн тоо	4		Адуу	9 083
Өрх	1 955		Үхэр	14 052
Хүн ам	6 348		Тэмээ	6
Улаанбаатар хотоос	135 км		Хонь	84 629
Аймгийн төвөөс	180 км		Ямаа	53 003

Газар нутгийн хэмжээ	280.3 мянг.га		Малын тоо	238 473
Багийн тоо	4		Адуу	17 615
Өрх	1 593		Үхэр	15 929
Хүн ам	5 407		Тэмээ	176
Улаанбаатар хотоос	180 км		Хонь	120 677
Аймгийн төвөөс	225 км		Ямаа	84 076

АЙМГИЙН АНХНЫ ТӨВ
ЛҮН

Эзэн богд Чингис хааны үед Хэрэйд аймаг, Ван хааны нутаг, хожим Түшээт хан аймгийн Сужигт гуний хошууны харьяат байсан түүхийн улбаатай энэ нутгийн гал голомтыг сахиж 1924 оноос эхлэн 80 гаруй жил улбаалан хөгжсөөр байгаа түүхтэй нутаг бол Лүн сум юм.

Нутгийнхан төдийгүй Монгол даяар мэдэх Лүн толгой тахилгат газар Лүн сумын төвийн хажууханд бий. Аян замын гийчид энэ толгойд сүсэглэн залбирч алс хэтийн ажил, аян замын ерөөлөө айлтгадаг уламжлалтай. Тэртээ цагт Лүн сум Төв аймгийн анхны гал голомт байсан түүхтэй. Олны хөлд хэзээний дарагдаж, айлчин гийчдийг цайлж ундалж сурсан Лүн сумынхан өдгөө ч баруун бусийн аймгуудыг улсын нийслэлтэй холбох гүүр болсоор байна.

ЛҮН ТОЛГОЙ

Лүн сумаас баруун тийм 2 км хэртэй явахад замын баруун талд хадтай, намхан толгой бий. Энэ бол Лүн толгой юм. Эрт урьд цагт шүдлэн үхэр бүтнээр нь залгихаар аварга том могой гарч ирж, нутгийн зон олон аюулд өртөх болов гэнэ. Тэрхүү аюулыг дарахаар нэгэн баатар эр ойрын нэгэн уулын модноос давхин ирээд уулын оройг ирт сэлмээрээ цавчин аваад үүрнээсээ цухалзах аварга могойн толгой руу шидэхэд "лүг" хийх дуу гарч могой үүрд дарагдан хүн зон олон, амьтан араатан бүхэн аюулт зовлонгоос ангижирчээ. Энэ цагаас могойн үүрийг хааж, могойг даран алсан хадат толгойг "Лүг" гэж нэрлэх болсон агаад цагийн эрхээр энэ нэр олны ам дамжсаар "Лүн толгой" гэх болсон гэдэг.

УРУУ ТОЛГОЙ

Лүн сумын нутагт ийм нэртэй нэгэн толгой бий. Эрт цагт гон бие гозон толгой Равсал гавж гэж байжээ. Тийрэнтэй нөхцсөн гэх учир түүнтэй айл буудаггүй, ганц л толгойн энгэрт ганц гэрээрээ суудаг байжээ. Равсал гавж айхтар догшин бурхадтай байсан гэх бөгөөд тэдгээр бурхдынхаа тэргүүнийг уруу нь харуулаад хананы толгойноос өлгөдөг байж. Өтөл болсон цагтаа тааралдсан хүндээ Равсал гавж "Намайг нас барсан байвал Налуу нэртэй энэ толгойн энгэрт уруу нь харуулаад оршуулаарай" гэсэн гэдэг. Нутгийнхан ч захисан ёсоор нь болгож Налуу нэртэй байсан тэр толгойг үүнээс цаашид Уруу толгой гэж болсон гэнэ.

Газар нутгийн хэмжээ	252.9 мянг.га
Багийн тоо	3
Өрх	791
Хүн ам	2 652
Улаанбаатар хотоос	130 км
Аймгийн төвөөс	175 км

Малын тоо	258 922
Адуу	17 759
Үхэр	13 446
Тэмээ	402
Хонь	140 754
Ямаа	86 561

ДОМГИЙН ӨЛГИЙ
МӨНГӨНМОРЬТ

Байгалийн баялаг, содон тогтоцуудаараа алдартай Мөнгөнморьт Сэцэн хан аймгийн Далай дархан бээлийн хошуу нэртэйгээр 1691 онд анх үүсэн байгуулагдаж, 1923 онд шинэ засаг захиргааны зохион байгуулалтаар дахин төлөвлөгдсөн түүхтэй.

БҮРХИЙН ДӨРВӨЛЖИН

Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг Хэрлэн голын цутгал Зүүн Бүрх голын баруун хөвөөнд оршдог эртний дөрвөлжин хэрмийн ор бий. Нутгийнхан энд эрт цагт бөө, удган хоёрын суусан байсан газар гэх нь бий. Тэр хоёр сүрхий айхавтар хараал хийдэг юмсанжээ. Нутгийнхан тэр хоёроос ихээхэн эмээж, цэрвэдэг байсан тул хоол унд дөхүүлж, өргөл барьцаар аргаддаг байж. Бөө удган хоёр тэндээ суусаар насыг элээсэн бөгөөд тэр хоёрын суурин суусан хэрмийг нутгийнхан "Хараалчийн хэрэм" хэмээн домоглож нэрлэдэг болжээ. Басхүү Бүрхийн дөрвөлжин гэх нь бий. Энэхүү дөрвөн тал шороон хэрмийн хэмжээ нь 18х30 м, 29х29 м харьцаатай. Тэнд хийсэн таван малтлагаар барилгын дээврийн ваарны хагархай, садармал хээтэй дөрвөлжин тоосго олдсон бөгөөд үүгээр нь Гуа дов, Тэрэлжийн дөрвөлжин зэрэг Хүннүгийн үеийн хэрэмтэй нэг цаг үеийнх гэж эрдэмтэд үздэг.

ХЭРЛЭНГИЙН ЗҮҮН ХҮРЭЭ

Дундад зууны үеийн Монголын түүх бичлэгийн томоохон бүтээл "Эрдэнийн эрх" сурвалжид Хэрлэн голын Зүүн хүрээ хэмээх хийдийн суурийг Энх Амгалан хааны 50 дугаар он буюу 1711 онд Өндөр Гэгээн Занабазар тавьсан гэж тодорхойлжээ. Харин Ч.Банзрагч, Б.Сайнхүү нарын "Монголын хүрээ хийдийн түүх"/УБ.2004 / эмхэтгэлд анх Энх Амгалангийн дөчдүгээр он буюу 1701 оны төмөр туулай жил Эфү засаг Жүн ван Дондовдоржийн үед шашин хурлыг дэлгэрүүлэхээр Тогос Гүши уулын өвөрт Хэрлэн голын хойд хөвөөнд сүм дуган байгуулж дээдийн түмэн өлзийг бататгахаар жүд, цанид, ламиран, мамба, зурхай, бадам ёго, майдар зэрэг дуганыг байгуулан хурал номын сургуулийг үйлдүүлжээ хэмээн дурдсан байна. Энэ хүрээний туурь одоо Багануур дүүргийн төвөөс зүүн хойш 28-30 км, Хэрлэн голын баруун эрэг, Тогос хайрхан уулын өвөр, Зүүн Байдлаг голын адагт байдаг. Хөгшин хүрээнд Цогчин, Цанид, Жүд, Мамба, Зурхай, Дүйнхор зэрэг 10-аад дацан 6 аймагтай сүм дуган нэлээд олонтой байжээ. Бүх орд харш нь цагаанаар будсан хашаатай. Түүний эргэн тойрон аймгийн дуган болон гол төлөв улаан халз гарган чимсэн гэр хэлбэрийн сүм дуган бүхий хашаанууд байрлаж байв. Зүүн хүрээ нь бие биеэ хөндлөн огтолсон хоёр гудамжтай, зуувандуу дөрвөлжин талбай эзэлдэг байжээ.

Газар нутгийн хэмжээ	672.1 мянг.га
Багийн тоо	3
Өрх	723
Хүн ам	1 991
Улаанбаатар хотоос	180 км
Аймгийн төвөөс	188 км

Малын тоо	70 195
Адуу	6 088
Үхэр	12 762
Тэмээ	25
Хонь	31 056
Ямаа	20 264

ӨВГӨДИЙН ТАМГАТАЙ
ӨНДӨРШИРЭЭТ

Түшээт Хан аймгийн Зоригт вангийн хошуу өдгөө Төв аймгийн Өндөршириэт сум Өндөрхаан нэртэйгээр анх 1924 онд Байшинт уулын энгэрт байгуулагдсан түүхтэй. Сумын хэмжээнд 30 гаруй мянгат малчин байгаагаас 11 нь нэг жилийн дотор төрж гарсан нь энэ нутгийн мал аж ахуйн хөгжил хэрхэн хурдацтай өсөн нэмэгдэж байгааг тодхон харуулах тоо баримт юм. Мөн энэ нутгаас 12 гавьяат төрсөн байдаг.

Ойрадын хаан Галданцэрэнгийн тэргүүн ангийн манлай Шарахай баатрыг онголсон Хуягт уул, Хубилай хааны зарлигаар тариа будаа халиуруулан ургуулсан Үүдэн цөл, Богд Хаант Монгол Улсын анхны Ерөнхий сайд Да лам Цэрэнчимэдийн хүмүүний хутгийг олсон Да ламын дэнж, сумын төв нь анхлан тулгаа тулсан Наранбилэг хайрхан гээд нэр нь хүртэл шүлэг шиг аялгуут уул усаараа алдартай Өндөршириэт сум өн эртнээсээ уран дархан, бурхан ухаантнуудаараа алдартай. Энэ нутгийнхан гурван үеэрээ төрийн их тамгатай хувь тавилангаараа холбогдсоноороо өдгөө ч бахархан үр хойчдоо домог болгон хуучлан үлдээжээ.

Зээ Баатарын домогт Хуягт уул
Балгасын дурсгалт Хэрмэн дэнж
Эртний түүхт хөшөө дурсгалт
Энэ нутгийн эрдэнэсийн сан
Долоон хошуу даншгийн
Домогт хурдан морьтой
Даншигийн аварга Баянмөнхийн
Даяар түгсэн алдартай

1204 онд болсон их тулааны үеэр олзлогдсон Тататунга гэгч тамгач сайд Таян хааны алтан тамгыг өврөөсөө гаргаж их хаанд "Энэ тамгыг эрдэмтнийг томилох, албан татвар хураах зарлиг дардаг" гэж хэлсэн гэх түүхт үйл явдал одоогийнхоор Өндөршириэт сум тэр үеийн Хэрэйдийн нутагт болсон гэнэ. Удаах төрийн их тамгатай Өндөршириэтийнхний холбогдсон түүх нь 1850-иад оны үед эл нутагт мэндэлсэн алдарт уран дархан Хар гарт хэмээх Лувсангомбо Шарга морьтын аманд улаан халзтай төрийн хүндэтгэлийн их өргөөнд хэдэн сар сууж Богд хаант Монгол Улсын төрийн тамгыг сийлжээ. Сайд Г.Цэрэнчимэд түүнийг дагуулан очиж тамгыг Богд Хаанд өргөн барьсан гэдэг. Уран дарханд Богд хаан сар бүр 30 янчааны цалин олгох зарлиг гаргасан байна. Энэ бол удаах учрал. Ардчилсан төрийн үед Монгол Улсын анхны Ерөнхийлөгчийн тамгын газрын даргаар Өндөршириэтийн уугуул Ч.Дашдэмбэрэл томилогдон Монгол төрийн тамгыг түшиж явсан нь гутгаар ерөөл биз ээ.

Газар нутгийн хэмжээ	271.2 мянг.га
Багийн тоо	4
Өрх	605
Хүн ам	1 921
Улаанбаатар хотоос	188 км
Аймгийн төвөөс	235 км

Малын тоо	211 742
Адуу	15 658
Үхэр	12 141
Тэмээ	36
Хонь	108 541
Ямаа	75 366

ЭЛБЭРЭЛТ ЭЭЖИЙН НУТАГ
СЭРГЭЛЭН

Түшээт хан аймгийн Дархан гүнгийн хошуу өдгөө Төв аймгийн Сэргэлэн сум уул, гүвээ, тал хээр хосолсон мал аж ахуй болон газар тариалан эрхлэхэд нэн тохиромжтой өгөөмөр баян нутаг юм. Даяар дурсагдах дархан аваргатай энэ нутаг улс, аймгийн наадамд онцгойрон шалгарсан шандаст хурдан хулгуудээрээ ч Монголдоо зартай.

ЭЭЖ ХАД

Ойрдын Галдан бошгот 1862 оны хар барс жил Шаргалжуутын голыг уруудан явахдаа их цэргэтгэйгээ буудаллаж шөнө нь ээжийгээ зүүдэлжээ. Гурван түмэн цэргээр хүрээлүүлэн Хараа ихт хар туг залан Төр тогтохын бэлэг гэж үзэн найман шилдэг харваачаар сонгон харвуулахад харвасан сум нь цөм энд туссан гэнэ. Тийнхүү энэ газрыг хүндэтгэн эмэгтэй хүний төрх хэлбэрийн хөшөө босгосон домогтой ажээ. Үүнээс хойш нутгийн ардууд төдийгүй хол газраас энэ хөшөөг зорин очиж "Ээж" хэмээн хүндэтгэн залбирч, ажил үйлсээ даатган гуйж, мөргөж ирсэн гэх домог бий.

Мөн Ээж хад байгаа одоогийн газарт, эрт үед нэгэн эмгэн 4 хөх ямаатайгаа амьдран суудаг байж. Гурван хөх ямаагаа өвөл зунгүй сааж аж төрдөг байжээ. Тэр ч байтугай ойр хавийн ядуу зүдүү айлд сүүнээсээ илүүчилдэг байсан аж. Хүмүүс ихэд баярлан буянт ээжтэйгээ адилтган үзэж "ээж" гэж дууддаг байжээ. Ийнхүү амьдран суусаар нэгэн шөнө эмгэн суугаагаараа насан эцэслэж том чулуу болон хувирчээ. Гурван хөх ямаа нь эзнийхээ хажууд гурван хөх чулуу болон тогтсон гэх домогтой ажээ. Эмгэнийг нас барахад хүмүүс ихэд харамсан гашуудаж уг чулууг "Ээж хад" хэмээн хүндэтгэн дууддаг болж.

Мөн ээждээ үргэлж өргөл барьж өргөдөг болжээ. Ээж хаданд ирсэн эмэгтэй хүн ээжийн баруун чихэнд, эрэгтэй хүн зүүн чихэнд нь хүслээ шивнэн гуйдаг болсон гэх өөр нэг домог ч бий.

Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших ээж хаданд нэг мөргөсөн хүн гурван жил дараалан очиж мөргөх төдийгүй очихоосоо өмнө гурван хүслээ бодож сүсэглэж явах учиртай гэж сүсэгтэн олон итгдэг.

Газар нутгийн хэмжээ	386.5 мянг.га
Багийн тоо	5
Өрх	725
Хүн ам	2 028
Улаанбаатар хотоос	62 км
Аймгийн төвөөс	18 км

Малын тоо	124 538
Адуу	17 772
Үхэр	7 313
Тэмээ	33
Хонь	61 706
Ямаа	37 714

СУГСРАХ ТАРИАНЫ НУТАГ
СҮМБЭР



БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1977 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн зарлигаар Сүмбэр сум байгуулагджээ. Үр тариа, тэжээлийн ургамлын тариалангийн аж ахуйг голлон хөгжүүлж ирсэн байна.

ЦЭЭЛИЙН ХӨНДИЙ

Шидсэн чулуунаас бусад зүйл ургадаг гэдгээрээ алдартай Цээлийн хөндийгөөс Богд Хааны үед хүртэл цэргийн агтанд зориулан арвин хадлан авдаг. Хадсан өвс нь өвөл морьдыг таргалуулдаг байсан гэх хууч яриа бий. Тиймдээ ч энэ нутаг цагтаа Богдын их шавийн отгийнхны гол нутаг байсан гэдэг. Хээр тал байтлаа битүү мойл ургасан моносон ойтой, тэгснээ атлаа элсэн манхан үргэлжилж, ойр тойрондоо булаг шанд огт байхгүй атал Орхон Туулын бэлчир болсон гээд энэ нутаг байгалийн тогтоцын хувьд маш сонирхолтой газар юм. Судлаачдын хийсэн нэгэн сонирхолтой судалгааны дүнд Хараа гол эрт дээр үед Загдал, Зөөхий, Цээлийн хөндий, Хар нуур, Шар усны голоор дамжин Туул голд цутгадаг байсны ул мөрийг тодорхой болгосон гэнэ. Нутгийн дийлэнх хэсэг нь үржил шимтэй, харьцангуй нам дор газар, уудам хөндий бөгөөд Төв аймгийн хамгийн нам дор газар болох далайн түвшнээс дээш 820 метрийн өндөрлөг Загдлын голын хөндий энэ сумын нутагт буй.

Газар нутгийн хэмжээ	349.3 мянг.га
Багийн тоо	2
Өрх	545
Хүн ам	1 778
Улаанбаатар хотоос	169 км
Аймгийн төвөөс	204 км

Малын тоо	42 947
Адуу	2 225
Үхэр	5 304
Тэмээ	-
Хонь	20 332
Ямаа	15 086

ХААДЫН ДОМОГТОЙ
УГТААЛЦАЙДАМ

Түшээт Хан аймгийн Халиугчин Боролзой хошуу өдгөө Төв аймгийн Угтаалцайдам сум 1924 онд байгуулагдсан.

Сумын нийт өрхийн 85 хувь нь төмс, хунсний ногоо тариалж байна. Аж ахуйн нэгж, иргэд жилд 300-4500 тн хадлан бэлтгэж дотоодынхоо хэрэгцээг хангаад зогсохгүй, зах зээлд борлуулдаг. Бэлчээрийн талбай 110 мянган га, ой бухий газар 8,3 мянган га, хадлангийн талбай 1250 га, зам шугам сулжээний газар 1000 га талбайтай аж.

СОНИН ХАНГАЙ

Эрт урьдын цагт Автай Сайн Хаан одоогийн Угтаалцайдам сумын нутгаар аялж явахдаа үзэмж төгс сүрэг бугатай тааралджээ. Хаан дагалдан явагсдын хамт мөнөөх бугын сүргийг гөрөөлөн хөөсөөр их уулын хашаа хороо мэт хадан хавцалд хашжээ. Хаалт хүрээ адил хад цохион хүрээтэй энэ уулыг Автай Сайн Хаан "Аятай сонин хангай байна даа" гэж таашаан магтжээ. Үүнээс үүдэн энэ уулыг "Сонинхангай" гэж нэрлэсэн домогтой.

Сумын төвийн урдхан байх хадтай уулыг Уушиг гэх бөгөөд Өндөр гэгээн Занабазар өрлөг эхийнхээ хайранд биширч анх "Сүүн далай ээж" гэж нэрлэхээр болжээ. Хожим өрлөг ээжийгээ бурхан болоход энэ уулын орчимд хөдөөлүүлж, энэ ууланд "ууш" сахил хүртээсэн учир "Ууш гуай" хэмээн авгайлсан нь өдгөөгийн Уушиг хайрхан нэрний үүсэл билээ. Уушиг уулын урд зүгт Талын уул, Ятуутын хэмээх уудам хөндий үргэлжлэх бөгөөд энэ хавьд эртний хүмүүсийн үлдээсэн бичээс, дурсгал олон бий.

ДАРАВГАЙ

Угтаалцайдам сумын нутагт Даравгай хэмээх хужир шүү, худаг устай тал нутаг байдаг. Уг нь энд Дарь хэмээх нэгэн авгай нутаглан мал маллан аж төрж байхдаа хужир тарьж ургуулсан гэх яриа бий. Цаг хугацаа улиран өнгөрөхөд "Дарь авгай" хэмээх үг Даравгай хэмээн нэршчихсэн гэнэ.

ЭЭЖ ХАДНЫ ДОМОГ

Эрт үед нэг залуу хөгшин ээжтэйгээ амьдарч суудаг байжээ. Тэрээр цэргэт явах болж "Ээж хайрхан"-даа "Намайг буцаад иртэл ээжийг минь сайн харж байгаарай, адууг минь аварч хамгаалж байгаарай" гэж залбиран гуйжээ. 2 жилийн дараа хүү цэргээс ирэхэд ээж нь байхгүй байж. Харин ард нь маш их чимээ гарахаар нь хартал адуу үй түмэн болсон байж гэнэ.

Газар нутгийн хэмжээ	154.8 мянг.га
Багийн тоо	4
Өрх	798
Хүн ам	2 640
Улаанбаатар хотоос	152 км
Аймгийн төвөөс	195 км

Малын тоо	129 817
Адуу	10 763
Үхэр	10 086
Тэмээ	1
Хонь	62 794
Ямаа	46 173

ЦЭНГЭЛИЙН ӨЛГИЙ
ЦЭЭЛ

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1976 оны 10-р сарын 19-ний өдрийн 357 дугаар тогтоолоор 1976 оны 12-р сарын 15-ний өдрөөс эхлэн Угтаалцайдам сумын Цээлийн нэгдүгээр тасгийг түшиглэн Цээл сум байгуулагдсан түүхтэй. Энэ нь хуучнаар Түшээт хан аймгийн Халиугчин боролзой уулын хошуунд харьяалагдаж байсан нутаг юм.

ТЭЭЛИЙН РАШААН

Далайн түвшнээс дээш 1200-1500 метр өндөрт өргөгдсөн ойт хээрийн хөнгөн сийрэг хүрэн хөрстөй, Орхон Сэлэнгийн сав газрын ойт хээрийн бүсэд хамаарах, өвөрмөц сонин байгальтай, нутгийнхаа төв баруун хойд хэсгээр говирхог болон тал хээрийн нутгийн шинжийг хадгалсан Цээл, Жаргалант сумын хилийн заагт Тээлийн рашаан бий. Ер нь Төв аймагт анагаах чадвартай рашаан ус элбэг.

Сэлбийн, Баянцогтын, Жанчивлангийн, Нүүрэнгийн, Баруун байдлигийн, Дунд байдлигийн доод рашаан, Дунд байдлигийн дээд рашаан, Бүрхийн, Хонгоны, Галдтайн, Гутайн, Минжийн, Хайлаастын, Дэвсэн булгийн, Хун харын Саарал морьтын, Элгэнэ, Естийн, Их тэнгэрийн, Бөөрөлжүүтийн, Хундаган, Бага төхөмийн давст нуур Их төхөмийн давст нуур Долоон рашаан гээд нэрлээд байвал дуусахгүй.

АР БУЛАГИЙН ХУРАЛ

Эртний тахилгат Хүүлэй хан уулын ар бие Тээлийн рашааны урд дэвсэг дээж Ар булагийн хурлын хоёр дуганы тууль бий. Ар булгийн хурал /жасаа хурал/ Жаргалант сумын төвөөс баруун урагш 28 километр, Жаргалант Цээл сумдын хилийн дээс Хүүлэй ханы ар биед энэхүү хурал, номын орон төвхнөж байжээ. Ар булгийн Дашлин нэрт хурлыг анх Дамбий гэлэн тойн, Ням гэлэн тойн, эрх тайж Түгж, Гончиг тайж нарын хүмүүс 1771 онд дуган байгуулан Ерөөл хуруулж эхэлснээр эх суурь нь тавигджээ. Дараа нь 1798 онд Ламрин хурлыг байгуулсан байна. Хоёр модон дугантай, 30 гаруй лам хурдаг байсан гэдэг. Энэ хурлын шүтээн сахиус нь одоог хүртэл тодорхойгүй байсаар байна. 1936 хаагдахын өмнөх үеийн тэргүүн лам нь Сүрэнцорж гэдэг хүн байжээ.

Газар нутгийн хэмжээ	165.6 мянг.га
Багийн тоо	5
Өрх	745
Хүн ам	2 480
Улаанбаатар хотоос	186 км
Аймгийн төвөөс	240 км

Малын тоо	131 614
Адуу	10 040
Үхэр	9 711
Тэмээ	158
Хонь	66 239
Ямаа	45 466

АЯЛЛЫН ЖИМ ХӨТӨЛСӨН
ЭРДЭНЭ

Ар, Өвөр Жанчивлингийн рашаан сувиллууд, байгалийн олон үзэсгэлэнт газартай, сүүлийн үед аялал жуулчлал ихээр хөгжиж буй сумдын нэг Эрдэнэ суманд Чингис хааны хөшөөт цогцолбор, 13-р зууны аж амьдралыг харуулсан жуулчны бааз, Гүнжийн сүм зэрэг олон алдартай дурсгалт газар бий.

ГҮНЖИЙН СҮМ

"БИ МОНГОЛ ХҮНИЙ ГЭРГИЙ ТУЛ МОНГОЛ ХҮН БОЛЖЭЭ. МОНГОЛД МИНЬ НУТАГЛУУЛААРАЙ..."

Хичээнгүй амирлангуй гүнжийн домгоос.

Их тайгын нэгээхэн үргэлжлэл хэсэгт моддын шуугиан дунд эвдэрч, хоосорсон сүм, сүмийг тойруулан барьсан өндөр биш хэрмэн хашаа байна. Тэртээ гурван зуун жилийн тэртээ урд зүгийн халуун, чийглэг орноос хатуу ширүүн уур амьсгалтай Монголд ирсэн Манжийн Энх-Амгалан хааны 6-р охин Хичээнгүй Амирлангуй гүнжийн сүүдэр нь үгүй сүнс энд нойрссон гэх юм.

Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг, Туул голын баруун талын томоохон цутгал болох Баруун Баян гол, Хөх чулууны голын эхэнд байх Гүнжийн сүмийн эргэн тойрон уул ус, ургамал жигдэрсэн хангай. Халхын Довдондорж ноёны хатан болохоор Манжийн хааны зарлигаар ирсэн тэр гүнж энэ захгүй их тайгын өвөр бэлд ирж нойрссон гэнэ. Эцгийн сургаал гэхээс хааны зарлиг сонссон гүнжийг харийн ноён харин чин сэтгэлээр гэргийлсэн бололтой. Хааны зарлигийг үл биелүүлсэн гэж 1740 онд Манжийн албатуудад хороогдсон хатандаа зориулан энэхүү бунхны цогцолборыг байгуулжээ. Хатан ч нас барахын өмнө "Миний цогцсыг Хятад газар бүү хүргүүл. Би монгол хүний эхнэр учир монгол хүн болжээ. Иймээс намайг Монголд нутаглуулаарай" гэж гэрээсэлсэн гэх.

Гүнжийн бунхан 1930 он хүртэл хүний хөл хүрээгүй дархан газар байсан ч Дотоодыг хамгаалах газрын дайрлага энэ газарт хүрчээ. Судлаачид онгоны үлдэгдэл Богд хаалга, чулуун дурсгал, хашаалсан байгууламж, хэрмэн хана, онгон, булш гэсэн зургаан хэсгээс бүрддэг болохыг судлан тогтоосон байна. Гүнжийн сүмийн эргэн тойронд байх хэрмэн хананы өндөр 2.5 метр, өргөн ба урт нь 70 метр бөгөөд нийт талбай нь 4900 хавтгай дөрвөлжин метр ажээ. Хана нь 4 тоосго зэрэгцүүлэн өрсөнтэй тэнцэх зузаантай. Хэрмэн дотор байх Богд хаалга 10 метр өндөр, 6 метр өргөн. Гүнжийн сүмийн онгон тэгш дөрвөлжин хэлбэртэй, урдаас хойш нэвт гарах замтай. Булшны хэсэг онгоны ард талд байх бөгөөд судалгаа хийх үед өмнө талд нь байгаа булшны доор гантиг чулуун барилга байгаа нь тодорхой болжээ.

Газар нутгийн хэмжээ	803.9 мянг.га
Багийн тоо	5
Өрх	1 287
Хүн ам	3 862
Улаанбаатар хотоос	77 км
Аймгийн төвөөс	97 км

Малын тоо	171 989
Адуу	12 172
Үхэр	18 188
Тэмээ	15
Хонь	84 253
Ямаа	57 361

АЙРАГ, АДУУНЫ НУТАГ
ЭРДЭНЭСАНТ

Түшээт хан аймгийн Зоригт вангийн хошуу 1920 онд засаг захиргааны шинэтгэлээр Богд Хан Уулын аймгийн Хүнцэлцавчидханд уулын хошуу болон өөрчлөгдөж байжээ. Эрдэнэсант сум гэж нэрийдэх болсон цагаас хойш эдүгээ түүхэн хөгжлийн 90 жилийн замналыг туулжээ.

БАТХААН УУЛ

Төв аймгийн Эрдэнэсант, Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутгаар дамнан, баруун хойноос зүүн урагш чиглэн 30 орчим километр үргэлжлэх нурууны ноён оргил Батхаан далайн түвшнээс дээш 2178 метр өндөрлөгт оршдог. Улаанбаатараас баруун урагш 250 км, Эрдэнэсант сумын төвөөс 33 км зайтай оршдог. Батхаан уул нь дархан цаазат Богд хан, Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт орших Хөгнө хан уулсын оргилтой хараалан цэнхэртдэг.

Анх эл уулыг Хүнцэл цавчил гэдэг байсан агаад Халх Ойрдын тулааны үед Халхын цэргийг бат найдвартай хамгаалсан гэж бэлгэдэн Батхаан гэх болжээ. Тайгын нуруунд нь ан амьтан шивээлсэн, талын уудамд нь мал сүрэг шилгээсэн өгөөмөр баян энэ хайрхныг 1957 онд дархалсан бөгөөд өдгөө ч нутгийн зон олон хуучин уламжлалаар нь тахисаар байна. Батхаан уулын овоог доогуур нь, дундуур нь, дээгүүр нь хөгнөж, гурван талаас нь гурамсан хуйвтай уурга тавьж, гурван ууцаар идээ шүүс өргөдөг уламжлал өнөө ч хэвээрээ. Хангайн Хэнтийн уулархаг мужид багтах уг уул Орхон Туул голын сав газарт бэсрэг уулсын нэг бөгөөд Монгол орны хамгийн өмнөд захын ой бүхий уул гэдгээрээ онцлог. Ойт хээрийн бүсээс тасархай оршдог Батхаан уулын төв хэсэг нь ус намагтай, уулын хар шороон хөрстэй жинхэнэ ойт хээрийн байгалийн төрхтэй. Эндээс арваад жижиг горхи эх авч урагш, хойшоо урсдаг. Уулын урд үзүүрт Ар жаргалант, Өвөр жаргалант хэмээх хоёр голын эх байдаг бөгөөд энд Монгол элс гэж алдаршсан Элсэн тасархайн зах хүрч ирдэг. Ар жаргалант голын элсний захаас эхлэн хайлаасны төгөл даган хойд хярыг давахад Тольтын ам харагдана. Түүнийг даган өгсөхөд их ой руу явж орох бөгөөд хус, шинэс голлосон ой нь ан амьтан, жигүүртэн шувуудаар баялаг. Батхаан уулын голын бүх хөндийгөөр элсэн манхантай бөгөөд энэ элс зүүн урагш салхинд туугдан нүүж Өвөр Жаргалант голын хөндийн урд ар, дунд хэсгийг дарсаар байгаа ажээ. Их элсэн манхантай, говийн бүсийн хайлаас мод ихээр ургасан, хангайн бүсийн өтгөн шигүү ой нэг дор цогцолсон байгалийн энэхүү өвөрмөц тогтолцоо нь дэлхийд ховор юм. Тиймээс энэ ховор нандин тогтоц бүхий 21 850 га талбайг 1957 онд дархлан хамгаалж Байгалийн нөөц газар болгожээ.

Газар нутгийн хэмжээ	302.4 мянг.га
Багийн тоо	5
Өрх	1 311
Хүн ам	4 369
Улаанбаатар хотоос	216 км
Аймгийн төвөөс	259 км

Малын тоо	386 821
Адуу	31 966
Үхэр	18 972
Тэмээ	175
Хонь	212 777
Ямаа	122 931

ТЭД М.ЭНХБОЛДЫН ТУХАЙ

ШУА-ийн ерөнхийлөгч Б.ЭНХТҮВШИН:

ШИНЖЛЭХ УХААНЧ ТӨР, НИЙГМИЙН ЗҮТГЭЛТЭН

Миеэгомбын Энхболд эрдэмтний гэр бүлд мэндэлж, шинжлэх ухааны орчинд өсч торнисон гэгээлэг ертөнцийн хөвүүн бөлгөө. Түүний сэтгэл нигүүлсэнгүй, сэтгэлгээ оюунлаг, аливаад шинжлэх ухааны үндэстэй ханддаг, төр нийгмийн зүтгэлтэн.

Аливаа улсын оршин тогтнож, хөгжих үндэс нь ухаалаг төр, шинжлэх ухааны хөгжил байдгийг мэдэрч, Монгол Улсын хөгжлийн цогц бодлогыг эрдэмтдийн оролцоотойгоор удирдан боловсруулж, УИХ-аар батлуулан хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулахад голлох үүрэг гүйцэтгэсэн.

Ерөнхий сайдаар ажиллахдаа Монгол Улсад шинжлэх ухааныг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг дэлхийн жишгээр боловсруулан батлуулж, эрдэмтдийн олон жилийн судалгааны үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулахад онцгой үүрэгтэй Технологийн инкубатор, Байгалийн шинжлэлийн нэгдсэн лаборатори байгуулах анхны шийдвэр гаргасан юм.

М.Энхболд үндэсний түүх, хэл, соёлыг эрхэмлэн дээдэлж, түүх, соёлын дурсгалыг сэргээх олон ажлыг санаачлан хөөцөлдөж, хэрэгжүүлсэн билээ. Шинэлэг үзэл санааг онцгой анхаарч дэмждэг хүн. Ерөнхий сайдаар ажиллаж байхдаа Үндэсний инновацийн асуудлыг боловсруулахыг анх санаачилж, хожим нь Засгийн газрын хөтөлбөр болж батлагдсан юм.

"Мэдлэгийг баялаг болгохыг товчхондоо инноваци гэх байх аа" гэж хэлж байхыг нь сонсоод бодитой сэтгэдэг, монгол сэтгэлгээтэй хүн юм гэсэн бодол төрж билээ.

1990 оноос хойш зах зээлийн шилжилтийн ороо бусгаа үед шинжлэх ухааны ач холбогдлыг үгүйсгэх, хүрээлэн, эрдэмтэн судлаачдыг цомхотгох, төсөв зардлыг нь танах болчимгүй бодлого өнөө хэр үргэлжилсээр буй билээ. М.Энхболд дарга ямар ч үед шинжлэх ухааны бий болсон чадавхийг авч үлдэх, цаашид шинэ нөхцөлд өөрчлөн шинэчилж хөгжүүлэхэд онцгой анхаарлаа хандуулж ирсэн. Тухайлбал, 2010 онд Ё.Отгонбаяр сайдын үед ШУА-ийг үндэсний хүрээлэнгүүд болгон салгаж холбогдох яамдад харьяалуулах асуудал тавигдахад, 2015 онд Ч.Сайханбилэгийн Засгийн газрын ШУА, хүрээлэнгүүдийн төсвийг хасах, их дээд сургуулиудтай нэгтгэх шийдвэрийг тууштай эсэргүүцэж "Энэ 2015 оны төсөв шинжлэх ухаан, ард иргэдэд халтай төсөв" болж байгааг хурцаар шүүмжилж шинжлэх ухааныг өмгөөлөн хамгаалж байсан.

Энэ нь шинжлэх ухаанд аль нэгэн улс төрийн өнцгөөс бус өөрийн үзэл бодол, итгэл үнэмшил, эх орон, ард түмний эрх ашгийн үүднээс ханддаг хүн болох нь харагддаг юм.

М.Энхболд Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн тэргүүлэгч гишүүнээр улиран сонгогдож, шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, судалгаа боловсруулалтыг сайжруулах, бүс нутгийг шинжлэх ухааны үндэстэй хөгжүүлэхэд хувь нэмэр оруулсаар байна.

М. Энхболдын аав Ардын багш, доктор, профессор Г.Миеэгомбо 1968 онд "БНМАУ-ын ажиллах хүчний нөхөн үйлдвэрлэлд үйлдвэрлэлийн бус хүрээний гүйцэтгэх үүрэг" сэдвээр эдийн засгийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалж 1980 онд Монгол Улсын

удирдах боловсон хүчнийг бэлтгэдэг Намын дээд сургуулийн захирлаар томилогдсон юм.
Нэгэн үе манай эх орны нам, төр, нийгэм, үйлдвэрлэлийн ихэнх салбар, хөдөө аж ахуй, орон нутгийн бүхий л шатны удирдлагад Миеэ багшийн шавь нар ажиллаж, улс орныг удирдаж байсан нь бодит үнэн юм.

Энхболдын гэр бүл бол эрдмийн гэр бүл юм. Түүний гэргий Ж.Туяацэцэг ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн захирал, Монгол Улсын зөвлөх инженер, доктор. Манай дээд боловсролын салбарын шилдэг менежер хүн. ШУА-ийн Биологийн салбарын Бага чуулганы гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Биологийн Бага чуулган бол биологийн шинжлэх ухааныг хөгжүүлэх, энэ чиглэлээр хийгдэж буй судалгааны ажилд үнэлэлт дүгнэлт өгөх, биологийн суурь ухаан дээр тулгуурласан орчин үеийн дэвшилтэт технологийг хөгжүүлэх зорилго бүхий Шинжлэх ухааны Академийн бүтцийн байгууллага бөгөөд манай орны эрдэм судлалын ажлыг идэвхтэй эрхэлж буй докторуудын оюун бодлоо уралдуулдаг талбар юм.

Тэрээр молекул биологи, генетикийн судалгаануудыг зохион байгуулах, харилцан туршлага солилцох, залуу боловсон хүчнүүдийг сургах, дадлагажуулах зэрэг ажлыг удирдаж байна.

Түүхийн ухааны доктор, профессор, Түүхийн хүрээлэнгийн захирал

Сампилдондовын ЧУЛУУН:

ТҮҮХ, УЛАМЖЛАЛДАА ИХЭЭХЭН ХҮНДЭТГЭЛТЭЙ ХАНДДАГ

XX зууны 1911, 1921, 1990 оны түүхэн хувьсгалууд бүгд Төв аймгийн нутаг дэвсгэрт өрнөн үр дүнд хүрсэн түүхтэй. Энэ зуунд Төв аймгаас төр, нийгмийн зүтгэлтэн олон төрөн гарсан нь үүнтэй холбоотой юм . Тэдний нэгэнд Монгол Улсын 24 дэх Ерөнхий сайд, Улсын Их Хурлын дэд дарга Миеэгомбын Энхболд зүй ёсоор орох буй заа. Олон түүхт ойнуудыг тэмдэглэх үед М.Энхболд даргын удирдлагад ажиллахад тэрээр Монголын төрт улсын түүхийг урагшлуулж, Хүннү бол өнөөгийн монголчуудын өвөг дээдэс, голомт мөн болохыг бататгах, түүхийн судалгааг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулахад гойд анхаарч, Үндэсний болон ардын хувьсгалын түүхт ойг улс орон даяар төдийгүй дэлхий дахинд сурталчлахад өндөр ач холбогдол өгч, эх түүх уламжлалдаа ихээхэн хүндэтгэлтэй ханддаг болох нь илт мэдрэгддэг юм. Монголын эх түүхийг үнэн зөвөөр таньж мэдүүлэх, уламжлалаа эрхэмлэн дээдлэх, төрт ёсоо хүндэтгэх талаар олон ажлуудыг санаачлан, хийж гүйцэтгэсэн байдаг. Тухайлбал, Их соён гэгээрүүлэгч Өндөр гэгээн Занабазарын түүхт ойг тэмдэглэх, Улсын нийслэл Улаанбаатар хотын түүхт нүүдлийн газруудыг шинээр тогтоолгон, хүндэтгэлийн хөшөө босгох, Их Монгол Улсын 800 жилийг ойг удирдан зохион байгуулах, Туулын Хар Түнэд орших Ван хаан Тоорилын хотыг хамгаалалтад авах зэрэг олон ажлыг хийсэн нь түүхэнд нэгэнт үлдэж хоцорсон байна. Түүнээс гадна Төв сайхан нутгийн залуусаа байнга дэмжиж, түүх соёл, уламжлалтай холбоотой олон асуудлыг удирдан чиглүүлж, бодитой ажлуудыг хийсэн бас хийсээр байна.

Батсүмбэр сумын уугуул, Монголын сайтуудын холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, сэтгүүлч

Жарантайн ЖАРГАЛСАЙХАН:

ХОВОР ЧАНАРТАЙ ХҮН

Нутаг усныхны минь бахархал болсон эрхэм төрийн түшээ, нэртэй улстөрч М.Энхболд даргыг би Монгол төрийн тусгаар тогтнол, бат бэх байдал, Монголын ард түмний хувь заяанд чухал нөлөөтэй, тулхтай, өнөөгийн төрийг заавал түшиж явах учиртай нэгэн багана гэж хардаг. Миний бие сэтгүүлчийнхээ ажил үүргийг гүйцэтгэж явахдаа “Миеэгомбын Энхболд аливаа зүйлийн талаар хэлтлээ бодож эргэцүүлдэг, нухацтай ханддаг, хэрэв нэг хэлсэн л бол түүнийгээ хийдэг, хэрэгжүүлдэг, хэлсэндээ хүрдэг хүн” гэж байхыг зөвхөн өөрийнх нь намынхан төдийгүй Ардчилсан нам зэрэг өрсөлдөгч улс төрийн хүчний олон лидеруудийн амнаас сонсч байсан. Энэ бол урваж шарвадаг, ухарч буцдаг нь хэтийдсэн өнөө цагт маш ховор чанар юм.

Баян-Өнжүүл сумын уугуул, яруу найрагч

Цэвэг-Очирын ЭРДЭНЭБААТАР:

МОНГОЛ ЖУДГАА ДЭЭДЭЛДЭГ ТӨРИЙН ТҮШЭЭ

УИХ-ын дэд дарга, МАН-ын дарга М.Энхболд хэмээх эрхэм хүнийг манай аймгийнхан "Шадар” гэх ба миний үеийнхэн ах хэмээнэ. Амьхандаа ихэд өөриймсөж байгаа юмдаг уу даа. Үнэндээ өөриймсмөөр ч, хүндэлмээр ч хүн л дээ...

Нэрэн дээрээ шударга ёсны лянхуаг дэлгэрүүлэвч нэдэр дээрээ шунал тачъяалын олсонд хүлүүлсэн хуурмаг улстөрчид нь ихэдсэн эдүгээ он цагт атаа хорсол, гүттэлгийн будгаар цацуулсан ч үл тоон үгний бэлбүүрт бус үнэний билүүнд ойр байж эх орныхоо язгуур соёл, монгол жудгаа дээдлэн зүтгэж буй төрийн түшээ юм.

Батсүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга

Дэнзэнгийн ГАНБОЛД:

ИРГЭДИЙН САНАЛ САНААЧИЛГЫГ САЙН СОНСДОГ

М.Энхболд даргатай 2008 оноос ойр хамтран ажиллаж байна. Иргэдэд төр засгийн бодлого, шийдвэрийг тоо баримттай, үндэслэлтэй тайлбарлан танилцуулж, сурталчлахын зэрэгцээ иргэдийн санал санаачилгыг сайн сонсдог, дэмждэг. Ер нь нэг санаачлаад эхлүүлсэн ажлынхаа үр дүнг нь заавал үздэг. Өмнө хамтран ажиллаж байсан, уулзсан хүнээ мартдаггүй дэмждэг сайхан жудагтай хүн юм билээ.

Баянцагаан сумын үүгүүл, Нийслэлийн НАМЗХ-ны тэргүүн

Пүрвээгийн БАЯРХҮҮ:

ОЧСОН ГАЗАРТ НЬ АЖИЛ БҮТЭЖ БАЙДАГ ХҮН

М.Энхболд даргыг танихгүй хүн байхгүй биз ээ. Бодоо агсаны дараа Төв аймгаас төрсөн хоёр дахь Ерөнхий сайд бөгөөд Шадар сайд, Нийслэлийн Засаг даргаар олон жил ажилласан улс төрийн болон удирдах, аж ахуйн ажлын арвин баялаг туршлагатай хүн. М.Энхболд даргын санаачлан хэрэгжүүлсэн ажлуудыг тоочвол уртаас урт жагсаалт гарах нь дамжиггүй. Төв сайхан нутгаас минь төрөн гарсан төр, нийгмийн зүтгэлтэн энэ хүн хариуцсан ажилдаа зангарагтай, төлөв төвшин, нуруутай, удирдах арга барил, бүтээлч чанараараа бусдаас ялгарах, аливаа ажлыг алсыг харж, өргөн хүрээнд сэтгэн хийж чаддаг Монголын төрт ёсны түүхийг бичилцэхэд жинтэй хувь нэмэр оруулан өөрийн гэсэн өнгө, төрхтэй тод мөрийг үлдээж яваа нэгэн билээ. Энэ хүний очсон газрын ажил хэрэг нь болж бүтэж, босгож бүтээсэн ул мөр нь үлдэж байдагт бахархаж явдаг шүү.

Баяндэлгэр сумын үүгүүл, Монгол Улсын начин

Чулуунбаатарын БАТЧУЛУУН:

100 ХУВЬ БӨХЧҮҮДИЙН МЭДЭЛД БАЙДАГ

Сүүлийн үед манай аймаг чинь бөхийн дэвжээ байгуулаад хамтарч цугларч бэлтгэл хийгээд сайхан байгаа. Дэвжээтэй болсноос хойш Ок начин нэг, Батмөнх хоёр, би нэг шовгөрлөө. Олон жил шовөггүй явж байгаа аймаг олон л байгаа биз дээ. Бусад аймгийн дэвжээнд яг тийм өөрийн гэсэн бааз одоогоор байхгүй л болов уу. Их сайхан тохижилттой газар бий. Одоо спорт заал нь баригдчихвал болох гээд байгаа юм. Дэвжээ маань 100 хувь бөхчүүдийн мэдэлд байдаг. Дуртай үедээ очоод бэлтгэл хийх боломжтой. "Дүнжингарав" бөхийн дэвжээний тэргүүн М.Энхболд ах өөрөө санаачилга гаргаж нутгийн ах нар дэмжээд ийм сайхан байртай болгож өгсөнд бөхчүүд бид их баяртай байгаа.

Эх сурвалж: "Зууны мэдээ" сонин

Монголын морин спорт, уяачдын холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга

Пүрэвийн Сэргэлэн:

НУТАГТАА НЭРТЭЙ ХҮН САЙХАН ЮМ БИЛЭЭ

М.Энхболд дарга дэлхийн дээд амжилтыг монгол хүн морьтойгоо шинэчлэн тогтоохыг санаачлан зохион байгуулах явцад нийгмийн зүгээс хүүхдийн аюулгүй байдал, зохион байгуулалт тал дээр маш их сөрөг хандлагууд гарч байсан. Гиннессийн 11125 морьтны их жагсаал, 4249 морины уралдаан эхлэх өглөө Хүй долоон худагт ирээд морь хүүхэд хоёр эсэн мэнд, монголчуудын маань үйлс өөдрөг бүтэмжтэй байгаасай хэмээн 2 цаг хэртэй бурхандаа залбираад гэж хэлэхэд нь санаачилсан ажлаа бүтээхийн төлөө ямар их шаналж, улстөрчийн хувьд их золиос гаргасныг ойлгож билээ. Эв нэгдэлтэй бол бидэнд чадахгүй зүйл байхгүй дээ. Монголчууд мориороо, адуугаараа л Дэлхийн дээд амжилт тогтоох ёстойдоо гэж хэлж зогссон. Нутаг орондоо нэр хүндтэй хүн сайхан юм билээ. Төв аймагчууд маань сайхан дэмжиж 3000 орчим морьтон жагсааж, 800 гаруй морь уралдуулж ёстой морьтой хүнтэйгээ боссон доо. Хүй мандалын дэвжээ хүн, морь хоёроор бялхсан тэр өдөр уул усны нь хиймор сэргээ биз дээ.

Баянцагаан сумын үүгүүл, аймгийн Алдарт уяач

Даваахүүгийн БАЯНБАТ:

ЗАЛУУ ХҮНИЙГ ДЭМЖСЭН ШИГ ДЭМЖДЭГ

Өнгөрсөн жил Наран хонгор азарга маань үндэсний их баяр наадамд түрүү магнайд давхиж Төв аймагчууд төр түмний их баяр цэнгэлийн азарганы түрүү авсан гэж их бэлгэшээж явна. Энэ жилийн хувьд залуу уяачид улс, бүсийн уралдаанаас олон айраг түрүү хүртлээ. Ер нь хөдөө орон нутаг нэг хэсэг эзгүйрэх хандлагатай байсан. ММСУХ-ноос хурдан морины уралдаанд монгол адууг эрлийз адуунаас тусад нь уралдуулах шийдвэр гарснаар олон залуучууд орон нутагтаа морио уяж, ажиллаж амьдрах дуртай болоод байна уу гэж боддог юм. Энэ бол ММСУХ-ны зөв бодлогын үр дүн юм даа. М.Энхболд тэргүүний хувьд залуу хүнийг сайхан дэмждэг юм. Миний бие 2010 онд Монголын морин спорт, уяачдын холбооны шугамаар Японы морин уралдааны холбооны 14 хоногийн сургалтад хамрагдаж дэлхийн морины соёлтой танилцаж байсан сайхан дурсамжаа эргэн санахад таатай байна.

Эрдэнэ сумын ИТХ-ын дарга, "Алтан шанага 2014" наадмын шилдэг залуу улстөрч

Норжмаагийн МӨНХСАЙХАН:

ХӨДӨӨГИЙН АМЬДРАЛ МЭДДЭГ

Би нутгийн өөрөө удирдах байгууллагын хуралд 15 жил ажиллаж байна. М.Энхболд гишүүнийг аймаг орон нутгийн түвшинд бүх насны иргэдийн төлөөлөлд хүрч, тэдний бодол санаа сэтгэгдлийг сонсож мэдэрч ажилладаг гэж би үнэлдэг. Төрд иргэдийн төлөөлөл болж ажиллахдаа хүн, малын ундны хэрэгцээ болон бэлчээрийн хомсдол, цөлжилтийн эсрэг малчдын үйл ажиллагаа санаачилгыг дэмжих, малчдын хүүхдүүдийн амьдарч, сурч боловсрох орчныг сайжруулах, малгүй айл өрхийг малжуулах, малын үүлдэр угсааг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх чиглэлээр хөдөө рүү хандсан олон бодитой ажил хийсэн. Хүмүүсийг хөгшин залуу гэлтгүй хүлээцтэй сонсдог, яриа хөөрөөтэй, хөдөөгийн амьдралыг сайн мэддэг юм билээ. Одоо ийм дарга ховор болсон цаг шүү дээ.

Өндөрширээт сумын үүгүүл, UBS телевизийн ерөнхий редактор

Өвгөнхүүгийн ГЭРЭЛТЦЭЦЭГ:

МӨРӨӨДЛӨӨ ЭХЛҮҮЛЭХЭД ТУСАЛЖ ЧАДДАГ

Залуучуудыг их дэмждэг улстөрч. Ялангуяа улс орныхоо нэрийг гаргаж яваа залуучуудаа марталгүй заавал урамшуулдаг сайхан чанартай. Тамирчид, авьяастнууд гэлтгүй амьдралаа эхлүүлж яваа залууст хийж чадах бүхнийг нь хийхэд ч, мөрөөдөж болох бүхнийг эхлүүлэхэд нь ч тусалж чаддаг. М.Энхболд гуайг дарга боллоо, сайд боллоо гэж харахаас илүү улс орны хариуцлага өндөртэй чухал ажил албуудыг залгуулж яваа төрийн хүн гэж хардаг. Нутгийнхаа хөгжлийг ирээдүйд авч явах хүүхэд залуучуудыг чиглүүлж, зөв монгол хүн болгон төлөвшүүлэхэд нь их хувь нэмэр оруулж чадах хүн дээ.

НҮҮДЭЛЧДИЙН ХОТЫН ИХ НҮҮДЭЛ

Монгол Улсын гал голомт Улаанбаатар хотыг “Нийслэл хүрээ” хэмээн өргөмжилсний 100 жилийн ойг угтан Улаанбаатар хотын захирагч М.Энхболд нэгэн их ажлыг зориглон эхлүүлсэн нь эрдэмтэн судлаачдын анхаарлыг Нийслэл Хүрээний их түүхэнд хандуулсан явдал байлаа. Мөн тэрээр санаачлан “Хүрээ нүүдэл” хөтөлбөрийн хүрээнд түүхийг баримтжуулан, хожмын залууст түүх соёлын дурсгал болгон үлдэх 17 хөшөө дурсгал босгосон нь нийслэлийн төдийгүй Монгол Улсын түүх судлалд үнэтэй хувь нэмэр болохуйц ажил болжээ. Өдгөө энэхүү буянтай үйлсийн ач тус улам бүр өргөжиж эл түүхэн жимийг дагасан аялагч жуулчдын зам тодорч, Монголыг дэлхийн иргэдэд танилцуулах аялал жуулчлалын бүтээгдэхүүн болох нь дамжиггүй.

Нүүдэлчин Монголын түүхийн нэгэн хэсэг болох Нийслэл Хүрээний түүхийн улбааг тухайн үед 1912 оноос эхлэн тоолдог байсан төдийгүй Улаанбаатар хотын тухайд энэ он дараалал бүр 1924 он гэж тооцогдсоор ирсэн нь нууц биш юм. Харин М.Энхболд даргын эхлүүлсэн ажлын үр дүнд нүүдэлчдийн хот Улаанбаатарын түүх 1639 оноос эхлэн өнөөдрийг хүртэл түүчээлсэн нь тодоос тод болсон юм. Нийслэл Орхон, Тамир, Туул голуудын хөндий дагуу 29 удаа нүүдэллэсний эцэст 1778 онд одоогийн байгаа газраа тухалж, шинэ цагийн хийгээд эрт эдүгээгийн өнгө төрхөө олох хүртлээ нийтдээ 29 удаа нүүдэллэсэн гэдгээрээ дэлхийн аль ч улс орны нийслэлүүдээс ялгарах тод өнгө юм. ***Их нүүдлийн зам өнөөгийн Төв аймгийн нутагт хэдэнтээ буудалласан байдаг нь өгөөмөр баян энэ нутаг цагийн цагт Монголын цохилох зүрх нийслэлийн түүхтэй салшгүй холбоотой байх ерөөлтэй гэлтэй. Цагийн цагт Монгол Улсын лугшиих зүрх, хөгжлийн хөтөч нь байсаар ирсэн Их Хүрээ Төв аймгийн нутгаар нүүдэллэсэн түүхэн жимээр хамтдаа аялцгаая.***

УГ СУРВАЛЖ

Монголын нууц товчоонд тэмдэглэснээр 12-р зууны хоёрдугаар хагаст Хэрэйд аймгийн удирдагч Ван ханы өргөө нь Туулын хар шугуй гэдэг газар байв гэж тэмдэглэсэн нь одоогийн Улаанбаатар хот оршиж буй хөндийг гэж судлаачид таамагладаг. Их Монгол Улсын анхны нийслэл Хархорум хот нь Орхон голын хөндийд цогцолсон ба Юань улс нуран унасны дараа Мин улсын довтолгоонд хоёронтой галдан шатаагджээ. Түүнээс хойш монголчууд нэгдмэл байдалгүй болоод нүүдлийн иргэншилд бүрэн шилжиж, хот байгуулах завдалгүй дотоод, гадаадад тэмцэлдэн байлдацгааж байснаас үүдэн, амарлингуй байдлыг дэлгэрүүлэхээр 16-р зуунаас шарын шашинд сүсэглэснээр Монголд сүм хийдүүд баригдаж эхэлсэн юм. Ингэснээр монголчуудын хот, хүрээ цогцлоох идэвх сэргэж, анхлан Абатай сайн хаан Хархорум хотын бууринд Эрдэнэ зуу хийдийг босгожээ.

ШИРЭЭТ ЦАГААН НУУР

Хэдийгээр Ширээт Цагаан нуур Төв аймгийн нутагт хамаарахгүй ч гэлээ их түүхийн эхлэл цэгт очих нь бурууюун билээ. Эндээс аяллаа эхэлцгээе. Их хотын анхны үүсч, ёслол үйлдсэн газрыг Ширээт Цагаан нуур гэж эрдэмтэд тодруулсан. Далайн түвшнээс дээш 1800 метр өргөгдсөн хоорондоо 10-аад км зайтай орших Их Монгол, Бага Монгол гэх хоёр улаан хүрэн уулын дунд орших Цагаан Нуурын хойд хөвөөн дээр Ширээ мэт тэгш оройтой багавтар толгой бий. Түшээт хан Гомбодоржийн хүү Занабазарыг анхны Богд Жибзундамба хутагтаар өргөмжлөн 1639 онд одоогийн Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутаг дахь Ширээт цагаан нуур гэдэг Өргөө цогцлоожээ. Ингэж нүүлгэхдээ Эрдэнэ зуу хийдийн доторх мөнхийн галтай Баруун өргөөг нүүлгэн гаргаж Занабазарын өргөөтэй нэгдүүлж Ширээ цагаан нууранд аваачжээ. Баруун өргөө нь төрийн гал голомтын бэлгэдэл өргөө байж. Ингэж төр, шашны гол үнэт зүйлсийг нэгдүүлснээр нийслэл үүссэн гэж үздэг. 1747 онд Хүрээг эл газраас нүүлгэсэн ажээ.

ӨГӨӨМӨР

Галдан Бошигтын шахалтад түрэгдсэн Өндөр гэгээн 1688 онд Хэрлэн гол руу зайлж гарсан боловч бошигтын цэргүүд түүнийг Туул, Хэрлэнгийн эх хүртэл нэхэж, Хэнтийн нуруунд Өндөр гэгээний байгуулж байсан Сарьдагийн хийдийг нурааж шатаажээ. Иймд Өндөр Гэгээн Хэрлэнгээс урагш дайжиж одоогийн Төв аймгийн Баян сумын нутаг Өгөөмөрийн Их, Бага булагт өвөлжсөн байна.

ЖАРГАЛАНТ

1723 онд Төв аймгийн Жаргалант сумын төвөөс урагш Жаргалант голын дэнж Буурал уулын бэлд нийслэл хүрээ нэгэнтээ өвөлжжээ.

УГТААЛ ЖАРГАЛАНТ

1724 онд Жаргалантаас баруун зүг ойрхон нүүж одоогийн Төв аймгийн Жаргалант, Угтаал цайдам сумын нутгийн заагийн ойролцоо Угтаал гол, Дэлгэрбулагийн бэлчрийн зүүнтээ буудаллаж байгаад хавар нь Ээвэн гол руу нүүжээ. Жаргалант Угтаалжаргалант хоёр уул хоёул байгаль нь үзэсгэлэнтэй Хүүлэй хан уулын ар бэлд орших ургамал, ус бэлчээр тэгш сайхан нутаг юм.

СӨГНӨГӨР

Хүрээ 1730-1732 онд өнөөгийн Төв аймгийн Батсүмбэр сумын нутаг Сөгнөгөрийн голын адаг Алтан бүс уулын Их нарстайн амны дэнжид суурьшжээ. Энд байгаль нь үзэсгэлэнтэй сайхан боловч хүрээний олон гэр, асар байршихад талбай жижиг, хавчигдмал байсан тул Бургалтайн гол руу нүүсэн аж.

БУРГАЛТАЙН ГОЛ

Бургалтайн гол бол Төв аймгийн Батсүмбэр сумын нутагт байх агаад энэ нутагт 1732-1733 онд Хүрээ суурьшиж байсан түүхтэй. Яг үүгээр Хиагт орох худалдааны зам дайрч хятад худалдаачид, явуулын хүмүүс ихээр сүлжилдэх болсон байна.

ТЭРЭЛЖ-ТУУЛЫН БЭЛЧИР

Хоёрдугаар Богдыг найман нас хүрэхэд Их Хүрээг түүний төрсөн газарт ойртуулж одоогийн Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг Туул, Тэрэлжийн бэлчир Бумбат ухаагийн энгэрт байгалийн үзэсгэлэн бүрдсэн нутагт байршуулжээ. Хоёрдугаар Богд нь Тэрэлж Гурван баяны хоорондТуулын хөндийд төрсөн ажээ. Тэрэлж Туулын бэлчир Монгол орны төв хэсгээс арай зайдуу байсан тул Хүрээг Хүйн гол руу нүүлгэжээ. Туул Тэрэлжийн бэлчир нь далайн түвшнээс дээш 1500 метр өргөгдсөн бөгөөд энэ нь Хүрээ суурьшиж байсан хамгийн өндөрлөг газар юм.

ХҮЙН ГОЛ

Хүрээ 1736-1740 онд одоогийн Төв аймгийн Батсүмбэр сумын нутаг Хүйн голын эхэнд Хүйн нуурын баруун дэнжид суурьшиж байв. Энэ нуурыг хожим нь Наваан Жалбын нуур гэж нэрлэх болжээ. Ер нь Нийслэл хүрээ 1730-1778 оны хоорондДундаа багахан завсарлагатайгаар Хүйн гол, түүний цутгал Сөгнөгөр, Бургалтай, Хунцал, Үдлэг, Хүй мандал зэрэг газарт ойрхон ойрхон нүүж суурьшиж байсан юм байна. Хараа голын эх Хүйн голын хөндий нь ус бэлчээр, хужир мараа сайтай, зүүн талаараа Хан Хэнтийн ой модтой эмжээрлэн залгасан их хот суурин байхад ихэд тохиромжтой нутаг юм. Хүрээ бууж, хоёрдугаар Богдын өргөөг барьж байсан суурин дээр 1949 онд төмөр замын зөрлөгийн байшин барьсан байна. Хүйн нуурыг 1940-өөд он хүртэл байнга тахидаг байжээ.

ХУНЦАЛ

Төв аймгийн Батсүмбэр сумын нутаг Хунцалын голын эх Нарстайн өвөрт 1740-1742 онд Хүрээг суурьшуулжээ. Энэ үед Хүнцэлийн голд Хиагтын Их замын өртөө байгуулагдаж, хятад худалдаачид цувах болсноос гадна Хунцалын голын эх нь харьцангуй хавчигдмал талбайтай газар байсан төдийгүй бэлчээр ус дутагдах болсон тул хүрээг Үдлэг рүү нүүлгэжээ.

ҮДЛЭГ

Хүрээ 1742-1743 онд Төв аймгийн Батсүмбэр сумын нутаг Үдлэгийн голд (зарим эх сурвалж Өдлөг гэж ярьж, бичих нь бий) суурьшжээ. Үдлэгийн Хүрээ үүссэний дараа хоёрдугаар Богдын өргөө байсан буурин дээр багавтар хурлын сүм барьсан нь 1921 оны хоёрдугаар сарыг хүртэл 180 шахам жил тогтмол хурал ном хурдаг байж. Харин тухайн сард Барон Унгерн, Лувсанцэвээн тэргүүн, өндөр Дугаржав нарын цэрэг нийслэл Хүрээнд байсан хятадын гамин цэргийг бут цохиж, хэдэн мянган цэрэг Хүрээнээс хойш Хиагт тийш зугтах замдаа Барон Унгерний цэрэгт зам зааж газарчилсан гэх шалтгаанаар Шадивлан хийдийн 20 орчим ламыг сүмд нь түгжин шатаагаад улмаар Эрээн гуяын даваагаар давж, Үдлэгт очоод Үдлэгийн хийдийн лам нараас хоол хүнс нэхжээ. Лам нар “Одоо хурал хурж байна, хурал тараад уналгын морьд цуглуулж өгье” гэсэнд гамин цэргүүд хорсож Үдлэгийн сүмд лам нарыг нь түгжиж өс овоолон шатаажээ. Хэд хоногийн дараа шатсан сүмийн үнс чандруу хийсэхэд сүмийн үнс нурам дотроос нэгэн толгойгүй хөшөө ил гарчээ. Намар нь Хараа голын хөндийгөөр хаа сайгүй суурьшсан хятад орос ирж тэрхүү хүн чулуун хөшөөг хэсэгчлэн хөрөөдөж тээрмийн чулуу хийхээр авч явсан байна. Энэ түүхийг 1980 он хүртэл Үдлэгт амьдарч байсан Маналжав гэдэг хүн судлаачдад ярьсан байдаг. Маналжав нь Түшээт Хан аймгийн Илдэн гүнгийн хошууны сүүлчийн ноён Дашдоржийн ганц хүү ажээ.

ӨДГӨӨГИЙН УЛААНБААТАР

1756 онд анхны шашны сургууль болох “Цаниг” байгуулагдсан бөгөөд 1786 оноос манж амбанд Сэцэн хан, Түшээт хан хоёр аймгийг хариуцуулах болсон зэрэг олон шалтгаанаас Их хүрээ суурьших шаардлагатай болжээ. 1780-1870 оны хоорондд 70 гаруй суурин сүм, дуган, ялангуяа өнөөгийн Гандантэгчэнлин хийд 1809 онд баригджээ. 1861 онд Оросын консулын газар байгуулагджээ. Хүрээний хүн ам нэмэгдсээр 1910 онд 50 мянга болсон байна.
1911 оны 12-р сард Богд хаант Монгол Улсыг тунхаглаж, Нийслэл хүрээ нэртэй болсон. 1919 онд Сю Шүженээр толгойлуулсан Хятад цэрэгт хот эзлэгдсэн ба 1921 оны 2-р сард Барон Унгернээр толгойлуулсан цагаан цэргүүд Хятад цэргээс хүрээг чөлөөлж, Богдыг дахин хаан ширээнд залсан бол 3-р сард Хиагт хотыг чөлөөлсөн Монгол-Зөвлөлтийн цэргүүд цагаантнуудыг 6-р сард цохин дутаалгаснаас хойш нийслэл нь гадаадын цэргийн түрэмгийллээс чөлөөлөгдсөн. 1924 оны Үндсэн хуулиар Улаанбаатар нэртэй болсон. Социализмын үед болон голдуу Дэлхийн хоёрдугаар дайны дараа ЗХУ-ын тусламж дэмжлэгээр хуучны гэр хороолол нь аажмаар орон сууцаар солигдож эхэлсэн.

МОНГОЛ ЗУРХАЙН "ТҮВДЭНПЭЛЖЭЭЛИН" ХИЙД

Огторгуйд орчигч одон гараг
Орчлонгийн амьтанд сайн
муугаар нөлөөлмүй
Огоорч авахыг мэдүүлэхийн тулд
Оддын зурхайг бичвэй би.

Лувсандансанжанцан (1639-1704)



... Хамаг амьтан амгалан хийгээд
амгалангийн шалтгаан лугаа
төгсөх болтугай.
Хамаг амьтан зовлон хийгээд
зовлонгийн шалтгаан лугаа
хагацах болтугай...

Бурханы сургаалаас

XVII ЖАРНЫ "СОГТУУРУУЛАГЧ" ХЭМЭЭХ МОДОН ХОНЬ ЖИЛИЙН ЦАГ УЛИРЛЫН БИЧИГ

(2015-2016 он)

Тооллын эхийг зохиосон: Ж.Гончигсүрэн (Гэвш Хамба лам)
С.Даваабаяр (дэд профессор)
Ш.Жамба (Гэвш, лам)
Махбодын зурхайн үрийг: Д.Цолмон (Зурхайч лам)
Нар сарны хиртэлтийг: Одон орон судлах оргилын эрдэм шинжилгээний ажилтан Т.Баяраа
Техник редактор: Х.Баясгалан, Б.Марав
Эх бэлтгэл дизайныг: Н.Болдцэрэн

Хаяг: Монгол зурхайн Түвдэнпэлжээлин хийд.
Тасганы овоо
Улаанбаатар хот
2015 он

XVII ЖАРНЫ "СОГТУУРУУЛАГЧ" ХЭМЭЭХ МОДОН ХОНЬ ЖИЛИЙН ШОРООН ҮХРИЙН ЗУРЛАГА

"ШОРООН ҮХЭР"-ийг модон хонь жилийн хаврын амьсгал орсон өдрийн махбодыг гол болгон дүрсэлбэл:

Үхрийн зураглал: Ногоон толгой, шар биетэй, цагаан ходоодтой, эвэр чих сүүл нь цагаан, дөрвөн шийр нь хөх, цагаан омруу бүхий амаа хамхиж, сүүлээ баруун тийш шарвасан үхэр ажээ.

Үхэр хариулаачийн зураглал: Шар дээл өмсөж, хөх бүс бүсэлсэн хөх царайтай, зүүн гутлаа өмссөн, баруун гутлаа зүүн ташаандаа зүүсэн, хоёр гэзгээ чихнийхээ урдуур унжуулсан өвгөн хүн үхрийнхээ өмнө яаравчлан явж буй.

Жилийн ерөнхий зураглал: Хаврын саруудад шороон болон цасан шуургатай. Тариа будаа арвин. Жилийн дунд үед газар тариаланд зохимжтой. Хавар намрын цагт мөндөр буумтгай. Хууль цааз чангарна. Өндөр дээд суудалтанд тааламжтай, түшмэлүүдэд ширүүн, эгэл ардад маш ширүүн жил болно.

ШИНИЙН НЭГНИЙ ӨГЛӨӨ ЗҮГ ЧИГЭЭ ХЭРХЭН ГАРГАХ ВЭ?

Ургасан жилд хүнийг ямар хүлэлд суусныг тооцохдоо эрэгтэй хүнийг "Гал"-аас эхлэн нар зөв, эмэгтэй хүнийг "Ус"-аас эхлэн нар буруу тойруулан билгийн насаар тоолж ямар хүлэлд хүрнэ тэр нь хүний тухайн жилд суух суудал болно. Шинийн нэгний өглөө зүг чигээ гаргахдаа суусан хүллийн хийморийн зүгт гарч буян хишгийн зүгээс ирдэг. Уг цаглабарт огторгуйн жил, хаврын тэргүүн сар, шинийн нэгний өдөр болон луу цагуудын хар нохойн амыг гарган тооцсон тул та дараах хүснэгтэд бичсэний дагуу мөрөө гаргаж, шинэ жилийнхээ ажил амьдралыг эхэлнэ үү.

Суудал	Унших тарни, гарах, ирэх зүг		Төрсөн он
ГАЛ	"Зүүн урд зүгт гарч, «Ум базар пад дагийни хум мама бизъяа суха» тарнийг 7-21 удаа уншаад, урд зүгээс ирнэ."	ЭР	1903, 1911, 1919, 1927, 1935, 1943, 1951, 1959, 1967, 1975, 1983, 1991, 1999, 2007, 2015
		ЭМ	1907, 1915, 1923, 1931, 1939, 1947, 1955, 1963, 1971, 1979, 1987, 1995, 2003, 2011
ШОРОО	"Баруун зүгт гарч, «Ум бадма дагийни хум мама бизъяа суха» тарнийг 7-21 удаа уншаад баруун урд зүгээс ирнэ."	ЭР	1910, 1918, 1926, 1934, 1942, 1950, 1958, 1966, 1974, 1982, 1990, 1998, 2006, 2014
		ЭМ	1908, 1916, 1924, 1932, 1940, 1948, 1956, 1964, 1972, 1980, 1988, 1996, 2004, 2012
ТӨМӨР	"Зүүн хойт зүгт гарч, «Ум радна дагийни хум мама бизъяа суха» тарнийг 7-21 удаа уншаад баруун зүгээс ирнэ."	ЭР	1909, 1917, 1925, 1933, 1941, 1949, 1957, 1965, 1973, 1981, 1989, 1997, 2005, 2013
		ЭМ	1909, 1917, 1925, 1933, 1941, 1949, 1957, 1965, 1973, 1981, 1989, 1997, 2005, 2013
ОГТОРГУЙ	"Зүүн хойд зүгт гарч, «Ум пагма дагийни хум мама бизъяа суха» тарнийг 7-21 удаа уншаад баруун хойд зүгээс ирнэ."	ЭР	1908, 1916, 1924, 1932, 1940, 1948, 1956, 1964, 1972, 1980, 1988, 1996, 2004, 2012
		ЭМ	1910, 1918, 1926, 1934, 1942, 1950, 1958, 1966, 1974, 1982, 1990, 1998, 2006, 2014
УС	"Урд зүгт гарч, «Ум гарма дагийни хум мама бизъяа суха» тарнийг 7-21 удаа уншаад хойт зүгээс ирнэ."	ЭР	1907, 1915, 1923, 1931, 1939, 1947, 1955, 1963, 1971, 1979, 1987, 1995, 2003, 2011
		ЭМ	1903, 1911, 1919, 1927, 1935, 1943, 1951, 1959, 1967, 1975, 1983, 1991, 1999, 2007, 2015
УУЛ	"Баруун хойд зүгт гарч «Ум будда дагийни хум мама бизъяа суха» тарнийг 7-21 удаа зүүн хойд зүгээс ирнэ."	ЭР	1906, 1914, 1922, 1930, 1938, 1946, 1954, 1962, 1970, 1978, 1986, 1994, 2002, 2010
		ЭМ	1904, 1912, 1920, 1928, 1936, 1944, 1952, 1960, 1968, 1976, 1984, 1992, 2000, 2008
МОД	Хойд зүгт гарч, «Ум базар дагийни хум мама бизъяа суха»тарнийг 7-21 удаа уншаад зүүн зүгээс ирнэ.	ЭР	1905, 1913, 1921, 1929, 1937, 1945, 1953, 1961, 1969, 1977, 1985, 1993, 2001, 2009
		ЭМ	1905, 1913, 1921, 1929, 1937, 1945, 1953, 1961, 1969, 1977, 1985, 1993, 2001, 2009
ХИЙ	"Урд зүгт гарч, «Ум базар пад дагийни хум мама бизъяа суха»тарнийг 7-21 удаа зүүн урд зүгээс ирнэ."	ЭР	1904, 1912, 1920, 1928, 1936, 1944, 1952, 1960, 1968, 1976, 1984, 1992, 2000, 2008
		ЭМ	1906, 1914, 1922, 1930, 1938, 1946, 1954, 1962, 1970, 1978, 1986, 1994, 2002, 2010

НАЙМАН ХӨЛӨЛ

Буян хишиг	Цог хийморь	5 ад чөтгөр	Цог хийморь	Буян хишиг	Бие тасрах	5 ад чөтгөр	Бие тасрах	Буян хишиг
Эм	ХИЙ	Бие тасрах	Амь	ГАЛ	5 ад чөтгөр	Хорлол	ШОРОО	Цог хийморь
Шулмас	Амь	Хорлол	Хорлол	Эм	Шулмас	Амь	Шулмас	Эм
Эм	Амь	Хорлол				Бие тасрах	5 ад чөтгөр	Цог хийморь
Буян хишиг	МОД	Шулмас				Шулмас	ТӨМӨР	Буян хишиг
Бие тасрах	Цог хийморь	5 ад чөтгөр				Эм	Хорлол	Амь
Шулмас	Хорлол	Амь	Амь	Эм	Шулмас	Хорлол	Шулмас	Эм
Бие тасрах	УУЛ	Эм	Цог хийморь	УС	Хорлол	5 ад чөтгөр	ОГТОРГУЙ	Амь
Буян хишиг	5 ад чөтгөр	Цог хийморь	5 ад чөтгөр	Буян хишиг	Бие тасрах	Цог хийморь	Бие тасрах	Буян хишиг

МАХБОДЫН ЗУРХАЙН ҮР, ТҮҮНИЙ ЗАСАЛ

Бурханы шашины үндсэн онол нь амьтныг хайрлах, энэрэх, туслах үзэл юм. Энэ зарчмыг бүхий л судар номондоо сургадаг. Зурхайн судар бичигт ч ялгаагүй хүнийг айлгах, гарцаагүй үнэн гэж хүнд тулгах, харамж мөнгө нэхэх, яршиг төвөг удах зэргийг хатуу хориглодог. Нэг үгээр хэлбэл бэрийн зурхайд сайн зүг нь давах боломжгүй цасанд хучигдсан даваа байхад давахыг шаардаж хүн амьтанд төвөг учруулахыг эс зөвшөөрнө. Харин түүний оронд зүгийн заслын ном судар айлтгаж засаад өөр зүгээс ирүүлдэг уян хатан сайхан онолтой.

Бас хүмүүс өөрийн сүсэг бишрэл, хөрөнгө чинээ, орон зай, цаг үедээ тохируулан гүрэм номоо хийлгэхийг цаг ямагт мэргэд сануулж байдаг. Хамгийн гол нь сэтгэл. Сэтгэлээрээ буян номонд хандаж, эргэл мөргөл хийж, Бурхан багшийн айлдсан Таравчинбо, Сандуйн жүд, Алтангэрэл, Жадамба, Доржзодов зэрэг хөлгөн судруудыг хэр чадлаараа уншуулж байвал түүнээс илүү буян гэж үгүй гэж судар бичигт номлодог.

Мөн хурал номын газар гүрэм засал хийлгэхийн зэрэгцээ өөрийн биеэрээ буян хийж байхыг уриалдаг юм. Тухайлбал Маани, Мигзэмийг амны уншлаганд авах, ядарсан зүдэрсэн нэгэнд өглөг өгөх, баярлуулах, хүмүүст талархал илэрхийлэх, амьтны амийг хайрлах, ой мод, уул усаа хүндэлж зүй бусаар ашиглахгүй байх, хүмүүст хор хөнөөлтэй хүнсний бараа бүтээгдэхүүн зарахгүй байх зэрэг бүхий л хүн болон амьтан, эх байгальд хор хөнөөлгүй сэтгэлийн үйл хөдлөлийг буян гэдэг.

Ялангуяа ядууст өглөг өгөх нь том гүрэм засалд тооцогддогийг танд дуулгахад таатай байна.

СУУДЛЫН ЦЭЭР

МОД - Туулай, илжиг, шувуу, бар ирвэсний мах идэх, хутга мэс, худалдан авах, хэрүүл тэмцэл хийх, хөх эд, ангийн арьс авах, мод огтлох зэрэг үйлүүдийг тэвч. Бурханд амь нас, амьдрал ахуйгаа даатгах, алт мөнгөөр гоёж чимэглэх, байшингийн суурь шинээр тавихад сайн. Элэг цөс, гэдэс, хөл өвдөх, яр шарх гарахаас сэрэмжил. Хутга, мэсний аюулаас болгоомжил. Тээрэм босгох, тангараг өргөх үйлэнд муу.

ГАЛ - Зээрд халиун гүү авах, улайн үйл хийх, оршуулганд явах, морь малын арьс үс, улаан өнгийн эд хүнээс авах зэргийг тэвч. Зун, намрын цагт толгой цээж өвдөхөөс болгоомжил. Онгод тахих, бэр, цэргийн үйл, хулгай дээрмийн үйлүүдэд бүү оролц. Галаа тахиулж бай.

ШОРОО - Шар толгойтой хонь авах, модны үйл хийх, газрын үүд хаах, ам авч тангараг тавих, байшингийн суурь тавих, эмгэн хүний малгай, шавар эдлэл авах, газар шороо ухах, хад чулуу булгалах зэрэг үйлүүдийг тэвч. Төмрийн үйл хийхэд сайн. Чимэг зүүх, цас мөс хайлах цагт сэрэмжтэй бай. Оршуулганд явахгүй бол сайн. Дарханы үйл сайн биш.

ТӨМӨР - Бухны мах идэх, төмөр хайлуулах, мод таслах, тангараг тавих, ан амьтан гөрөөлөх, хүүхэд анх хөлд оруулах, хүүр түлэх, хутга мэс авах, чоно нохойд ноцуулсан амьтны мах идэх зэрэг үйлүүдийг цээрлэ. Уушиг, зүрх гэдэсний өвчнөөс сэргийлж, ус хөлдөх үед анхаар. Хулгай дээрэм илрүүлэхэд сайн.

ОГТОРГУЙ - Нохой, цагаан морь авах, их хүнтэй гэрээ хэлэлцээр байгуулах, гэр байшин дээвэрлэх, гөрөөсний мах идэх, шар өнгийн эд авах, өндөрт авирах зэргийг цээрлэ. Толгой гар, хөл өвдөх, сэтгэл тавгүйтэх, нойр муудах болон газар хөлдөх үед болгоомжил. Огторгуйн үүдийг хаалга. Хараал адыг хариулахад сайн. Сүм байгуулах, балгадын суурь тавих, их хэмжээтэй нүүдэл хийхэд сайн биш.

УС - Гахай, загасны мах идэх, худаг малтах, хар зүсмийн мал хийгээд хар өнгийн хуучин эд авах, булаг шанд хөндөх, их гол мөрөн гатлах, тангараг тавих, суваг шуудуу малтах зэрэг үйлүүдийг тэвч. Бурхан сахиусаа тахих, газар лусаа аргад. Бөөр сав, гэдэс өвдөхөөс болгоомжил, зуны эхэн сардаа хянуур бай. Төмрөөр элдэв зүйл хийхэд сайн. Нүүдэл суудал хийхгүй.

УУЛ - Үхрийн худалдаа хийх, хуварга хүнээс таваг аяга авах, тахилын эд авах, газар ус хөндөх, өндөр ууланд авирах, хар малгай өмсөх, ан гөрөө хийх, шороо чулууны үйл зэрэг үйлүүдийг тэвч. Байшингийн суурь тавих, үс унах, яр шарх гарах, бөөр болон шар усны өвчнөөс сэрэмжил. Идээ ундаанаас бузартах болон өвс шарлах газар хөлдөхөд хянуур бай. Адуу, үхэр сургах, гэр бүрэхэд сайн. Худалдаа хийхэд сайн биш.

ХИЙ - Баруун зүгээс мах авах, галзуу хүн, хуварга хүнээс аяга таваг авах, өвчилсөн малын мах идэх, барын арьс авах, хуяг алт эрдэнийн зүйл авах, хэрүүл шуугиан хийх, тарни тоолох, хатуу үйл, согтуу номхотгох, модны зүйл, шар өнгийн эд авах, чимэг, хөгжмийн зэмсэг авах, модон тээрэм босгож байгуулах зэрэг үйлүүдийг

XVII ЖАРНЫ “СОГТУУРУУЛАГЧ” ХЭМЭЭХ МОДОН ХОНЬ ЖИЛИЙН ТАНЫ ТӨӨРӨГ МАХБОДЫН ЗУРХАЙД

Таван махбодын зурхайн үрийг зурсан Монгол зурхайн Түвдэнпэлжээлин хийдийн зурхайч Д.Цолмон

ХУЛГАНА ЖИЛТЭН

Хулгана жилтнүүд хөх бар, мягмар гараг давхцсан өдөр зүүн зүгт хийморийн дарцгаа хийсгэ. 1924, 1948, 1972, 1996 оны огторгуйд, 1936, 1960, 1984, 2008 оны хий суудалд суусан эрэгтэйчүүд Цагаан шүхэрт; 1936, 1960, 1984, 2008 оны шороонд суусан эмэгтэйчүүд Усан балин, Хийморийн сан, сахиус тахиулах. 1924, 1948, 1972, 1996 оны огторгуй суудалд суусан хүмүүсийн хагацахын үүд нээгдсэн тул Дашдондов, Дашзэгвэ, Алтангэрэл уншуулах. Мөн 1924, 1948, 1972, 1996 оны шороон суудалд эмэгтэйчүүдийн үгүйрлийн үүд нээгдсэн тул Дашзэгвэ, Доржнамжом, Алтангэрлийн даллага авахуул. 1936, 1960, 1984, 2008 оны хулгана жилтэй эрэгтэй хий, эмэгтэйчүүд уул суудлын засал хийлгэ.

ҮХЭР ЖИЛТЭН

Үхэр жилтнүүд харагчин гахай, пүрэв гараг давхцсан өдөр хойд зүгт хийморийн дарцгаа хийсгэ. Харш жилийн засалд Жанаггадгог, Барчиднамсэл, Нанжад, Дашзэвэг уншуулах. 1925, 1949,1973, 1997 оны төмөр суудалд эрэгтэй, эмэгтэйчүүд Цагаан шүхэрт; 1913, 1937, 1961, 1985, 2009 оны мод суудалд суусан эрэгтэй, эмэгтэйчүүд Намсрай тахиулж Нанжад уншуул. 1925, 1961, 1997 оныхон мэнгэ голлосоны засал хийлгэ. 1913, 1937, 1961, 1985, 2009 оны мод суудалд, 1925, 1949,1973, 1997 оны төмөр суудалд суусан эрчүүдийн олзны үүд нээгдсэн бататгахын тулд Намсрайн даллага авахуул. 1913, 1937, 1961, 1985, 2009 оны эрэгтэй эмэгтэйчүүд мод; 1925, 1949,1973, 1997 оны эрэгтэй эмэгтэйчүүд төмөр суудлын засал хийлгэ.

БАР ЖИЛТЭН

Бар жилтнүүд цагаан бич, бямба гараг давхцсан өдөр баруун зүгт хийморийн дарцгаа хийсгэ. 1926, 1950, 1974, 1998 оны шороон суудалд суусан хүмүүс бурхан сахиусаа тахиул; мөн дээрх оны огторгуйд суусан эмэгтэйчүүд болон 1914, 1938, 1962, 1986, 2010 оны хийд суусан эмэгтэйчүүд Цэнд, Гурван гүрэм уншуулах. 1926, 1950, 1974, 1998 оны эмэгтэйчүүд суудал өнцөгтсөн тул засал хийлгэ. Бүх бар жилтэй эрэгтэйчүүдийн газрын үүд нээгдсэн тул Саяинямбуу, Нанжид, Лхам уншуулах. 1998 оны бар жилтэн гүмэг, суудлын нашидүрсүм хоёр хавсарсан тул тусгай засалд шамд. Бүх бар жилтэн “жил”-ийн нашидүрсүмийн болон суудлын засалд шамд. 1914, 1938, 1962, 1986, 2010 оны эрэгтэй уул, эмэгтэйчүүд хий; 1926, 1950, 1974, 1998, оны эрэгтэй шороо, эмэгтэйчүүд огторгуй суудлын засал номоо хийлгэж буянд шамд.

ТУУЛАЙ ЖИЛТЭН

Туулай жилтнүүд улаагчин могой, даваа гараг давхцсан өдөр урд зүгт хийморийн дарцгаа хийсгэ. 1915, 1939, 1963, 1987, 2011 оны туулай жилтэй эрэгтэйчүүд Цагаан шүхэрт, эмэгтэйчүүд Бурхан шүтээнээ тахиул. Бүх туулай жилтэй эмэгтэйчүүдийн үгүйрлийн үүд нээгдсэн тул Янбий дончир, Дашзэгвэ, Дашдондов, Норжмаагийн сүн уншуул. Бүх туулай жилтэнгүүд “Жил”-ийн нашидүрсүмийн засал хийлгэ. 1927, 1951, 1975, 1999 оны туулай жилтэй эрэгтэй гал, эмэгтэйчүүд ус; 1915, 1939, 1963, 1987, 2011 оны туулай жилтэй эрэгтэй ус, эмэгтэйчүүд гал суудалд суусан тул тус тусын цээрийг сахиарай.

ЛУУ ЖИЛТЭН

Луу жилтнүүд хөх бар, мягмар гараг давхцсан өдөр зүүн зүгт хийморийн дарцгаа хийсгэ. Огторгуй суудалд суусан 1916, 1940, 1964, 1988, 2012 оны эрэгтэйчүүд болон хий суудалд суусан 1928, 1952, 1976, 2000 оны эрэгтэйчүүд Цагаан шүхэрт уншуул. Шороон суудалд суусан 1916, 1940, 1964, 1988, 2012 оны эмэгтэйчүүд сахиус тахиул. Уул суудал суусан 1928, 1952, 1976, 2000 оны эмэгтэйчүүд Усан балин, Хийморийн сан уншуулж, Намсрай тахиул. Бүх луу жилтэн Шишидийн засал хийлгэ. 1928, 1952, 1976, 2000 оны луу жилтэй эрэгтэй хий, эмэгтэйчүүд ууланд суусан тул Нашидүрсүмийн засал хийлгэ. 1916, 1952, 1988 оны луу жилтний мэнгэ голлосон тул засал хийлгэ. 1916, 1940, 1964, 1988, 2012 оны эрэгтэй огторгуй, эмэгтэйчүүд шороо; 1928, 1952, 1976, 2000 оны хий, эмэгтэйчүүд уул суудлын цээрийг сахиж буян номд шамд.



МОГОЙ ЖИЛТЭН

Могой жилтнүүд харагчин гахай, мягмар гараг давхцсан өдөр хойд зүгт хийморийн дарцгаа хийсгэ. Бүх могой жилтэй эрэгтэйчүүдийн олзын үүд нээгдсэн бататгахын тулд Намсрай тахиул. 1917, 1941, 1965, 1989, 2013 оны эрэгтэй эмэгтэйчүүд Цагаан шүхэрт, 1929, 1953, 1977, 2001 оны эрэгтэй эмэгтэйчүүд Усан балин, Донбуужан, Хийморийн сан уншуул. 1953,1989 оныхон мэнгэний гүмигийн засал хийлгэ. 1917, 1941, 1965, 1989, 2013 оны мөн 1929, 1953, 1977, 2001 оны нэг гэр бүлийн хүмүүс суудал салгуулах засал хийлгээрэй. 1917, 1941, 1965, 1989, 2013 оны эрэгтэй эмэгтэйчүүд төмөр; 1929, 1953, 1977, 2001 оны эрэгтэй эмэгтэйчүүд мод суудлын цээрийг сахиж буян номд шамд.

МОРЬ ЖИЛТЭН

Цагаан мич өдөр бямба гарагт баруун зүгт хийморийн дарцаг хийсгэх. Хийд суусан 1930, 1954, 1978, 2002 оны эмэгтэйчүүд, огторгуйд суусан 1918, 1942, 1966, 1990, 2014 оны эмэгтэйчүүд Цэнд, Гурван гүрэм, ууланд суусан 1930, 1954, 1978, 2002 оны эрэгтэй, шороонд суусан 1918, 1942, 1966, 1990, 2014 оны эрэгтэй хүмүүс бурхан сахиусаа тахиулах. Бүх морь жилтэнгүүд суудал өнцөгдсөн. 1918, 1930, 1942, 1954, 1966, 1978, 1990, 2002, 2014 оны эмэгтэйчүүд гарзын үүд нээгдсэн тул Дашдондов, Дашзэгвэ, Ямбийдончин уншуул. 1918, 1942, 1966, 1990, 2014 оны эрэгтэй шороо, эмэгтэйчүүд огторгуй; 1930, 1954, 1978, 2002 оны эрэгтэй уул, эмэгтэйчүүд хий суудалд суусан тул тус тусын цээрийг сахиж буян номд шамд.



ХОНЬ ЖИЛТЭН

Улаан могой өдөр, могой цагт, Даваа гарагт урьд зүгт хийморийн дарцаг хийсгэнэ. Галд суусан 1919, 1943, 1967, 1991, 2015 оны эрэгтэй, 1931, 1955, 1979, 2003 оны эмэгтэйчүүд бурхан сахиусаа тахиулах. Хонь жилтний жил орж байгаа тул

13 настай – Ламаадан, Нанжид дашзэгвэ
25 настай – Алтангэрлийн даллага, Цэнд, Доржнамжим
37 настай – Жадамба, Жанаггагдог, Цагаан шүхэрт, Лусын сан
49 настай – Сундуй, Дашдондов, Гурван гүрэм
61 настай- Сундуйн жуд, Алтангэрэл, Цагаан шүхэрт
73 настай – Цэвэгмэдийн чого, Цэнд, Жамбалцанжод
85 настай – Манал, Улаан юм
97 настай – Дүншиг, Маанийн гаа бум, Найман гэгээн, Ниваагүнсэл тус тус уншуул. 1919, 1931, 1943, 1955, 1967, 1979, 1991, 2003, 2015 оны эмэгтэйчүүд гарзын үүд нээгдсэн тул Саяннямбуу, Найман гэгээн уншуул. 1943, 1979, 2015 оны хонь жилтэнгүүд мэнгэ голлосон. 1919, 1943, 1967, 1991, 2015 оны эрэгтэй гал, эмэгтэйчүүд ус; 1931, 1955, 1979, 2003 оны эрэгтэй ус, эмэгтэйчүүд галд суусан тул тус тусын суудлын цээрийг сахь.

БИЧ ЖИЛТЭН

Хөх бар өдөр мягмар гарагт зүүн зүгт хийморийн дарцаг хийсгэх. Мич жилтнүүд "Логар" буюу цагаан жилийн засал хийлгэ. Хий суудалд суусан 1920, 1944, 1968, 1992 оны эрэгтэй, огторгуйд суусан 1932, 1956, 1980, 2004 эрэгтэй Цагаан шүхэрт, Уул, Шороонд суусан 1932, 1956, 1980, 2004 оны эмэгтэйчүүд Усан балин, Хийморийн сан, 4 зүгт цагаан Дун үлээх. Бүх мичин жилтнүүд суудал өнцөгдсөн. 1920, 1932, 1944, 1956, 1968, 1980, 1992, 2004 оныхон газрын үүд нээгдсэн тул Саяннямбуу, Найман гэгээн, Лхүмбэнгарав уншуулах. 1944, 1980 оны мич жилтэнгүүд жилийн гүмэг засуулах. 1920, 1944, 1968, 1992 оны эрэгтэй хий, эмэгтэйчүүд уул; 1932, 1956, 1980, 2004 оны эрэгтэй огторгуй, эмэгтэй шороон суудлын цээрийг тус тус сахь.

ТАХИА ЖИЛТЭН

Харагчин гахай өдөр, хойд зүгт хийморийн дарцаг хийсгэнэ. Модон суудалд 1921, 1945, 1969, 1993 оны эрэгтэй эмэгтэйчүүд Усан балин, Хийморийн сан, Намсрайн даллага, төмөрт суусан 1933, 1957, 1981, 2005 оны эрэгтэй эмэгтэйчүүд Цагаан шүхэрт уншуулах. Тахиа жилтэй эрэгтэйчүүд Гончойлхасүм, Сахиусны ганшиг, пэрэнжал уншуул. 1921, 1945, 1969, 1993 оны эрэгтэй эмэгтэйчүүд мод, 1933, 1957, 1981, 2005 оны эрэгтэй эмэгтэйчүүд төмөр суудлын цээрийг сахь. Мөн тахиа жилтэй нэг гэр бүлийн хүмүүс суудал салгах зан үйлийг хийлгэ.

НОХОЙ ЖИЛТЭН

Цагаан бар өдөр мич цагт бямба гарагт баруун зүгт хийморийн дарцаг хийсгэх. Хийд суусан 1922, 1946, 1970, 1994 оны эмэгтэйчүүд, огторгуйд суусан 1922, 1946, 1970, 1994 оны эмэгтэйчүүд Цэнд, Гурван гүрэм уншуул. Уул суудалд суусан 1922, 1946, 1970, 1994 оны эрэгтэй, Шороонд суусан 1934, 1958, 1982, 2006 оны эрэгтэй хүмүүс бурхан, сахиусаа тахиулах. Бүх нохой жилтэнгүүд суудал өнцөгдсөн. Шишидийн засал хийлгэх. 1922, 1934, 1946, 1958, 1970, 1982, 1994, 2006 оны эмэгтэйчүүд хагацлын үүд нээгдсэн тул Доржнамжом, Дашдондог, Алтангэрэл уншуул. 1934, 1970, 2006 оныхон мэнгэ голлосон. 1922, 1946, 1970, 1994 оны нохой жилтэй эрэгтэй, эмэгтэйчүүд Нашдүрсүмийн засалтай. 1922, 1946, 1970, 1994 оны эрэгтэй уул, эмэгтэй хий; 1934, 1958, 1982, 2006 оны эрэгтэй шороо, эмэгтэй огторгуйд суусан тул тус тусын суудлын цээрийг сахь.

ГАХАЙ ЖИЛТЭН

Улаагчин могой өдөр могой цагт даваа гарагт урд зүгт Хийморийн дарцаг хийсгэх. Усанд суусан хүмүүс1923, 1947, 1971, 1995 оны эрэгтэй Цагаан шүхэрт, галд суусан 1935, 1959, 1983, 2007 оны эрэгтэй бурхан сахиусаа тахиулж байх. Ивээл жил гарч байгаа тул ажил бүтэмжтэй. 1935, 1971, 2007 оныхон жилийн гүмэг засуул. 1983 оны гахай жилтэн 33-ны мөчлөгийн засал хийлгэх. 1923, 1947, 1971, 1995 оны эрэгтэй ус, эмэгтэйчүүд гал; 1935, 1959, 1983, 2007 оны гахай жилтэй эрэгтэй гал, эмэгтэйчүүд усанд суусан тул тус тусын суудлын цээрийг сахь.

Өгөөмөр жаргал эдлэх гэвэл
Өр төлөөснөөс ангижиръя гэвэл
Өөрийн суудалд бусдыг зал
Бусдын оронд өөрийгөө зал
гэсэн буддын шашины сургаалыг даган хэвшүүлэхийг хүсье.

XVII ЖАРНЫ "СОГТУУРУУЛАГЧ" ХЭМЭЭХ МОДОН ХОНЬ ЖИЛИЙН ЦАГЛАБАР / 2015-2016 ОН

Хаврын тэргүүн шар бар сар /их/ — **2015 оны II сар**

Билгийн өдөр, гараг		1 R© Бархасвадь	2 Б Сугар	3 ✂ Санчир	4 ✂ Адъяа
Аргын өдөр, гараг		19 Пүрэв	20 Баасан	21 Бямба	22 Ням
Жил өдөр		улаан бар	улаагчин туулай	шар луу	шарагчин могой
Сарын өдөр Дувзий Жэдзий		22 23	23 24	24 25	25 26
Наран од		22	22	22	22
Суудал		төмөр	огторгуй	ус	уул
Мэнгэ		8 цагаан	7 улаан	6 цагаан	5 шар
Барилдлага		үл тохирох	түлэх	идэр	үхэх
Шүтэн барилдлага		хуран үйлдэх	тийн мэдэх	нэр өнгө	төрөн түгэх
Нар ург/шин		7:53-18:20	7:51-18:22	7:50-18:23	7:48-18:25
Сар ург/шин		7:40-18:58	8:15-20:18	8:48-21:36	9:21-22:51

Б-Балжинням, ✂-Үс авах, ©-Лусын буулт, R-Хур ус

Хаврын тэргүүн шар бар сар /их/ — **2015 оны II-III сар**

Билгийн өдөр, гараг	5 ✂ Сумъяа	6 Д ✂ Ангараг	7 © Буд	8 ✂ Бархасвадь	9 © Сугар	10 ✪ ✂ Санчир	11 ✪ © ✂ Адъяа
Аргын өдөр, гараг	23 Даваа	24 Мягмар	25 Лхагва	26 Пүрэв	27 Баасан	28 Бямба	1 Ням
Жил өдөр	цагаан морь	цагаагчин хонь	хар бич	харагчин тахиа	хөх нохой	хөхөгчин гахай	улаан хулгана
Сарын өдөр Дувзий Жэдзий	26 0	0 1	1 2	2 3	3 4	4 5	5 6
Наран од	22	22	23	23	23	23	23
Суудал	мод	хий	гал	шороо	төмөр	огторгуй	ус
Мэнгэ	4 ногоон	3 хөх	2 хар	1 цагаан	9 улаан	8 цагаан	7 улаан
Барилдлага	үл зохилдох	арвидах	үхэх	үл тохирох	үл тохирох	идэр	хүчин төгсөх
Шүтэн барилдлага	хүрэлцэх	сэрэх	хурьцах	авах	сансар	төрөх	өтлөх үхэх
Нар ург/шин	7:46-18:27	7:44-18:28	7:42-18:30	7:40-18:31	7:39-18:33	7:37-18:34	7:35 - 18:36
Сар ург/шин	9:55-	10:31-0:04	11:11-1:13	11:54-2:16	12:42-3:13	13:34-4:04	14:30-4:48

©-Лусын буулт, Д-Дашням, ✂-Үс авах, ✪-Хутганы ир

Хаврын тэргүүн шар бар сар /их/ — **2015 оны III сар**

Билгийн өдөр, гараг	12 Сумъяа	13 ▲ ✂ Ангараг	14 © ✂ Буд	15 ✂ Бархасвадь	16 ♣ Сугар	17 Санчир	18 ♂ Адъяа
Аргын өдөр, гараг	2 Даваа	3 Мягмар	4 Лхагва	5 Пүрэв	6 Баасан	7 Бямба	8 Ням
Жил өдөр	улаагчин үхэр	шар бар	шарагчин туулай	цагаан луу	цагаагчин могой	хар морь	харагчин хонь
Сарын өдөр Дувзий Жэдзий	6 7	7 8	8 9	9 10	10 11	11 12	12 12
Наран од	23	23	23	23	23	23	23
Суудал	уул	мод	хий	гал	шороо	төмөр	огторгуй
Мэнгэ	6 цагаан	5 шар	4 ногоон	3 хөх	2 хар	1 цагаан	9 улаан
Барилдлага	үхэх	үхэх	үхэх	хүчин төгсөх	үл тохирох	үл тохирох	хүчин төгсөх
Шүтэн барилдлага	мунхаг	нэр өнгө	төрөн түгэх	хүрэлцэх	хуран үйлдэх	мунхаг	өтлөх үхэх
Нар ург/шин	7:33-18:37	7:31-18:39	7:29-18:40	7:27-18:42	7:25-18:43	7:23-18:45	7:21-18:46
Сар ург/шин	15:27-5:26	16:26-6:00	17:26-6:30	18:25-6:57	19:25-7:23	20:25-7:48	21:26-8:13

©-Лусын буулт, ▲-Тэрсүүд, ♣-Ичигсэд хөдлөх, ✂-Үс авах, ♂-Бүтээлийн барилдлага

Хаврын тэргүүн шар бар сар /их/ — **2015 оны III сар**

Билгийн өдөр, гараг	19 ✂ Сумъяа	20 Ангараг	21 © Буд	22 ✪ ✂ Бархасвадь	23 ✪ ✂ Сугар	24 Санчир	25 Адъяа
Аргын өдөр, гараг	9 Даваа	10 Мягмар	11 Лхагва	12 Пүрэв	13 Баасан	14 Бямба	15 Ням
Жил өдөр	хөх бич	хөхөгчин тахиа	улаан нохой	улаагчин гахай	шар хулгана	шарагчин үхэр	цагаан бар
Сарын өдөр Дувзий Жэдзий	13 13	14 14	15 15	15 16	16 17	17 18	19 19
Наран од	23	23	24	24	24	24	24
Суудал	ус	уул	мод	хий	гал	шороо	төмөр
Мэнгэ	8 цагаан	7 улаан	6 цагаан	5 шар	4 ногоон	3 хөх	2 хар
Барилдлага	үл зохилдох	хүчин төгсөх	үхэх	үл тохирох	шид	идэр	үхэх
Шүтэн барилдлага	төрөх	сансар	авах	хурьцах	сэрэх	хүрэлцэх	төрөн түгэх
Нар ург/шин	7:19-6:48	7:19-6:49	7:15-6:51	7:13-18:52	7:11-18:54	7:09-18:55	7:07-18:57
Сар ург/шин	22:27-8:40	23:28-9:09	-9:41	0:29-10:19	1:29-11:02	2:26-11:53	3:19-12:52

©-Лусын буулт, ✂-Үс авах, ✪-Хутганы ир

Хаврын тэргүүн шар бар сар /их/-Хаврын дунд шарагчин туулай сар /бага/ — **2015 оны III сар**

Билгийн өдөр, гараг	26 ✂ Сумъяа	27 ✂ Ангараг	28 Буд	29 © Бархасвадь	30 ☼ Сугар	1 ♣ Санчир	2 ▼ © Адъяа
Аргын өдөр, гараг	16 Даваа	17 Мягмар	18 Лхагва	19 Пүрэв	20 Баасан	21 Бямба	22 Ням
Жил өдөр	цагаагчин туулай	хар луу	харагчин могой	хөх морь	хөхөгчин хонь	улаан бич	улаагчин тахиа
Саран од Дүвсий Жэдсий	20 20	21 21	22 22	23 24	24 25	25 26	26 0
Наран од	24	24	24	24	24	24	24
Суудал	огторгуй	ус	уул	мод	хий	гал	шороо
Мэнгэ	1 цагаан	9 улаан	8 цагаан	7 улаан	6 цагаан	5 шар	4 ногоон
Барилдлага	идэр	түлэх	рашаан	хүчин төгсөх	идэр	идэр	хүчин төгсөх
Шүтэн барилдлага	нэр өнгө	тийн мэдэх	өтлөх үхэх	төрөх	сансар	тийн мэдэх	нэр өнгө
Нар ург/шин	7:05-18:58	7:03-19:00	7:01-19:01	6:59-19:03	6:57-19:04	6:55-19:06	6:53-19:07
Сар ург/шин	4:08-13:59	4:52-15:11	5:31-16:27	6:07-17:46	6:42-19:05	7:15-20:23	7:50-21:40

©-Лусын буулт, ▼-Модон хохимой, ♣-хаврын тэнцэл, ✂-Үс авах , ☼-Нар хиртэнэ

Хаврын дунд шарагчин туулай сар /бага/ — **2015 оны III сар**

Билгийн өдөр, гараг	3 Д © ✂ Сумъяа	4 ✪ ✂ Ангараг	6 ✪ ✂ Буд	7 Бархасвадь	8 Б © ✂ Сугар	9 Санчир	10 Адъяа
Аргын өдөр, гараг	23 Даваа	24 Мягмар	25 Лхагва	26 Пүрэв	27 Баасан	28 Бямба	29 Ням
Жил өдөр	шар нохой	шарагчин гахай	цагаан хулгана	цагаагчин үхэр	хар бар	харагчин туулай	хөх луу
Саран од Дүвсий Жэдсий	0 1	1 2	2 3	3 4	4 5	5 6	6 7
Наран од	24	25	25	25	25	25	25
Суудал	төмөр	огторгуй	ус	уул	мод	хий	гал
Мэнгэ	3 хөх	2 хар	1 цагаан	9 улаан	8 цагаан	7 улаан	6 цагаан
Барилдлага	үхэх	арвидах	идэр	хотол чуулган	идэр	үл тохирох	арвидах
Шүтэн барилдлага	төрөн түгэх	хүрэлцэх	сэрэх	хурьцах	авах	сансар	төрөх
Нар ург/шин	6:51-19:09	6:49-19:10	6:47-19:11	6:45-19:13	6:43-19:14	6:41-19:16	6:39-19:17
Сар ург/шин	8:26-22:53	9:05-	9:49-0:01	10:37-1:03	11:28-1:58	12:23-2:45	13:21-3:26

Б-Балжинням, Д-Дашням, ©-Лусын буулт, ✂-Үс авах, ✪-Хутганы ир

Хаврын дунд шарагчин туулай сар /бага/ — **2015 оны III-IV сар**

Билгийн өдөр, гараг	10 © ✂ Сумъяа	11 ▲ ✂ Ангараг	12 Буд	13 ✂ Бархасвадь	14 ✂ Сугар	15 * ✂ Санчир	16 ✪ © ♥ Адъяа
Аргын өдөр, гараг	30 Даваа	31 Мягмар	1 Лхагва	2 Пүрэв	3 Баасан	4 Бямба	5 Ням
Жил өдөр	хөхөгчин могой	улаан морь	улаагчин хонь	шар бич	шарагчин тахиа	цагаан нохой	цагаагчин гахай
Саран од Дүвсий Жэдсий	7 8	8 9	9 9	10 10	11 11	11 12	12 13
Наран од	25	25	25	25	25	25	25
Даваа - (сар) гараг нь (усан орон, усан махбодьтой) бөгөөд эм хүний сүлд гариг болно. Хишиг даллага авах, эм найруулах, лус ба тэнгэр тахих, хөрөнгө эсгэх, архи нэрэх, сүм хийд босгох, бэр авах, хурим хийх, тариа тарих, гэр байшин барих, сан тавих, зам мөр гаргах, хот байгуулахад сайн гэж үздэг ажээ. Харин эхэлж ном сонгох, замд хол явах, шинэ дээл өмсөх, эд юм өгөх, өмнө зүгт явахад зүгээр, бусад зүгт анхааралтай явах ёстой гэнэ.

Мягмар - (ангараг) гараг нь (галын орон, гал махбодьтой) Эр цэргийн сүлд гариг болно. Дайнд ялах, дайсан дарах, номхотгох, цэргийн ба догшин үйл хэрэг, худалдаа хийх, балгас эвдэх, шинэ ноён тавих, захиран тушаах ажилд сайн гэж үздэг аж. Энэ гаригт эм найруулах, замд гарах, бэрийн үйл нугуудыг тэвчих, үхэгсдийн үйл үйлдэхийг хориглоно. Эр хүн хэрэг чирэгдэлд холбогдохоос болгоомжилж явах ёстой. Хүн мал амгалангүй тул хичээнгүй сэрэмжлэх хэрэгтэй гэжээ.

Лхагва - (буд) гараг нь (усан махбодьтой) ялгуугсадын сүлд гариг, эд юм бүтээх, бичиг зурхай зурах, ураг садан болох, худалдаа хийх, сүмийн тахил, тахилга засах, өөрийн амьдралд тустай ажил хийхэд сайн гэж үздэг аж. Хатуу үйл ажил хийх, лам болох, ном сонсох, гадагш өгөх, хөрөнгө эсгэх, үр цацах зэргийг муу гэдэг.

Пүрэв - (Бархасбадь) гараг нь (хий махбодьтой) Лам хүний сүлд гариг. Сургуульд орох, бичиг зурхай, эрдэм сурах, ном сонсох, номлох, хэвлэх, замд явах, санваар өгөх, шүтээн босгох, номын хурал байгуулах, эм найруулах, мод тарих, хөрөнгө эсгэх, бэр авах, төрөх, буяны үйлс бүхэнд сайн гэж үздэг ажээ.

Баасан - (сугар) гараг нь (шороон махбодьтой) Ноёд хаадын сүлд гариг болно. Лам болох, эм найруулах, хурим хийх, замд гарах, эрдэм сурах, шинэ хувцас өмсөх, бэр авах, бэрийн үйл бүхэнд өлзийтэй сайн. Үхэгсдийн явдалд сайн, ном сонсоход дунд, эд хөрөнгө зээлдүүлэх, нэхэх, нүүдэл хийх зэрэгт муу гэж үздэг.

Бямба - (санчир) гараг нь (шороон махбодьтой) Нялхсын сүлд гариг. Насан буян бүтээх, эд мал авах, худаг гаргах, тариа тарих, мод суулгах, хот байшин барихад сайн ажээ. Бусад үйлийг тэвч. Бэр, хүргэн авч болохгүй.

Онцгойлон үзэх нь:

Ням гарагт:	Тэнгэрийн үйл дэлгэрдэг ч шидийг бүү хий.
Даваа гарагт:	Лусын үйл дэлгэрдэг ч балин бүү гарга
Мягмар гарагт:	Түшмэл, хутганы ир дэлгэрдэг ч хутга бүү хурцал.
Лхагва гарагт:	Үр таслах дэлгэрдэг ч үхэгсдийг бүү тавь.
Пүрэв гарагт:	Модон гариг дэлгэрдэг ч сор бүү гарга.
Баасан гарагт:	Мал адгуус дэлгэрдэг ч мал бүү гарга.
Бямба гарагт:	Газрын гариг дэлгэрдэг ч эд бүү гарга.

АРВАН ХОЁР ӨДРИЙН ҮР

1. Бар өдөр: Хот тосгоны суурь тавих, бурхан шүтээн, орон гэрийг аравнайлах, бэр буулгах, хувцас эсгэх, тооцоо хийх, мэргэ төлөг тавих, цэрэг хөдөлгөх зэрэгт сайн. Муу нь: Эм найруулах, төрөл садан бололцох, ном эхлэн заалгахад харш.

2. Туулай өдөр: Ном заалгах, бурханд залбирах, ихэс дээдэст бараалхах, үхэр хонь зэрэг малтай холбогдох үйл бүхэнд сайн. Муу нь: Хот суурин, байшин барилга эхлэн барих, төрөл садан болох, газар хагалах, суваг шуудуу малтах, хурим хийх, цэрэг хөдөлгөх, тариа ногооны үр суулгах, нүүдэл хийх зэрэгт тохиромжгүй.

3. Луу өдөр: Ном айлтгаж, заалгах, дээдэст бараалхах, буян үйл хийх, зэтгэрийг номхотгох, шүтээн босгох, эм найруулах, тооцоо хийх, мэргэ төлөг тавих зэрэгт сайн. Муу нь: Онгоц, сал, модон тээрэм урлах, гүүр барих, хануур, төөнүүр хийлгэх, газар малтах зэрэгт харш.

4. Могой өдөр: Мал гадагш гаргах, газар лусын зан үйл, тахил хийх, нүүдэл хийх, цэрэг хөдөлгөх, зээл авахад сайн. Муу нь: Мод таслах, эм найруулах, үхэгсдийн үйл, усыг хааж бөглөх, бэр өгөх, худалдаа хийх, заргалдах, замд явах, нүүдэл суудал хийх зэрэгт зохимжгүй.

5. Морь өдөр: Нууц зөвлөгөөн хийх, бурханд залбирах, нөхрийг эрэх, (нөхөртэй болох), хаад ноёд, ихэс дээдэст тангараг, амлалт гаргах зэрэгт сайн. Муу нь: Байшин сууц тохижуулах, морь худалдах зэрэгт муу.

6. Хонь өдөр: Бурханд залбирах, хониноос ашиг шим авах, хот тосгон барьж эхлэх, мал гадагш өгөх, ажилчин авах, хурим найр хийх үйлд эрэг сайн. Муу нь: Хануур, төөнүүр хийлгэх, эм найруулах, анагаах үйл хийх, цэрэг хөдөлгөх зэрэгт харш.

7. Бич өдөр: Бэр авах, мод суулгах, цэцэрлэг байгуулах, чимэг зүүх, бүжиг наадам хийх, туг дарцаг хийсгэх зэрэгт сайн. Муу нь: Шинэ хувцас өмсөх, эсгэх, чимэг оёх, худалдаа хийх зэрэгт харш муу.

8. Тахиа өдөр: Мэргэ төлөг тавих, эм найруулахад сайн. Муу нь: Мал агтлах, нууц зөвлөгөөн хийх, хурим найр хийх зэрэгт муу.

9. Нохой өдөр: Хөлсний ажилчин авах, урлах үйлд суралцах, чуулган хийх, ном заалгах, бурханд залбирах, ан гөрөө хийх үйлд сайн. Муу нь: Бэрд холбогдох үйл, ашиг тустай үйл, нүүдэл хийх, хэрүүл зэрэгт муу.

10. Гахай өдөр: Номын хурим, лам хуварга болох, ном заалгах, гөлөг тэжээхэд сайн. Муу нь: Үхэгсдийг оршуулах, мод таслах, худаг шуудуу малтах зэрэгт муу.

11. Хулгана өдөр: Шинэ барилгыг ашиглалтад оруулах, худалдаа наймаа хийх, гэрлэх, тус хэрэгтэй үйлийг бүтээхэд сайн. Муу нь: Төлөг тавих, морь уралдуулах, нохой тэжээх, хүүхэд үрчлэн авахад харш.

12. Үхэр өдөр: Мал зарах, худалдаа хийх, хот суурин, байшин барилгын суурь тавих зэрэг үйлд сайн. Муу нь: Урлан бүтээх, дархлах, эрдэм ухаанд суралцах, цэрэг хөдөлгөхөд сөрөг муу нөлөөтэй.

Дээрхи 12 өдрийн бар, бич өдрүүдэд худаг малтахыг, тахиа, туулай өдрүүдэд үзмэр үзэх, хурим хийхийг, нохой, луу өдрүүдэд мордохыг, гахай, могой өдрүүдэд мод таслах, газар малтахыг, хулгана морь өдрүүдэд морь уралдуулах, улаан идээ авахыг, үхэр, хонь өдөрт өндөр суудалд сууж эхлэх, туг дарцаг хийсгэхийг цэцэрлэвэл зохино.

ЗАРИМ ӨДРИЙН ҮРИЙН ТУХАЙ

1. Балжинням, Дашнямтай өдөр гэдэг нь өлзий хутгийн наран ба цогийн наран ургахуй хэмээх хоёр өдөр бөгөөд ном уншуулах, буян үйлдэх, хишиг даллага авах, гэр байшин барих, бэр буулгах, хуварга тойн болох, эд мал авах зэрэгт ивээлтэй. Алив нэгэн ажил үйлс эхлэн, үйлдэхэд, тэр хүний санасан зүйлс бүтээд үр ач нар дэлгэрэн буян хишиг нэмэх нэн сайн болно.

2. Хутганы ир хэмээх өдөр – Зүү тавих, хануур, төөнүүр, мэс засал хийх зэрэг аливаа хутга мэсийн ажлыг цээрлэдэг ажээ.

3.Модон хохимой өдөр – Ураг садан бололцох, бэр авах, өгөх, нөгчигсдийн үйл, буян хишиг дуудах, аян замд гарах, бурхан тэнгэр тахих, хуварга тойн болох зэрэг буяны үйл, мөн нүүж нутаг сэлгэх зэргийг цээрлэн тэвчдэг ажээ.

Тэрсүү өдөр - Тэрсүү өдөр үйл бүхнийг хоригловол тус ихтэй гэжээ. Монголын Цагаан сарын шинийн нэгнээс эхлэн хаврын тэргүүн буюу бар сар эхлэх бөгөөд түүнээс дэс дарааллан 12 сард харгалзсан тодорхой өдрүүдийг "тэрсүү өдөр" гэж нэрлэнэ. Энэ өдөр аливаа үйл үйлдвэл үр нь муу гэж үздэг. Шинэ гэр баривал салж хагацах аюултай. Бэр буулгавал эхнэр нөхрөөс салах гэмтэй. Сүм дуган баривал лам хуварга үл тогтох, замд гарвал хулгай дээрэмчинтэй учрах, үр тариа таривал хатах, нэр алдар авбал доройтох, хишиг даллага авах сүлд дуудбал үл илрэх.

САРЫН ОНЦГОЙ ӨДРҮҮДИЙГ ОЛОХ НЬ

Сарын нэр	Бар	Туулай	Луу	Могой	Морь	Хонь	Бич	Тахиа	Нохой	Гахай	Хулгана	Үхэр
Балжинням	2	8	10	3	3	29	3	17	3	16	1	9
Дашням	2,6	3,8	1,10	3,9	3,4	5,19	3,18	17,24	3	1,11	1,27	10,19
Модон хохимой	1	2	3	4	5	6	7	8	9	10	1,16	29
Тэрсүүд	13	11	9	7	5	3	1	19	17	25	23	21

ӨДРИЙН СУУДЛЫН ҮР

Нэр	Сайн үр	Муу үр
Гал	Төмрийн үйл хийх, зүүлт чимэг зүүх, бурханд залбирах, буяны үйл	Эвлүүлэх, нийцүүлэх, бэрийн болон улайн үйл хийгээд үхэгсдийн үйл.
Шороо	Газрын үүд боох, мод хатгах, зүүн тийш явах, тангараг няцаах, саад тотгор дарах	Байшингийн суурь тавих, үхэгсэд оршуулах, угаал, залбирал талбих.
Төмөр	Мод таслах, зүүн зүгт одох, тангараг няцах, хаах, гөрөөлөх	Хүүхэд хөлд оруулах, хүүхдийг гадагш явуулах.
Огторгуй	Огторгуйн үүд сахих, гүрэм засал хийлгэх, их хүмүүнтэй уулзах, буяны үйл	Өвчин эмнэж эхлэх, сүм дугана, балгадын суурь тавих, гэр бүрэх, нүүдэл, худалдаа хийх.
Ус	Бурхан лусыг тахих, зод барих, хариулга хийх, төмөр урлах үйл.	Их гол гатлах, бэрх газар номхотгох, загас барих, тангараг үүсгэх, гуу суваг татах, дайсан номхотгох.
Уул	Бурханыг сахих, номын үүдэнд орох, Очирпүрэвийн хариулга, морь, үхэр номхотгох, байшингийн суурь тавих, гэр бүрэх	Их хэрэг үүсгэх, ном унших, худалдаа наймаа.
Мод	Бурхан, тэнгэр тахих, чимэг зүүлт зүүх, мод тарих, шав тавих.	Мод таслах, тангараг тавих
Салхи	Тарни тоолох, хариулга хийх, согтуу галзуу номхотгох хатуу үйлд сайн.	Тээрэм босгох, андгай тавих, цуглаж чуулах.

ӨДӨР ТУС БҮРТ САРАН ХЭРЖ БУЙ 27 ОДНЫ ТҮВД, МОНГОЛ, САНСКРИТ НЭР

	Монгол	Түвд	Санскрит
1	Гоё хүүхэн	Брани	Барани
2	6 эхтэй хүү	Миндуг	Гирдиг
3	Чөлөөт эх	Нарма	Ровагини
4	Гөрөөсөн толгой	Го	Мэргэшир
5	Хэрцгий охин	Лаг	Артир
6	Өглөгт охин	Навсо	Бүрнавасан
7	Найралт эх	Жал	Бүс
8	Үнэг	Гаг	Аслис
9	Их морь	Чү	Мэг
10	Бар морь	Дэ	Бурбабэлгүни
11	Харцага	Бо	Удирабэлгүни
12	Түүхчин	Мэши	Хасда
13	Тэргүүн дагуул	Навга	Цэдэр
14	Салхины эх	Сари	Сувади
15	Эрхтний тэнгэр	Сага	Шошаг
16	Гар од	Лхамцам	Анурад
17	Хонгорцог	Нрон	Цэста
18	Онгоц	Нрув	Мол
19	Суулга	Чудод	Бурбасад
20	Элдэв тэнгэртэн	Чумад	Удирасад
21	Яруу эгшигт	Дошин	Абизи
22	Булаагч	Жишин	Ширван
23	Тооно	Мондэ	Даниста
24	Чөдөр	Монду	Садабис
25	Шувуун хошуут	Түмдод	Бурвабадрабад
26	Могойг хуулэгч	Түммад	Удирабадрабад
27	Дэлгэрүүлэгч	Намдуу	Ривади
28	Шийдэм	Тагар	Ашувани

ӨДРИЙН МЭНГЭНИЙ ҮР

Мэнгэ	Билэг дэмбэрэл	Сайн талууд	Анхаарах зүйл
1 цагаан	Эхийн цагаан сүү шиг ариун	Угаал үйлдэх бурхан луст залбирах, тахил үйлд сайн.	Нялхсыг хөлд оруулах, гадагш явуулахад муу
2 хар	Арга билэг төгөлдөр	Шулмас хийгээд хараалыг буцаах хариулахад сайн.	Бурхан тахих, бэрийн үйл нугуудад муу.
3 хөх	Бие хэл, сэтгэл гурваар ариун	"Чав дор" "Усан балин" лүүдор "лусын балин" өргөх, эм залах, лус тахихад сайн.	Газар хөндөх, хариулга хийх, мод таслах, суваг.
4 ногоон	Ухаан билгүүн төгөлдөр	Эм найруулах, 8 лусыг тахих хийгээд тахил өглөг өгөх бурханд залбирах, хануур үйлдэхэд сайн.	Бэлэвсний газар очих, эхнэрийн үс хайчлах, нялхасыг гаргахыг тэвч.
5 шар	Таван эрдмээр тэгш сайн	Хаанд айлтгал өгөх, сүмийг сэргээх, аравнайлах, оршуулах, тойн болох, ном номлоход сайн.	Газар хагалах, хурим хийх, нохой авах, наймаанд муу.
6 цагаан	Чанадын зургаа (өглөгч, хууль зүйч, хичээнгүй, тэвчээр хатуужилтай, мохошгүй сайхан сэтгэлт, оюун ухаант)	Бурханд залбирах, хишиг даллага авахуулах, угаал үйлдэх, бэр авах, нүүдэлд сайн.	Бузар буртгийг харж, дайсагнах үйлийг тэвч.
7 улаан	Гал шиг дээш хандаж өөдрөг халуун сэтгэлтэй	Бурхан нугуудад залбирах сайн.	Улаан үйл, хиншүү хярвасанд муу.
8 цагаан	Сэтгэл нь ямагт ариун онгон	Бурханд залбирал үйлдэх сан тавиулах, Хангал тахиулах, бэрийн үйл, сахиусанд өглөг өгөхөд сайн.	Хиншүү хярвас, бузар бэлэвсний үйл нугуудад муу.
9 улаан	Нар мэт энх амгалан	Сайн бүтээл, хишиг даллага авахуулах, чангас өгөхөд сайн.	

ӨДРИЙН АРВАН УЧРАЛЫН ҮР

"Шид", "хотол чуулган", "рашаан", "хучин төгсөх", "арвидах", "идэр"-ийн учралыг "зургаан сайн", "үхэх", "түлэх", "үл тохирох", "үл зохицох"-ыг "өдрийн муу" хэмээдэг.

1. Шидийн учралтай өдөр – Аливаа санасан үйл сэтгэлчлэн бүтмүй. Шүтээн босгох, хот балгад барих, тариа тарих, худалдаа наймаа хийх зэрэг дэлгэрүүлэх үйлд хичээвэл сайн. Бүтээл туурвил үйлдэх зэрэг батжуулах үйлд ч сайн.

2. Рашааны учралтай өдөр – Насны хучийг арвижуулах, эм найруулах, усан засал, угаал үйлдэх, бэр авах, насны хишиг, насан бүтээлийн зан үйлийг хийлгэх, төрөл садан бололцох, худалдаа наймаа үүсгэх зэрэг дэлгэрүүлэх үйлсэд сайн.

3. Идрийн учралтай өдөр – Сайн үйлс үүсгэх, баясгалангийн хурим үйлдэх, ялангуяа гэр бүл бололцох, газар хагалж тариа тарих, шинээр хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үйлдэх зэрэгт сайн.

4. Арвидах учралтай өдөр – Идээ, хувцас олох, худалдаа наймаа үйлдэх, өглөг өгөх, хөрөнгө талбих, эдийн тэнгэр тахих хийгээд бүтээл үүсгэхэд сайн.

5. Хотол чуулганы учралтай өдөр – Санасан хэрэг бүтнэ. Хэл ам намдаах, арга эвийг олж түргэн бүтээх үйлсэд сайн.

6. Хучин төгсөхийн учралтай өдөр - Өлзийтэй буян үйл үйлдэх, номын үйл эхлэх, гүйцээх, сүм дуган нээх, амирлангуй, дэлгэрэнгүй эрхшээх үйл бүхэнд сайн.

7. Түлэхийн учралтай өдөр – Элдэв сайн үйлийг эхлэн үүсгэхийг тэвчвэл сайн. Хатуу үйл үүсгэвэл зохилтой.

8. Үл тохирохын учралтай өдөр – Хулгай, дээрэм дарах, дайсныг номхотгох үйлд сайн. Амраг садан бололцох, багш шавь барилдахыг тэвч.

9. Үхэхийн учралтай өдөр – Мал адгуус муулах үйлд сайн.

10. Үл зохилдохын учралтай өдөр – Андгай тангаргаас няцах, дайсныг номхруулах үйлд сайн.

ХҮН БҮРИЙН СҮЛД, ҮХЛИЙН ГАРИГ, ОДНЫ ХҮСНЭГТ

Төрсөн жил	Ивээл жил	Харш жил	Сүлд гариг	Амь гариг	Үхэх гариг	Сүлд од	Амь од	Үхэх од
Хулгана	Луу Бич	Морь Туулай	Лхагва	Мягмар	Бямба	19	5	22
Үхэр	Могой Тахиа	Хонь Луу	Бямба	Лхагва	Пүрэв	16	13	4
Бар	Морь Нохой	Бич Могой	Пүрэв	Бямба	Баасан	4	26	1
Туулай	Хонь Гахай	Тахиа Морь	Пүрэв	Бямба	Баасан	10	26	17
Луу	Бич Хулгана	Нохой Хонь	Ням	Лхагва	Пүрэв	2	23	10
Могой	Тахиа Үхэр	Гахай Бич	Мягмар	Баасан	Лхагва	12	11	5
Морь	Нохой Бар	Хулгана Тахиа	Мягмар	Баасан	Лхагва	16	11	26
Хонь	Гахай Туулай	Үхэр Нохой	Баасан	Даваа	Пүрэв	7	0	26
Бич	Хулгана Луу	Бар Гахай	Баасан	Пүрэв	Мягмар	7	0	16
Тахиа	Үхэр Могой	Туулай Хулгана	Баасан	Пүрэв	Мягмар	13	6	23
Нохой	Бар Морь	Луу Үхэр	Даваа	Лхагва	Пүрэв	8	26	11
Гахай	Туулай Хонь	Могой Бар	Лхагва	Мягмар	Бямба	1	7	11

ЦАГИЙН САЙН МУУГИЙН ЯЛГАА

Зурхайд жил, сар, өдөр, цагийг арван хоёр амьтнаар нэрлэх агаад хуучин Монгол тоололд нэгэн хоногийг арван хоёр цагт хуваана. Үүнд:

00 цаг – 02 цаг Хулгана цаг	02 цаг – 04 цаг Үхэр цаг	04 цаг – 06 цаг Бар цаг
06 цаг – 08 цаг Туулай цаг	08 цаг – 10 цаг Луу цаг	10 цаг – 12 цаг Могой цаг
12 цаг – 14 цаг Морь цаг	14 цаг – 16 цаг Хонь цаг	16 цаг – 18 цаг Бич цаг
18 цаг – 20 цаг Тахиа цаг	20 цаг – 22 цаг Нохой цаг	22 цаг – 24 цаг Гахай цаг

Морь, хулгана өдрийн хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа цаг
Хонь, үхэр өдрийн бар, туулай, могой, бич, нохой, гахай цаг
Бич, бар өдрийн луу, могой, хонь, нохой, хулгана, үхэр цаг
Тахиа, туулай өдрийн морь, хонь, тахиа, хулгана, бар, туулай цаг
Нохой, луу өдрийн могой, бич, тахиа, гахай, бар, луу цаг
Гахай, могой өдрийн морь, хонь, нохой, гахай, үхэр, луу цаг тус тус сайн болно. Эдгээр цагуудад элдэв үйлийг хийхэд эрхэм сайн агаад чингэхүл од, гариг, газрын эзэд хийгээд үйлчлэн, мэнгэ, хөлөлийн элдэв тотгорт үл автагдана хэмээн зурхайн ном зохиолд заажээ.

ЛУСЫН БУУЛТ

Бар сарын 1, 7, 9, 11, 14, 21, 29; Туулай сарын 2, 3, 8, 10, 16, 18; Луу сарын 25; Могой сарын 5, 8, 9, 10, 15, 21, 23, 28; Морь сарын 5, 10, 14, 19, 20-24, 28, 29, 30; Хонь сарын 9, 15, 19, 20, 23, 25, 26, 28, 30; Бич сарын 1, 9, 15, 17, 19, 20, 23, 25, 27; Тахиа сарын 5, 8, 10, 15, 17, 18, 23, 25, 29; Нохой сарын 1, 11, 14, 16, 20-23, 29; Гахай сарын 1-6, 8, 13-17, 25, 28, 29, 30; Хулгана сарын 7, 9, 11, 15, 21, 27; Үхэр сард лус ичнэ.

МАЛЫН ҮС НООС ХЯРГАХ ӨДӨР

Шин-ийн		Хууч-дын	
1	хулгай, дээрэм хийгээд чоно араатан учрах муу	16	өнгө зүс төгөлдөр
2	буян хишиг зайлах муу	17	нийтэд муу
3	буян хишиг дэлгэрэх сайн	18	амгалан жаргалан болно
4	өнгө зүс сайжирч, тамир тэнхээ нэмэгдэнэ	19	малд үхэл гарз ирнэ
5	малын ур төл арвидна.	20	ур төл арвижина
6	тамир хүч нь доройтно	21	өвчин эмгэг тусна
7	зарга залхай гарна	22	машид сайн
8	сэтэртэйг бүү хярга	23	амгалан сайн
9	өвчин эмгэг тусна	24	урхаг өвчин гарна
10	бурхан сахиус машид баясна	25	буян хишиг дэлгэрнэ
11	нэгэнд дунд зэрэг	26	шим хүч төгөлдөр
12	малын ур төлд харш	27	сүргийн манлайд харшлах муу
13	ур төл арвидан дэлгэрэх сайн	28	буян хишиг зайлна
14	нийтээр төгс сайн	29	сүргийн манлайд муу
15	эзэн хүнд сайн	30	машид муу

Хонь малын үс нооc хяргахад сар бүрийн 3, 4, 5, 10, 13, 14, 15, 16, 18, 20, 22, 23, 25, 26-ны өдрүүд сайн, үлдсэн өдрүүд нь муу байна.

XVII ЖАРНЫ "СОГТУУРУУЛАГЧ" ХЭМЭЭХ МОДОН ХОНЬ ЖИЛИЙН ТАНЫ ТӨӨРӨГ

Чулууны шинжлэлийг тооцсон Уугаа овогт С.Даваабаяр

Төөргийн чулууны үр, түүний арга засал (1-100 насныхан)

Төрсөн он	1913		1914		1915		1916		1917		1918		1919		1920		1921		1922	
Билгийн нас	103		102		101		100		99		98		97		96		95		94	
Төрсөн жил	Харагчин үхэр		Хөх бар		Хөхөгчин туулай		Улаан луу		Улаагчин могой		Шар морь		Шарагчин хонь		Цагаан бич		Цагаагчин тахиа		Хар нохой	
Төрсөн мэнгэ	6		5		4		3		2		1		9		8		7		6	
Буусан мэнгэ	1		8		2		3		5		5		1		1		4		2	
Хүйс	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм
Суудал	мод	мод	уул	хий	ус	гал	огторгуй	шороо	төмөр	төмөр	шороо	огторгуй	гал	ус	хий	уул	мод	мод	уул	хий
Амь	ООО	О	ОО	Х	О	ООО	О	ОХ	ХХ	О	ООО	ОО	ООО	О	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	ООО
Бие	ООО	ООО	ООО	ООО	Х	О	ОХ	ОО	ХХ	ХХ	ХХ	ХХ	ХХ	ХХ	ООО	О	ООО	ООО	ООО	ООО
Эрхтэн	ООО	ООО	ОХ	ООО	ХХ	ХХ	ОХ	ООО	Х	ХХ	ООО	ОО	О	ХХ	ООО	ООО	ООО	О	ООО	ООО
Хийморь	ХХ	ХХ	ООО	Х	ООО	ООО	ОО	ОО	ХХ	ХХ	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	ООО	ХХ	ХХ	ХХ	ХХ
Сүлд	Х	О	ОО	Х	ХХ	ХХ	ООО	ООО	ОХ	ООО	ХХ	ХХ	О	ОХ	ХХ	ХХ	ХХ	О	ООО	ООО
Урвасан жил	гал туулай	шороо гахай	гал гахай	төмөр хонь	гал тахиа	ус хонь	гал гахай	мод туулай	гал туулай	гал үхэр	гал могой	шороо үхэр	гал тахиа	төмөр могой	гал гахай	ус гахай	гал тахиа	мод тахиа	гал могой	гал тахиа

Төрсөн он	1923		1924		1925		1926		1927		1928		1929		1930		1931		1932	
Билгийн нас	93		92		91		90		89		88		87		86		85		84	
Төрсөн жил	Харагчин гахай		Хөх хулгана		Хөхөгчин үхэр		Улаан бар		Улаагчин туулай		Шар луу		Шарагчин могой		Цагаан морь		Цагаагчин хонь		Хар бич	
Төрсөн мэнгэ	5		4		3		2		1		9		8		7		6		5	
Буусан мэнгэ	4		2		3		1		6		6		1		8		1		8	
Хүйс	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм
Суудал	ус	гал	огторгуй	шороо	төмөр	төмөр	шороо	огторгуй	гал	ус	хий	уул	мод	мод	уул	хий	ус	гал	огторгуй	шороо
Амь	ООО	О	ОО	Х	О	ООО	О	ОХ	ХХ	О	ООО	ОО	ООО	О	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	ООО
Бие	ООО	ООО	ООО	ООО	Х	О	ОХ	ОО	ХХ	ХХ	ХХ	ХХ	ХХ	ХХ	ООО	О	ООО	ООО	ООО	ООО
Эрхтэн	ООО	ООО	ОХ	ООО	ХХ	ХХ	ОХ	ООО	Х	ХХ	ООО	ОО	О	ХХ	ООО	ООО	ООО	О	ООО	ООО
Хийморь	ХХ	ХХ	ООО	Х	ООО	ООО	ОО	ОО	ХХ	ХХ	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	ООО	ХХ	ХХ	ХХ	ХХ
Сүлд	Х	О	ОО	Х	ХХ	ХХ	ООО	ООО	ОХ	ООО	ХХ	ХХ	О	ОХ	ХХ	ХХ	ХХ	О	ООО	ООО
Урвасан жил	гал гахай	шороо үхэр	гал тахиа	төмөр үхэр	гал туулай	ус гахай	гал гахай	мод хонь	гал тахиа	гал хонь	гал гахай	шороо туулай	гал туулай	төмөр үхэр	гал могой	ус үхэр	гал тахиа	мод могой	гал гахай	гал гахай

Төөргийн чулууны үр, түүний арга засал (1-100 насныхан)

Төрсөн он	1933		1934		1935		1936		1937		1938		1939		1940		1941		1942	
Билгийн нас	83		82		81		80		79		78		77		76		75		74	
Төрсөн жил	Харагчин тахиа		Хөх нохой		Хөхөгчин гахай		Улаан хулгана		Улаагчин үхэр		Шар бар		Шарагчин туулай		Цагаан луу		Цагаагчин могой		Хар морь	
Төрсөн мэнгэ	4		3		2		1		9		8		7		6		5		4	
Буусан мэнгэ	2		3		5		5		1		1		4		2		4		2	
Хүйс	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм
Суудал	төмөр	төмөр	шороо	огторгуй	гал	ус	хий	уул	мод	мод	уул	хий	ус	гал	огторгуй	шороо	төмөр	төмөр	шороо	огторгуй
Амь	ООО	ООО	ООО	ООО	ООО	ХХ	ХХ	ХХ	Х	ООО	О	ОХ	ХХ	ОХ	ООО	ООО	ООО	О	ХХ	ХХ
Бие	ОХ	ООО	ХХ	Х	ХХ	Х	Х	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ОО	ООО	О	ОО
Эрхтэн	ООО	ООО	ОХ	ХХ	ХХ	ООО	ООО	ОО	ООО	ООО	ООО	ОО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО
Хийморь	ООО	ООО	ООО	ООО	ХХ	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	ОО	ОО	ХХ	ХХ	О	О	ООО	ООО	ООО	ООО
Сүлд	ООО	ООО	Х	ХХ	ООО	ОХ	ОХ	ХХ	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	ООО	ХХ	ХХ	О	ХХ	ХХ	ХХ
Урвасан жил	гал тахиа	шороо тахиа	гал могой	төмөр тахиа	гал гахай	ус үхэр	гал тахиа	мод үхэр	гал туулай	гал гахай	гал гахай	шороо хонь	гал тахиа	төмөр хонь	гал гахай	ус туулай	гал туулай	мод үхэр	гал могой	гал үхэр

Төрсөн он	1943		1944		1945		1946		1947		1948		1949		1950		1951		1952	
Билгийн нас	73		72		71		70		69		68		67		66		65		64	
Төрсөн жил	Харагчин хонь		Хөх бич		Хөхөгчин тахиа		Улаан нохой		Улаагчин гахай		Шар хулгана		Шарагчин үхэр		Цагаан бар		Цагаагчин туулай		Хар луу	
Төрсөн мэнгэ	3		2		1		9		8		7		6		5		4		3	
Буусан мэнгэ	3		1		6		6		1		8		1		8		2		3	
Хүйс	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм
Суудал	гал	ус	хий	уул	мод	мод	уул	хий	ус	гал	огторгуй	шороо	төмөр	төмөр	шороо	огторгуй	гал	ус	хий	уул
Амь	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	Х	О	ООО	О	ОХ	Х	ООО	ООО	ООО
Бие	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	Х	Х	О	ООО	ХХ	ХХ	ХХ	ХХ	ОО	ООО
Эрхтэн	ООО	ООО	ХХ	ХХ	ХХ	ХХ	ОХ	ООО	ХХ	Х	ООО	ОО	ООО	ОХ	ООО	ООО	ОО	ООО	ООО	ООО
Хийморь	ХХ	ХХ	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	ООО	ХХ	ХХ	Х	Х	ООО	ООО	ОО	ОО	ХХ	ХХ	О	О
Сүлд	ХХ	О	ООО	ООО	ООО	ООО	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	О	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	ООО	ХХ	ХХ
Урвасан жил	гал тахиа	шороо могой	гал гахай	төмөр гахай	гал тахиа	ус тахиа	гал могой	мод тахиа	гал гахай	гал үхэр	гал тахиа	шороо үхэр	гал туулай	төмөр гахай	гал гахай	ус хонь	гал тахиа	мод хонь	гал гахай	гал туулай

Төөргийн чулууны үр, түүний арга засал (1-100 насныхан)

Төрсөн он	1953		1954		1955		1956		1957		1958		1959		1960		1961		1962	
Билгийн нас	63		62		61		60		59		58		57		56		55		54	
Төрсөн жил	Харагчин могой		Хөх морь		Хөхөгчин хонь		Улаан бич		Улаагчин тахиа		шар нохой		Шарагчин гахай		Цагаан хулгана		Цагаагчин үхэр		Хар бар	
Төрсөн мэнгэ	2		1		9		8		7		6		5		4		3		2	
Буусан мэнгэ	5		5		1		1		4		2		4		2		3		1	
Хүйс	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм
Суудал	мод	мод	уул	хий	ус	гал	огторгуй	шороо	төмөр	төмөр	шороо	огторгуй	гал	ус	хий	уул	мод	мод	уул	хий
Амь	ОО	Х	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	Х	ОО	ХХ	Х	ООО	О	ОХ
Бие	ООО	ООО	ООО	ООО	ОХ	ОО	ОХ	Х	ОО	ОО	О	О	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО
Эрхтэн	ОО	ХХ	Х	ХХ	ХХ	ХХ	ОХ	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ОХ	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО
Хийморь	ООО	ООО	ООО	ООО	ХХ	ХХ	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	ООО	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	ООО	ОО	ОО
Сүлд	Х	ХХ	ХХ	ХХ	ХХ	О	ООО	ООО	ООО	ООО	Х	ХХ	О	ООО	ОО	ХХ	ХХ	ХХ	ООО	ООО
Урвасан жил	гал туулай	шороо үхэр	гал могой	төмөр үхэр	гал тахиа	ус могой	гал гахай	мод гахай	гал тахиа	гал тахиа	гал могой	шороо тахиа	гал гахай	төмөр үхэр	гал тахиа	ус үхэр	гал туулай	мод гахай	гал гахай	гал хонь

Төрсөн он	1963		1964		1965		1966		1967		1968		1969		1970		1971		1972	
Билгийн нас	53		52		51		50		49		48		47		46		45		44	
Төрсөн жил	Харагчин туулай		Хөх луу		Хөхөгчин могой		Улаан морь		Улаагчин хонь		Шар бич		Шарагчин тахиа		Цагаан нохой		Цагаагчин гахай		Хар хулгана	
Төрсөн мэнгэ	1		9		8		7		6		5		4		3		2		1	
Буусан мэнгэ	6		6		1		8		1		8		2		3		5		5	
Хүйс	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм
Суудал	ус	гал	огторгуй	шороо	төмөр	төмөр	шороо	огторгуй	гал	ус	хий	уул	мод	мод	уул	хий	ус	гал	огторгуй	шороо
Амь	ХХ	ХХ	ООО	ОО	ООО	ОХ	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ОХ	ХХ	Х	ХХ
Бие	ОХ	ХХ	ОХ	ООО	О	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	О	ООО	ОХ	ООО	ООО	ООО	ООО	ХХ	О
Эрхтэн	ХХ	ОХ	ХХ	ХХ	ХХ	ХХ	ОХ	ООО	ОХ	ХХ	ООО	ОО	ООО	ОХ	ООО	ООО	ООО	ООО	ОХ	ОХ
Хийморь	ХХ	ХХ	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	ООО	ХХ	ХХ	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	ООО	ХХ	ХХ	ООО	ООО
Сүлд	ООО	ООО	ХХ	ХХ	ООО	ОХ	ХХ	ХХ	ХХ	О	ООО	ООО	ООО	ООО	Х	ХХ	ХХ	ОХ	О	ХХ
Урвасан жил	гал тахиа	шороо хонь	гал гахай	төмөр туулай	гал туулай	ус үхэр	гал могой	мод үхэр	гал тахиа	гал могой	гал гахай	шороо гахай	гал тахиа	төмөр тахиа	гал могой	ус тахиа	гал гахай	мод үхэр	гал тахиа	гал үхэр

Төөргийн чулууны үр, түүний арга засал (1-100 насныхан)

Төрсөн он	1973		1974		1975		1976		1977		1978		1979		1980		1981		1982	
Билгийн нас	43		42		41		40		39		38		37		36		35		34	
Төрсөн жил	Харагчин үхэр		Хөх бар		Хөхөгчин туулай		Улаан луу		Улаагчин могой		Шар морь		Шарагчин хонь		Цагаан бич		Цагаагчин тахиа		Хар нохой	
Төрсөн мэнгэ	9		8		7		6		5		4		3		2		1		9	
Буусан мэнгэ	1		1		4		2		4		2		3		1		6		6	
Хүйс	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм
Суудал	төмөр	төмөр	шороо	огторгуй	гал	ус	хий	уул	мод	мод	уул	хий	ус	гал	огторгуй	шороо	төмөр	төмөр	шороо	огторгуй
Амь	О	ООО	О	ОХ	ХХ	ОО	ООО	ООО	ООО	ОО	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО
Бие	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	О	ОХ	ХХ	ХХ	ХХ	ХХ	ХХ	ХХ	ХХ	ООО	ООО	ХХ
Эрхтэн	ООО	ООО	ХХ	ХХ	ХХ	ОХ	ХХ	ОХ	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ОО	ООО	ООО	ООО
Хийморь	ООО	ООО	ОО	ОО	ХХ	ХХ	О	О	ООО	ООО	ООО	ООО	ХХ	ХХ	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	ООО
Сүлд	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	ООО	ХХ	ХХ	Х	ХХ	ХХ	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	ООО	ХХ	ХХ	ООО
Урвасан жил	гал туулай	шороо гахай	гал гахай	төмөр хонь	гал тахиа	ус хонь	гал гахай	мод туулай	гал туулай	гал үхэр	гал могой	шороо үхэр	гал тахиа	төмөр могой	гал гахай	ус гахай	гал тахиа	мод тахиа	гал могой	гал тахиа

Төрсөн он	1983		1984		1985		1986		1987		1988		1989		1990		1991		1992	
Билгийн нас	33		32		31		30		29		28		27		26		25		24	
Төрсөн жил	Харагчин гахай		Хөх хулгана		Хөхөгчин үхэр		Улаан бар		Улаагчин туулай		Шар луу		Шарагчин могой		Цагаан морь		Цагаагчин хонь		Хар бич	
Төрсөн мэнгэ	8		7		6		5		4		3		2		1		9		8	
Буусан мэнгэ	1		8		1		8		2		3		5		5		1		1	
Хүйс	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм
Суудал	гал	ус	хий	уул	мод	мод	уул	хий	ус	гал	огторгуй	шороо	төмөр	төмөр	шороо	огторгуй	гал	ус	хий	уул
Амь	ООО	ОО	ООО	О	Х	ООО	О	ОХ	ОО	ООО	ООО	ООО	О	ХХ	ХХ	ХХ	ООО	ООО	ооо	ооо
Бие	ООО	ООО	ООО	ООО	ОО	ООО	ОХ	ОО	ХХ	ХХ	О	О	ХХ	ХХ	ООО	ОО	ООО	ООО	ооо	ооо
Эрхтэн	ООО	ООО	ХХ	ХХ	ХХ	ХХ	ОХ	ООО	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	О	ООО	ООО	О	ООО	ооо	ооо
Хийморь	ХХ	ХХ	Х	ХХ	ООО	ООО	ОО	ОО	ХХ	ХХ	О	О	ООО	ООО	ООО	ООО	ХХ	ХХ	хх	хх
Сүлд	ООО	ООО	ООО	ООО	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	ООО	ХХ	ХХ	О	ОХ	ХХ	ХХ	ХХ	О	ооо	ооо
Урвасан жил	гал гахай	шороо үхэр	гал тахиа	төмөр үхэр	гал туулай	ус гахай	гал гахай	мод хонь	гал тахиа	гал хонь	гал гахай	шороо туулай	гал туулай	төмөр үхэр	гал могой	ус үхэр	гал тахиа	мод могой	гал гахай	гал гахай

Төөргийн чулууны үр, түүний арга засал (1-100 насныхан)

Төрсөн он	1993		1994		1995		1996		1997		1998		1999		2000		2001		2002	
Билгийн нас	23		22		21		20		19		18		17		16		15		14	
Төрсөн жил	Харагчин тахиа		Хөх нохой		Хөхөгчин гахай		Улаан хулгана		Улаагчин үхэр		Шар бар		Шарагчин туулай		Цагаан луу		Цагаагчин могой		Хар морь	
Төрсөн мэнгэ	7		6		5		4		3		2		1		9		8		7	
Буусан мэнгэ	4		2		4		2		3		1		6		6		1		8	
Хүйс	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм
Суудал	мод	мод	уул	хий	ус	гал	огторгуй	шороо	төмөр	төмөр	шороо	огторгуй	гал	ус	хий	уул	мод	мод	уул	хий
Амь	ООО	ООО	ООО	ООО	ОО	ОХ	ОО	ХХ	О	ООО	О	ОХ	ХХ	О	ООО	ОО	ООО	О	ХХ	ХХ
Бие	ООО	ООО	ХХ	ООО	Х	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ОО	ООО	ХХ	ХХ
Эрхтэн	ООО	ОХ	ОХ	ОХ	ХХ	ХХ	ХХ	ОХ	ОО	ОО	ООО	ОО	ООО	ОО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО
Хийморь	ООО	ООО	ООО	О	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	ООО	ОО	ОО	ХХ	ХХ	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	ООО
Сүлд	ООО	ООО	Х	ХХ	ХХ	ОХ	ОО	ХХ	ХХ	ХХ	ООО	ООО	ОХ	ООО	ХХ	ХХ	О	ХХ	ХХ	ХХ
Урвасан жил	гал тахиа	шороо тахиа	гал могой	төмөр тахиа	гал гахай	ус үхэр	гал тахиа	мод үхэр	гал туулай	гал гахай	гал гахай	шороо хонь	гал тахиа	төмөр хонь	гал гахай	ус туулай	гал туулай	мод үхэр	гал могой	гал үхэр

Төрсөн он	2003		2004		2005		2006		2007		2008		2009		2010		2011		2012	
Билгийн нас	13		12		11		10		9		8		7		6		5		4	
Төрсөн жил	Харагчин хонь		Хөх бич		Хөхөгчин тахиа		Улаан нохой		Улаагчин гахай		Шар хулгана		Шарагчин үхэр		Цагаан бар		Цагаагчин туулай		Хар луу	
Төрсөн мэнгэ	6		5		4		3		2		1		9		8		7		6	
Буусан мэнгэ	1		8		2		3		5		5		1		1		4		2	
Хүйс	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм
Суудал	ус	гал	огторгуй	шороо	төмөр	төмөр	шороо	огторгуй	гал	ус	хий	уул	мод	мод	уул	хий	ус	гал	огторгуй	шороо
Амь	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ХХ	Х	ХХ	Х	ООО	О	ОХ	ХХ	Х	ООО	ООО
Бие	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО	ХХ	ХХ	ОО	ООО	ХХ	ХХ	ХХ	ХХ	ОО	ООО
Эрхтэн	ООО	ООО	ХХ	ХХ	ХХ	Х	ХХ	ОХ	ХХ	ХХ	ООО	ООО	О	ХХ	ООО	ООО	ООО	ООО	ООО	ООО
Хийморь	ХХ	ХХ	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	ООО	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	ООО	ОО	ОО	ХХ	ХХ	О	О
Сүлд	ХХ	О	ООО	ООО	ООО	ООО	Х	ХХ	ООО	ОХ	О	ХХ	ХХ	ХХ	ООО	ООО	ООО	ООО	ХХ	ХХ
Урвасан жил	гал тахиа	шороо могой	гал гахай	төмөр гахай	гал тахиа	ус тахиа	гал могой	мод тахиа	гал гахай	гал үхэр	гал тахиа	шороо үхэр	гал туулай	төмөр гахай	гал гахай	ус хонь	гал тахиа	мод хонь	гал гахай	гал туулай

Төөргийн чулууны үр, түүний арга засал (1-100 насныхан)

Төрсөн он	2013		2014		2015	
Билгийн нас	3		2		1	
Төрсөн жил	Харагчин могой		Хөх морь		Хөхөгчин хонь	
Төрсөн мэнгэ	5		4		3	
Буусан мэнгэ	4		2		3	
Хүйс	эр	эм	эр	эм	эр	эм
Суудал	төмөр	төмөр	шороо	огторгуй	гал	ус
Амь	ООО	ООО	ХХ	ХХ	ХХ	ХХ
Бие	ООО	ООО	ООО	ООО	Х	ООО
Эрхтэн	ООО	ООО	ОХ	ХХ	ХХ	ООО
Хийморь	ООО	ОХ	ООО	ООО	ОХ	О
Сүлд	ООО	ОХ	ХХ	ХХ	ХХ	ХХ
Урвасан жил	гал туулай	шороо үхэр	гал могой	төмөр үхэр	гал тахиа	ус могой

ЧУЛУУНЫ ҮР БУЮУ ОНЬСЫГ ТАЙЛАГЧ ТҮЛХҮҮР

I. АМИНЫ ЧУЛУУ

Хоёр буюу гурван цагаан (000) бууваас амины найлзуур модонд насны үр боловсрон дэлгэрч насан буян батдан ивээнэ. Насны шүтээн төмөр мэт бат бөгөөд амь нас бусдад үл булаагдах сайн.

Нэг цагаан (0) бууваас ивээгч тэнгэр араас тэтгэж, цогийн наран урдаас ургана. Саад барцад гаравч гэм үл болно. Өөрийгөө барин хянуур бай. Батдуулахын тухайд бурханд "Түй" өргөж, "Данраг" уншуул.

Цагаан хар (0Х) хослон бууваас тэтгэгч тэнгэр, хорлогч зэтгэр хоёул булаалдана. Ялах ялагдахын магадлагаа үгүй. Айж цочих, гэнэт гарз гарах гэмтэй тул "Гомбо, Чойжал Лхамын ганшаг" уншуулж засал хийлгэвээс гэмгүй.

Нэг хар (Х) бууваас үхэрийн гэм, саад тотгор босох, амины найлзуур модон үндэс, навчнаасаа хатахын гэмтэй. Иймд хурлын газар "Цэнд","Цэвээн" айлтгаж "Гомбын ганшаг" хуруулваас тустай.

Хоёр хар (ХХ) бууваас амины гол мод хугарч, насны хүрдэн эвдрэхийн гэмтэй. Гэнэт сэтгэл амгалангүй болж зүүд нойр муудах нигууртай. Хутга мэс болон төрийн зарлиг цаазаас сэргийлэн болгоомжил. "Юм", "Цэнд" айлтгаж, "Цэвэгмэдийн чого" хуруул. Амьтны амь үл тасалж, аварч үйлд. Наадам цэнгээнийг огоорч, шөнө харанхуйд явахыг цээрлэ.

II. БИЕИЙН ЧУЛУУ

Хоёр буюу гурван цагаан (000) бууваас биеийн шүтээн хүрдэн үл эвдрэх, биед өвчин, сэтгэлд гаслан үгүй амгалантай оршино.

Нэг цагаан (0) бууваас бие болоод сэтгэлд өвчин зовлон үл гарах сайн авч бузар буртаг, ариун бус зүйл, өшөө хорслоос зайлан сэргийлэх хэрэгтэй. Бурханд "Түй" өргөж, "Сахиусны ганс" уншуулваас батдана.

Цагаан хар (0Х) хослон бууваас биеийн тэнхээ тамир доройтож, сэтгэл тавгүйтэн зүүд нойр муудна. Бурханд "Түй" өргөж, лам багшид өргөл хүндлэл үйлд. Хүүхэд ядууст өглөг буян хийвээс сайн болъюу.

Нэг хар (Х) бууваас биед өвчин ирж, оюун санаа тавгүйтэнэ. Насны тоогоор "Сац талби", адистад орон хийдийн шүтээнд тахил өргөж, "Сундуй" уншуул.

Хоёр хар (ХХ) бууваас биед өвчин, сэтгэлд гаслан ирэх ба гэнэт бэртэж гэмтэхийн нигуур буй. Эмч маарамба, эм танг шүтэх хэрэгтэй. Шүтээнд зул өргөж, "Сац" олонтаа талби. "Нүгнай", "Гүн аа" хуруулж, ужиг өвчтэй болон хэрүүл маргааны газар явахыг цээрлэвээс тустай.

III. ЭРХ БАЯЛГИЙН ЧУЛУУ

Хоёр буюу гурван цагаан (000) идээ унд, эд баялаг хуран чуулна. Худалдаа наймаа хийвээс ашиг орлоготой, гарзгүй. Эрх хүчин нэмэгдэж хүн хийгээд малд тайван сайн байна.

Нэг цагаан (0) бууваас санасан хэрэг саатаж, орлого гарлага тэнцэх тул арвидуулан бататгахын тухайд "Намсрайн ганшаг" уншуулж буян хишгийн даллага авбаас тустай.

Цагаан хар (0Х) хослон бууваас идээ эдлэл тогтох нь батгүй агаад хааяа дүүрч хааяа хоосорно. Нялхас, хүүхэд, үгээгүй ядууст өглөг өгч үйлд. Бурхан шүтээнд "Балин" өргөж, "Жарз" хийх хэрэгтэй.

Нэг хар (Х) бууваас эрх хүчин хумигдан, эд малын гарз гарах нигууртай. Анд нөхдийн санаа урваж, худалдаа наймаа ашиг олз хомсдоно. Иймд "Намсрайн даллага" авч мал сэтэрлэ. Дөрвөн гэлэн ламд гүнцэг болон, хурлын шүтээнд тахил өргөж засал хийлгэ.

Хоёр хар (ХХ) бууваас эрх хүчний гуу сан ёроолоосоо цоорч, хураасан эд агуурс барагдахын гэмтэй. Эд малд гарз гараад, худалдаа наймаанд ашиг орлого багасах тул эдийн даллага дуудуулж шүтээнд балин өргө. "Жаши", "Норжүнма" уншуул. Буянд шамдаж өглөг үйлдвээс засал болъюу.

IV. ХИЙМОРИЙН ЧУЛУУ

Хоёр буюу гурван цагаан (000) бууваас хийморь лүндаа бадран дэлгэрч санасан хэрэг сэтгэлчлэн бүтнэ. Муу зүгийн түйтгэрийг ялан дийлнэ.

Нэг цагаан (0) бууваас гадна дотны хүмүүс асран тусалж, хичээвээс хэрэг бүтнэ. Гэнэтийн саад тотгор гарч болзошгүй ч түргэнээ амирлана. Бататгахын тухайд сан олонтаа тавиулж, хийморь дарцаг хийсгэ.

Цагаан хар (0Х) хослон бууваас дээрээс асран өргөвч доороос уурлан түлхэнэ. Зарим үед идээ унд хор болж, зарим үед амраг садны сэтгэл урвах болзоогүй. Хэл амны ном "Зүгдор", "Хамчу нагба", "Цагаан шүхэрт" уншуул.

Нэг хар (Х) бууваас хэл аманд ороцолдохын гэмтэй. Гадна үүд бат бэх ч доторхи хүмүүн бээр хууран мэхэлнэ. Засахын тулд "Дову чи", "Зүгдор гар наг" уншуул. Сан олонтоо уншуул.

Хоёр хар (ХХ) бууваас Буян хишгийн хүрээ эвдэрч, ойрын хүмүүн холдон дайсагнаж, их хүмүүн хийгээд төрийн цааз зарлиг ирэхийн гэм буй. Ач тусын хариу үл ирж, гэм үгүй ч гэмд өртөгдөж, гадны хор хөнөөл ирэх нигууртай. Засахын тухайд "Зүгдор", "Доржнамжом", "Чогжү мүнсэн", "Лхамын ганшаг" хуруул. Хэл амны ном олонтаа уншуулж "Хийморийн дарцаг" хийсгэ.

V. СҮЛДНИЙ ЧУЛУУ

Хоёр буюу гурван цагаан (000) бууваас рашаанаар дүүрсэн амь бумба мэт сүлдэн үл хагацах сайн болой.

Нэг цагаан (0) бууваас сайн нөхрийг шүтэх адил гадна дотны хөнөөл үгүй амгалантай оршино.

Цагаан хар (0Х) хослон бууваас сайн муугийн магадлагаа үгүй бөгөөд насан сүлд тэнэх болзошгүй тул шүтээн зул өргө.

Нэг хар (Х) бууваас насны шүтээн сүлд доройтох тул "Жаши", "Цэнд" хуруулж "Насан бүтээл" хийлгэвээс ач тустай.

Хоёр хар (ХХ) бууваас сүлд холдон зайлж, насанд хорлол учрах, зүүд нойр эвгүйтэн муудах тул "Сүлд дуудуулж", "Цэвэгмэдийн чого" хуруул. "Чойжонгуудын ганшаг" уншуулж засах хэрэгтэй.

Санамж: Амь, Бие, Эрх баялаг, Хийморь, Сүлдний чулуу бүгд цагаан буух аваас сахигч тэнгэр сахиус холдон зайлж үл баясах тул "Говийн лха", "Далха" тахиж "Чойжонгийн ганс" хуруулна. Бүгд хар бууваас амь нас, ажил үйлс, аливаа бүгдэд муу тул тус тусын үүрэм засалд цаг алдалгүй шамдаж, буяны үйлд хичээх хэрэгтэй.

Мөн түүнчлэн эр хүнийг амины чулуугаар, эм хүнийг эрх баялгын чулуугаар, хүүхэд нялхсыг биеийн чулуугаар, лам хуврага хийгээд их хүмүүнийг хийморийн чулуугаар голлож үздэг тул өөрсдөө нягтлана уу. Амины болон сүлдний чулуугаар амь насанд хорлол, хөнөөл буй үгүй эсэхийг шинжинэ. Эрх баялагийн чулуугаар эрх мэдэл хийгээд эд баялаг арвидах хомсдохыг шинжинэ. Биеийн чулуугаар өвчин эмгэг тусах эсэх, биеийн эрүүл мэндийг шинжинэ. Хийморийн чулуугаар санаж хүссэн хэрэг ямар мэт бүтэх эсэх, хийморь лүндаа ямар байгааг үзэж нягталдаг. Ерөнхийдөө ихэнх чулуу цагаан байгаад ганцын төдий хар байх аваас сайн хэмээдэг.

ЕСӨН НҮД

Насны буюу жилийн есөн нүд нь 9, 18, 27, 36, 45, 54, 63, 72, 81 насанд тохиох бөгөөд 9, 81-ний есөн нүд нь аминд хорлолтой тул "Цэдүв" хуруулж "Чивэл" хийлгэ.

18, 36, 54-ний есөн нүд нь эд хөрөнгө, мал адгууст хорлолтой тул сан олонтаа тавиулж, балин тахил өргөж хишгийн даллага авахуул.

27,72-ний есөн нүд нь ад зэтгэрийн хөнөөлтэй тул сахиусныхаа "Ганс" уншуул.

45, 63-ны есөн нүд нь зовлон гаслан авчрах тул "Цагаан шүхэрт" нас тоолон уншуулж "Сундуй" айлтга. Ер нь есөн нүд ээлсэн эр, эм аливаа хүмүүн "Есөн нүдний засал" хийлгэж насны тоогоор "Сац" талбиж, "Жавтүй" хүртэх хэрэгтэй тул эд бүгдийг гүйцээвээс тустай.

УРВАСАН ЖИЛИЙН ҮР

Хар зурхайд дотоод жил буюу урвасан жил хэмээхийг бодож олоод түүгээр жилийн нурууг шинждэг нэгэн арга байдаг.
Эр жилд төрсөн (хулгана, бар, луу, морь, бич, нохой) хүний урвасан жил нохой гарваас "Огторгуйн үүд нээгдэх", гахай гарваас "газрын үүд нээгдэх", хулгана гарваас " Яс тасрахын үүд нээгдэх", тахиа гарваас "Салж сарнихын үүд нээгдэх", Үхэр гарвал " Үгүйрэлийн үүд нээгдэх", Бар гарвал олзны үүд нээгдэнэ хэмээнэ.
Харин эм жилд төрсөн хүний урвасан жил Луу гарвал "Огторгуй үүд", Могой гарвал "Газрын үүд", Морь гарвал "Яс тасрахын үүд" нээгдэнэ гэж тус тус үзнэ. Эдгээрээс бусад жил гарвал гэмгүй, жирийн хэмээнэ.

Огторгуйн үүд нээгдэхэд: Уул хад, газарт авирах, байшингийн дээвэр туургад мацахыг цээрлэ. Шинээр нохой бүү ав. Андгай тангараг үүсгэх, ам алдахаас сэргийл. Тархи толгойны өвчин хөдөлж болзошгүй. "Намхай нинбуу", "Лхамын ганшаг", "Цагаан шүхэрт" уншуулж засна.

Газрын үүд нээгдэхэд: Лус савдагийн хорлол болон элдэв хүмүүний хөнөөл ирэх тул газар шороо хөндөх, малтах, мод чулуу хугалж булгалах ба ус лусыг бохирлон бузарлахыг тэвчиж цээрлэ. Засал нь " Са и нинбу", "Найман гэгээн", "Лү бангон", "Лүнбүн гарбо" зэргийг уншуул.

Яс тасрахын үүд нээгдэхэд: Элдвийн хэрүүл тэмцэл, хэл ам, хулгай дээрэм ирэх тул зарга тэмцэл хийх, мөрий тавих, мөрийтэй тоглох, аливаа хэрүүл маргааныг тэвчвээс зохино. Засал нь: "Дорждэрэм", " Хамчиннагбо", "Чойжилын ганшаг" хуруулж "Дүгжү" хийлгэ.

Салж сарнихын үүд нээгдэхэд: Найз нөхөд ойр дотны хүнээс салж эвдрэлцэхийн гэмтэй тул хэрүүл тэмцэл, өш хонзонгоос зайлж сэргийл. "Дашдондүв", "Доржнамжом", "Сэр-Од" уншуул.

Үгүйрлийн үүд нээгдэхэд: Сэтгэл санаа амгалангүй болж, идээ ундаа эд малын гарз ирэх тул алс хол жуулчлан явах, худалдаа наймаа хийхийг тэвчвээс зохино. Засал нь "Сац" 1000 талби, "Дашзэвэг", "Дашдондүв" айлтга.

Олзны үүд нээгдэхэд: Хүсэж сэдсэн ажил үйлс түргэнээ бүтэж, ашиг олз олох сайн хэмээнэ.

БУУСАН МЭНГЭНИЙ ҮР

Нэг цагаан: Ариун бус бузар болон хурим, оршуулгын идээнээс сэргийл. Тархи толгой нүдний өвчин тусаж магадгүй. Хэрүүл тэмцэл, өс хонзонгоос хол явж ариун сан олонтаа тавиул. "Алтангэрэл", " Лангар шэгвий до" уншуулж "Түй" өргө.

Хоёр хар: Өвчин хийгээд гэнэтийн осол ирж болзошгүй. Хар өнгийн эд бусдаас авах ба харанхуй шөнөөр явахаас сэргийл. "Шийрав нинбу", "Чогжү мүсэл", "Догсүн" уншуул.

Гурван хөх: Газар шороо болон дарханы үйл үйлдэхийг тэвч. Хавдар, бөөрний өвчин хүрч болзошгүй. "Шийрав нинбу", "Зүгдор" уншуул. "Сац" тавьж, суврага сэргээ.

Дөрвөн ногоон: Лус савдагийн болон хэл амны хорлол ирэх гэмтэй. Уул ус хөндөх, андгай тангараг тавихыг цээрлэ. "Лүнбумгарав", "Лусын сан" уншуулж "Усан балин" өргө.

Таван шар: Банди бөөгийн эд хэрэглэл, өвчин халдвараас сэргийл. "Жаши", "Жамбалцанжод", "До палчин" уншуулж засал хийлгэ.

Зургаан цагаан: Хурим найрын идээ, ариун бусаас бузартана. "До палчин", "Нити", "Ханд дивсэл" уншуул. Нялхас хүүхдэд өглөг өг.

Долоон улаан: Яр шарх болон цусны өвчнөөс сэргийл. Улай үзэх, ууланд авирахыг цээрлэ. "Шийрав нинбу" уншиж, "Золиг гарга". Дөрвөн гэлэнд гүнцэг өргө.

Найман цагаан: Тэнгэр сахиус хилэгнэх гэмтэй. Ариун бус зүйл, бэлбэсний идээ унд, үхээрийн газраас болгоомжилж, бурхан сахиусаа тахиж, лам багшийг шүтэж өргөн хүндэл.

Есөн улаан: Улайны газар явах, бусдын хуучин эд хувцас авахыг цээрлэ. Эд малын гарз гарах магадгүй тул "Алтангэрэлийн даллага" ав, "Норжмаагийн сүн" уншуулж сүлд дуудуул.

ХҮНИЙ ҮС АВАХАД САЙН, МУУ ӨДРҮҮД

Өдөр	Учир буюу үр	Өдөр	Учир буюу үр	Өдөр	Учир буюу үр
1	Нас ахар болно	11	Эрхтэн хурц болно	21	Өвчин ирнэ
2	Хэл, ам, хэрүүл, тэмцэл ирнэ	12	Өвчин эмгэг ирнэ	22	Идээ ундаа элбэг олдоно
3	Эд малаар баялаг төгөлдөр болно	13	Жаргал ирнэ	23	Эд эдлэл, идээ ундаа олдоно
4	Бие эрхтний хүч сайжирна	14	Эд, мал арвидана	24	Өвчин эмгэг ирнэ
5	Эд, мал арвижна	15	Өлзийтэй сайн	25	Нүд бүрэлзэн улцайна
6	Өнгө зүс сайжирна	16	Өвчин ирнэ	26	Жаргал үргэлжид ирнэ
7	Хэл, ам, хэрүүл, тэмцэл ирнэ	17	Өнгө зүс доройтно	27	Өлзийтэй сайн
8	Нас уртасна	18	Эд малын гарлагатай	28	Хэрүүл тэмцэл ирнэ
9	Өвчин өчүүхэн ирнэ	19	Сайн нөхөртэй нөхөрлөнө	29	Сүлд тэнэж одно
10	Эрч хүч ихэснэ	20	Өлсөж ундаасна	30	Эрлэг лугаа учирна муу

Хүний үс авах өдөр нь сар бүрийн 3, 4, 5, 6, 8, 10, 11, 13, 14, 15, 19, 22, 23, 26, 27-ны өдрүүдэд сайн, үлдсэн өдрүүдэд муу.